

12

ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ЦАГААН ЭЛС-ХИ II ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-НИЙ
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ

ГЭРЭЭ

2009 оны 04 дугаар сарын 21-ний өдөр

| | |
|--|-----------|
| БРОИХНИЙ ЗҮЙЛ..... | 5 |
| НӨГ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨЛӨӨЛӨГЧИД..... | 5 |
| 1.1. Төлөөлөгч томилгох..... | 5 |
| 1.2. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ХЯНАН ШАЛГАХ ЭРХ..... | 5 |
| ХОЁР ДУГААР ЗҮЙЛ. ТОДОРХОЙЛОЛТУУД..... | 5 |
| 2.1. НЭР ТОМЬЁО..... | 5 |
| ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ..... | 9 |
| 3.1. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЭРХ..... | 9 |
| 3.2. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮҮРЭГ..... | 10 |
| 3.3. ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ..... | 10 |
| 3.4. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮҮРЭГ..... | 11 |
| ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАРДАЛ БОЛОН ӨРТӨГ НӨХӨЛГӨӨ | 12 |
| ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУГАЦАА..... | 13 |
| 5.1. Хайгуулын хугацаа..... | 13 |
| 5.2. Хайгуулын хугацааг сунгах..... | 13 |
| 5.3. НЭЭЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ..... | 14 |
| 5.4. ҮР АШИГТАЙ НЭЭЛТ..... | 14 |
| 5.5. ҮР АШИГТАЙ НЭЭЛТ, ТУРШИЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦАА..... | 14 |
| 5.6. ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙГ ХЯНАХ..... | 15 |
| 5.7. ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ..... | 15 |
| ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ХАЙГУУЛЫН АЖИЛ..... | 15 |
| 6.1. ЗААВАЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ..... | 15 |
| 6.2. ӨРӨМДӨХ АРГУУД..... | 15 |
| 6.3. ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР БА ТӨСӨВ..... | 16 |
| ДОЛДУГААР ЗҮЙЛ. ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.1. ГЭРЭЭ ЁСООР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.2. ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ..... | 17 |
| НАЙМДУГААР ЗҮЙЛ. РОЯЛТИ БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ..... | 17 |
| 8.1. РОЯЛТИ..... | 17 |
| 8.2. ТҮҮХИЙ ТОС БОРЛУУЛАХ..... | 17 |
| 8.3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ..... | 17 |
| 8.4. ГЭРЭЭТ ТОСНЫ ҮНЭЛГЭЭ..... | 18 |
| 8.5. БОРЛУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО..... | 19 |
| 8.6. ДУТАЛТ БА ХЭТРҮҮЛЭЛТ..... | 19 |
| ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ..... | 19 |
| АРАВДУГААР ЗҮЙЛ. УРАМШУУЛАЛ, ШИМТГЭЛ БОЛОН БУСАД ТӨЛБӨРҮҮД..... | 19 |
| 10.1. УРАМШУУЛАЛ..... | 19 |
| 10.2. СУРГАЛТЫН УРАМШУУЛАЛ..... | 20 |
| 10.3. ТАЛБАЙН ДЭНЧИН..... | 20 |
| 10.4. ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ..... | 21 |
| 10.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ..... | 21 |
| АРВАН НӨГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЭМЖИЛТ..... | 22 |
| 11.1. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ХЭМЖИЛТ..... | 22 |
| 11.2. ХЭМЖИЛТИЙГ ЗАЛРУУЛАХ..... | 22 |
| 11.3. ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ..... | 22 |
| АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТЕХНИКНИЙ МЭДЭЭЛЭЛ..... | 23 |

| | | |
|--|--|----|
| 121 | ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨХ | 23 |
| 122 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ | 23 |
| 123 | ГЕОФИЗИКИЙН МЭДЭЭЛЭЛ | 23 |
| 124 | ХАЙГУУЛ, ПЕТРОФИЗИК, ЛАБОРАТОРИЙН СУДАЛГАА БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУРШИЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ | 23 |
| 125 | БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ, ГАЗРЫН ТОС ТУХАЙ ТАЙЛАНГУУД | 23 |
| 126 | ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ | 23 |
| 127 | АВТОМАШИНЫ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ | 24 |
| 128 | ХАМТАРСАН ХОРОО | 24 |
| 129 | БУСАД АШИГТ МЭЛТМАЛ | 24 |
| 1210 | НУУЦЛАЛ | 24 |
| АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ | | 24 |
| 131 | НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ | 24 |
| 132 | БҮРТГЭЛ ТООЦООНЫ ТАЙЛАН | 25 |
| 133 | САНХҮҮГИЙН ХЯНАЛТ | 25 |
| АРВАН ДОРОВДУГЭЭР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАЛЦАА | | 25 |
| 141 | ЕРӨНХИЙ ТУСЛАЛЦАА | 25 |
| 142 | БУСАД ТУСЛАЛЦАА | 25 |
| 143 | ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 26 |
| 144 | ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 26 |
| АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ӨМЧИЙГ АШИГЛАХ, ӨМЧЛӨХ, ЭРХ БА ӨМЧ ШИЛЖҮҮЛЭХ | | 26 |
| 151 | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖ | 26 |
| 152 | ГАЗРЫН ТОСЫГ ЭЗЭМШИХ | 26 |
| 153 | ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ | 26 |
| АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР, ХУРААМЖ БОЛОН ТӨЛБӨР | | 26 |
| АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ. ВАЛЮТ СОЛИЛЦООНЫ ЭРХ | | 27 |
| 171 | ГАДААД ВАЛЮТ | 27 |
| 172 | ГАДААДЫН БАНКИН ДАХЬ ДАНС | 27 |
| 173 | ВАЛЮТ СОЛИХ ЭРХ | 27 |
| 174 | ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР | 27 |
| АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСАД | | 27 |
| 181 | МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ | 27 |
| АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ОНЦ БАЙДАЛ | | 28 |
| 191 | ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БОЛОХ ОНЦ БАЙДАЛ | 28 |
| 192 | ОНЦ БАЙДАЛ | 28 |
| ХОРЬДУГААР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ | | 29 |
| ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ | | 29 |
| ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА | | 30 |
| ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ | | 31 |
| ХОРИН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДААТГАЛ | | 32 |
| ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗААЛТ | | 32 |
| 25.1 | ХАВСРАЛТУУД | 32 |
| 25.2 | ХУУЛЬ | 32 |
| 25.3 | САЙН САЛМ | 32 |
| 25.4 | ГЭРЭЭНИЙ ХЭЛ | 32 |

| | |
|-------------------|----|
| ОРУУЛАХ..... | 33 |
| ХАВСРАЛТ "А"..... | 34 |
| ХАВСРАЛТ "Б"..... | 35 |
| ХАВСРАЛТ "В"..... | 36 |
| ХАВСРАЛТ "Г"..... | 37 |

Энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээг нэг талаас Газрын тосны газар /цаашид ГТГ гэгддэгөө талаас "DWM Петролеум AG" /цаашид Гэрээлэгч гэнэ/-ийн хооронд /хамтад нь Тагруд гэнэ/ 2009 оны 04 дугаар сарын 21-ний өдөр байгуулав.

ЕРӨНХНИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллага болох ГТГ болон Гэрээлэгч нарын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хавсралтаар тодорхойлсон хайгуулын зорилдлаар ашиглах газрын тосны гэрээт талбайд Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эдэлнэ.

НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨЛӨӨЛӨГЧИД

1.1. ТӨЛӨӨЛӨГЧ ТОМИЛОХ

- а) Монгол Улсын Засгийн газар нь энэхүү Гэрээний дагуу Засгийн газрын төлөөлөгчөөр ГТГ-ын даргыг болон түүний эрх олгосон этгээдийг томилж байна.
- б) Гэрээлэгч энэхүү Гэрээний дагуу "DWM Петролеум AG" өөрийн төлөөлөгч (Гэрээлэгчийн төлөөлөгч)-өөр Александр Беккер болон түүний эрх олгосон этгээдийг томилж байна.
- в) Засгийн газрын төлөөлөгч болон Гэрээлэгчийн төлөөлөгчийг өөрчлөгдсөн тухай энэхүү Гэрээний 23 дугаар зүйлд заасны дагуу нөгөө талдаа мэдэгдэнэ.

1.2. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ, ХЯНАН ШАЛГАХ ЭРХ

- а) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч (эсвэл Засгийн газрын төлөөлөгчийн томилсон эрх бүхий этгээд) нь гэрээт талбайд нэвтрэх болон газрын тостой холбогдсон бүхий л үйл ажиллагаатай танилцах, хянан шалгах эрхтэй. Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчийг энэхүү эрхээ хэрэгжүүлэх бүрэн боломжоор хангана. Ийнхүү танилцахдаа, Засгийн газрын төлөөлөгч нь тодорхой шалтгаангүйгээр Гэрээлэгчийн үйл ажиллагаанд саад учруулахгүй.
- б) Хуулиар эрх олгогдсон этгээд газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай танилцах, хянан шалгах эрхтэй.

ХОЁР ДУГААР ЗҮЙЛ. ТОДОРХОЙЛОЛТУУД

2.1. НЭР ТОМЬЁО

Энэхүү Гэрээнд тодорхойлсон нэр томьёонууд болон тэднээс үндэслэсэн бусад ухагдахуун, хэлбэрүүд нь хэрэв тухайн тохиолдолд өөрөөр тайлбарлаагүй бол энэхүү 2 дугаар зүйлд заасан агуулгатай байна.

"Газрын тосны газар" гэж Монгол Улсын Засгийн газраас газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулах, түүнийг биелэлтэд хяналт тавих зэрэг олгосон байгууллагыг хэлнэ.

"Армз-ленгф худалдааны зарчим" гэж Гэрээлэгч гэрээт түүхий тосыг гуравдагч тээгдээлд (Гэрээлэгчийн өөрийн салбар нэгж бус)-д худалдаалах гэрээнд дараахь нөхцөлүүдийг тусгасаныг хэлнэ. Үүнд:

1. Гэрээт түүхий тосны үнийг бууруулсан, эсвэл бууруулахад чиглэсэн аливаа үгссэн хуйвалдааны шинжийг агуулаагүй байх;
2. Төлбөрийн чөлөөтэй хөрвөх валютаар хийх;
3. Гэрээт түүхий тосыг худалдаалахад санхүүгийн ямар нэгэн хөнгөлөлтийг илүүтэйгээр үзүүлэх; Тухайлбал: бараа солилцоо, үнийн хямдрал, нөхөн төлбөр зэрэг хөнгөлөлтийн хэлбэрүүдийг хэрэглээгүй байх;

"Байгалийн хий" гэж агаарын даралт, температурын хэвийн нөхцөлд мийн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлэх бөгөөд үүнд хүнд ба хөнгөн хий, газрын тосны олборлолтын хий болон хүнд хийгээс шингэн нүүрс-устөрөгчийг ялгаж авсны дараа үлдэх хий, түүнчлэн шингэн буюу хийжүүлсэн нүүрс-устөрөгчтэй хамт гарган авсан бусад хий тус тус багтана.

"Баррель" гэж 1.01325 барын агаарын даралтын дор Фаренгейтын жаран (60) хэмийн дулаанд буй буюу тийм нөхцөлд тааруулсан 158.987 литрийн хэмжээг хэлнэ.

"Бүртгэл тооцооны журам" гэж Хавсралтад заасан бүртгэл тооцооны журмыг хэлнэ.

"Бүтээгдэхүүн хуваах гэрээ" гэж гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар ГТГ болон Гэрээлэгчийн хооронд байгуулж, Монгол Улсын Засгийн газар баталсан гэрээг хэлнэ.

"Газрын тос" гэсэн ойлголтод газрын хэвлийд байгаа шингэн тос, хий болон хатуу байдалтай хамтад нь буюу дангаар нь олборлож болох нүүрс-устөрөгчийн төрөл бүрийн нэгдлийг хамааруулна.

"Газрын тосны тухай хууль" гэж 1991 оны 1 дүгээр сарын 18-ны -ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Газрын тосны тухай хууль, энэхүү хуультай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.

"Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам" гэж Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам", энэхүү журамтай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.

"Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа" гэсэн ойлголтод газрын тос хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, бууруулах ажиллагааг хамааруулна.

“Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх” гэж Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд тухайн гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах эрхийг зөвхөн Гэрээлэгч эдгэхийг хэлнэ.

“Гэрээлэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааг энэ гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу явуулахыг зөвшөөрч гэрээ байгуулсан “DWM Petroleum AG”-ийг хэлнэ.

“Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр” гэж энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газарбаталсан өдрийг хэлнэ.

“Гэрээт жил” гэж Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр буюу дараагийн жилүүдийн уг өдрөөс эхлэн тооцсон дараалсан хуанлийн арван хоёр (12) сарын хугацааг хэлнэ.

“Гэрээт талбай” гэж энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрээний хавьтлаар тодорхойлсон талбайг хэлэх бөгөөд энэ талбай нь 7 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх хэмжээгээр тухай бүр багасч байна.

“Гэрээт түүхий тос” гэж гэрээт талбайгаас олборлож хуримтлуулсан Түүхий тосыг хэлнэ. Уг нэр томъёог тайлбарлах үүднээс “олборлосон” гэдэг нь газрын хэвлийгээс гарган бүтээгдэхүүн хуваах хэмжүүрийн хэрэгсэлээр нэвтрүүлсэн. “хуримтлуулсан” гэдэг нь авч борлуулах боломжийг бүрдүүлсэн тосыг хэлнэ.

“Дагалдах байгалийн хий” гэж эдийн засгийн хувьд үр ашигтайгаар олборлож болох газрын тосыг дагалдан илэрсэн байгалийн хийг хэлнэ.

“Дагалдах бодис” гэж газрын тос ба байгалийн хийгээс гаргаж болох буюу тэдгээрийг дагалдан илэрсэн бусад бодисыг хэлнэ.

“Дүрэм” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны гадархой төрлийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, горимыг хэлнэ.

“Захиргааны зардал” гэж Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарсан хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааны зардлаас бусад зардлыг хэлнэ.

“Нэгж талбай” гэж уртрагийн арван (10) минут, өргөргийн арван (10) минутын үржвэртэй тэнцэх хэмжээний газрыг хэлнэ.

“Нээлтийн цооног” гэж Үр ашигтай нээлт болох эсэхийг нь тогтоох шаардлагатай гэж Талууд үзэж буй байгалийн агууламжийг илрүүлсэн цооногийг хэлнэ.

“Орд” гэж нэг буюу хэд хэдэн цооногоор илрүүлсэн, геологийн бүтцээрээ болон давхарга зүйн онцлогоороо төсөөтэй бөгөөд газрын тос олборлож болох нэг буюу хэд хэдэн байгалийн агууламж бүхий талбайг хэлнэ.

“Олборлолтын зардал” гэж олборлолтын үйл ажиллагаатай холбогдон гарах бүх зардал (захиргааны болон хайгуулын зардлаас бусад)-ыг хэлнэ.

“Олборлолтын талбай” гэж Гэрээт талбай дахь Үр ашигтай нээлт бүхий талбайг хэлнэ.

“Олборлолтын үйл ажиллагаа” гэж нэг буюу хэд хэдэн Үр ашигтай нээлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

“Олборлолтын хугацаа” гэж Гэрээний 5.5 дугаар зүйлд заасны дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаа, мөн 5.7 дугаар зүйлд заасны дагуу сунгасан хугацааг хэлнэ.

“Олборлолтын хөтөлбөр” гэж үр ашигтай нээлттэй холбоотой Олборлолтын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлнэ.

“Өртөгт тос” гэж Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардыг нөхөхөд зориулах гэрээт түүхий тосыг хэлнэ.

“Роялти” гэж Монгол Улсын байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ.

“Талбай буцааж өгөх” гэж Гэрээний дагуу Гэрээлэгчээс гэрээт талбайг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаахыг хэлнэ.

“Талбайн дэнчин” гэж Гэрээлэгч гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх эдэлснийхээ төлөө Газрын тосны хуулийг хэрэгжүүлэх журамд заасны дагуу гэрээт талбайн хэмжээгээр нөхөн төлөгдөхгүйгээр ГТГ-г жил бүр төлөх төлбөрийг хэлнэ.

“Төсөв” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой үе шатанд хийгдэх ажлын хөтөлбөрийн мөнгөн илэрхийллийг хэлнэ.

“Туршилтын олборлолт” гэж нээлтийн болон үр ашигтай нээлтийн цооног мөн эсэхийг тогтоох зорилгоор цооногт олон улсын газрын тосны аж үйлдвэрт мөрддөг жишгийн дагуу явуулдаг туршилтын ажлын явцад хийх олборлолтыг хэлнэ.

“Туслах гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр Гэрээлэгчтэй гэрээ хийсэн аж ахуйн нэгж, иргэнийг хэлнэ.

“Түүхий тос” гэж газар доорхи байгалийн агууламжид байгаа, эсвэл гадаргуу дээр ялгагч болон боловсруулах төхөөрөмжөөр оруулан гаргасны дараа агаарын даралтад шингэн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлнэ. Түүнчлэн “түүхий тос” гэсэн нэр томъёонд байгалийн барагшин, конденсат ба ялгагч үйлдвэр, эсвэл боловсруулах бусад төхөөрөмжид шингэрүүлсэн байгалийн шингэн хий багтана.

“Үнэлгээний талбай” гэж үнэлгээний хөтөлбөрийн дагуу үнэлгээ хийх нь зүйтэй гэж Талуудын үзсэн геологийн нэг буюу хэд хэдэн бүтэц буюу илрэлийг хэлнэ.

“Үнэлгээний хөтөлбөр” гэж Нээлтийн цооногоор илрүүлсэн байгалийн агууламж нь Үр ашигтай нээлт болох эсэхийг тодорхойлох зорилгоор хийх ажлын төлөвлөгөөг хэлнэ.

“Үр ашигтай нээлт” гэж Гэрээлэгчийн гаргаж өгсөн олборлож болох тосны газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг үзүүлэлтэд тулгуурлан Талуудын боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу үр ашигтай олборлох боломжтой газрын тосны нэг буюу хэд хэдэн байгалийн агууламжийг хэлнэ.

“Хайгуулын зардал” гэж хайгуулын үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардал (захиргааны болон олборлолтын зардаас бусад) -ыг хэлнэ.

“Хайгуулын үйл ажиллагаа” -нд дараах үйл ажиллагаа багтана:

1. агаарын болон сансрын зураглал, геологи, геофизик, геохимийн судалгаа, керн авах, давхарга зүйн судалгаа явуулах, хайгуулын болон үнэлгээний цөөнөг оромдож ажиллуулах, мэдээллийн тайлал хийх болон дээрхтэй холбоотой бусад бүхий л үйл ажиллагаа;
2. тухайн үед үр ашигтай нээлтийн хүрээнд багтах нь тогтоогдсонгүй нэг буюу хэд хэдэн агууламжийг нээн илрүүлэх;
3. үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх.

“Хайгуулын хугацаа” гэж Гэрээний 5.1 дүгээр зүйлд заасны дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулах хугацаа, мөн 5.2 дугаар зүйлд заасны дагуу сунгасан хугацааг хэлнэ.

“Хуваах тос” гэж гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ.

“Хуанлийн сар” гэж аргын тооллын арван хоёр (12) сарын нэг (1) нь бөгөөд энэ нь тухайн сарын эхний өдрөөс эхлэн, сүүлчийн өдрийг дуусгал үргэлжилнэ.

“Хуанлийн улирал” гэж а/нэг, хоёр, гурав дугаар сарууд; б/ дөрөв, тав, зургадугаар сарууд; в/ долоо, найм, есдүгээр сарууд; г/ арав, арваннэг, арванхоёр дугаар сарууд зэрэг аргын тооллын улирлын нэгийг хэлнэ.

“Хуанлийн жил” гэж аргын тооллын 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусах нэг (1) жилийг хэлнэ.

“Хуулийн этгээд” гэж хуульд заасан журмаар хуулийн этгээд болох нь нотлогдсон аливаа аж ахуйн нэгжийг хэлнэ.

“Хууль тогтоомж” гэж Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актыг хэлнэ.

“Хэмжилт хийх цэг” гэж олборлосон түүхий тосоо худалдах зорилгоор гэрээт талбай дээр цэвэршүүлсэн тосыг хэмжих цэгийг хэлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЭРХ

а) Гэрээлэгчийн гаргаж өгсөн олборлох болох тосны газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг үзүүлэлтэд тулгуурлан Талуудын боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу үр ашигтай олборлох боломжтой газрын тосны нэг буюу хэд хэдэн байгалийн агууламжийг хэлнэ.

- б) Геологи, геофизик, гидрогеологи, геохими, петрофизик, лабораторийн шинжилгээ зэрэг газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүхий л мэдээллийн эх хувийг өмчилно.
- в) Гэрээлэгчийн явуулж буй үйл ажиллагаатай холбогдсон баримт бичиг болон хэрэглэж буй тоног тохоромж, багаж хэрэгсэл, барилга байгууламжийн заавар, техникийн тодорхойлолт, зураг зэрэг техникийн баримт бичгийн хувийг авна.
- г) Гэрээлэгчээс түүний хуваарьт Газрын тосыг Монгол Улсын дотоодын хэрэгцээнд шилдүүлэхийг хүсэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үнийг дэлхийн зах зээлийн үнээр ам. доллараар толно.
- д) Монгол Улсын Засгийн газарт ногдох Газрын тосны борлуулалтанд хяналт тавьж, захиран зарцуулна.
- е) Энэхүү гэрээнд заагдсан бусад эрхийг эдэлнэ.

3.2. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮҮРЭГ

- а) Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад Гэрээлэгчид дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- б) Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, дүрэм, энэхүү Гэрээний биедгэлгэд хяналт тавина.
- в) Энэхүү гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ.

3.3. ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ

- а) Гэрээлэгч нь Монгол Улсын Газрын тосны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээний дагуу Гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх эдэлнэ.
- б) Зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр дамжуулах хоолой, гүүр, зам, орон сууц, агуулах байгууламж, нисэх онгоцны талбай, радио цамхаг, хөлбооны төхөөрөмж барьж байгуулна.
- в) ГТ-ын мэдээллийн санд хадгалагдаж буй гэрээт талбайд холбоотой урьд өмнө хийгдсэн хайгуул, геофизик, петрофизик, геохими, цооногийн талаарх мэдээ, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай тохиолдолд худалдан авах эрхтэй.
- г) Энэхүү Гэрээний дагуу өөрт ногдох газрын тосыг захиран зарцуулна.
- д) Гэрээлэгч нь Монгол Улсын хуулийн этгээд, иргэдийн нэгэн адил Монгол Улсын эрхзүйн хамгаалалтад байна.
- е) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оролцох эрх, үүргээ Засгийн газраас бичгээр зөвшөөрлийн үндсэн дээр бүрдэл шинжлүүлж болно.

- ё) Гэрээлэгчийн ажиллагаад болон гэрээт талбайд ажиллагаад хүнд өвчин тусах, байгалийн гамшигт нэрвэгдэх, гэмт халдлагад өртөх, нонтой осолд орох тохиолдолд Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газраас дэмжлэг хүснэ.
- з) Гэрээлэгч нь ажиллагааны ажилд авах, ажлаас халах, туслан гүйцэтгэгч сонгох, газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардлагатай бараа материал худалдан авах эрхтэй.
- ж) Гэрээнд заасан бусад эрхийг эдлэнэ.

3.4. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮҮРЭГ

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулахдаа дараах үүргийг хүлээнэ:

- а) Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, энэхүү хуультай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлт, эрх бүхий байгууллагаас баталсан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад мөрдөх дүрэм, журам, Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээг дагаж мөрднө.
- б) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг олон улсын болон Монгол Улсын стандарт, дүрэм, журамд нийцүүлэн явуулна.
- в) Хэрэв хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчинг хамгаалахтай холбогдсон осол, зөрчлийг гарсан тохиолдолд холбогдох байгууллагууд болон ГТГ-т нэн даруй мэдэгдэж, уг зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авна.
- г) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсад оруулж ирж буй техник, технологи, тоног төхөөрөмж нь газрын тосыг үр ашигтай олборлох шаардлагад нийцсэн байна.
- д) Газрын тосны газар Гэрээлэгчийн хуваарьт газрын тосыг Монгол Улсын дотоодын хэрэгцээнд нийлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Гэрээлэгч өөрийн хуваарьт газрын тосыг тэргүүн ээлжинд Монгол Улсын дотоодын хэрэгцээнд нийлүүлнэ.
- е) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, үнэлгээний ажлын тайлангийн эх хувийг ГТГ-т хүлээлгэн өгсөн байна.
- ё) Монгол Улсын хүн ам, ан амьтан, байгаль, түүх, соёлын үнэт зүйл, газрын гадаргууг хамгаалах шаардлагатай дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Гэрээлэгч нь Монгол Улсын хүн ам, мал, ан амьтан, агаар, ус, түүх, соёлын үнэт зүйл, газрын гадаргуу, байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын төлөөлөгч болон эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;
2. Гэрээний хугацаа дуусах, гэрээ хүчингүй болох, эсхүл гэрээт талбайгаас төлөрхой хэсгийг буцааж өгөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгөноос бусад бүх тоног төхөөрөмж, байгууламж, зориулалт талбайгаас гаргаж, байгаль орчныг

нөхөн сэргээх;

3. Жил бүрийн олборлолтын хөтөлбөртөө хаах цооногуудын талбайн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын хөтөлбөр, түүний сал хүүжилтийн талаар гутаах;
 4. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахыг хориглосон нутаг дэвсгэрийн ойр орчимд үйл ажиллагаа явуулах тохиолдолд түүнийг хамгаалахтай холбогдсон тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
 5. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хайгуул, олборлолтогтой холбогдсон аливаа тээвэрлэлийг Монгол Улсын холбогдох хуульд нийцүүлэн зохих дүрэм, журмын дагуу хүн амын эрүүл мэнд хүртээлэн байгаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр зохион байгуулана.
- ж) Гэрээт хугацаанд олж хуримтлуулсан геологи, гидрогеологи, геохими, геофизикийн судалгаа, петрофизик, лабораторийн шинжилгээ, өрөмдлөг, цооног, цооногийн гуршилт, олборлолтын болон бусад бүх анхдагч мэдээллийн эх хувь, тайлан баталсан дүрмийн дагуу бэлтгэж, жил бүр ГТГ-т өгнө.
- з) Газрын тосны салбарыг хөгжүүлэх, боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- к) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны горимыг зорчтөсөний улмаас гарах бүх хохирлыг хариуцна.
- л) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүлэхээр Туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ГТГ-ын төлөөллийг санал өгөх эрхтэйгээр оролцуулах, туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө гэрээний төслийг Засгийн газрын төлөөлөгчид урьдчилан танилцуулж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулах бөгөөд гэрээний нэг хувийг Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.
- м) Гэрээлэгч нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ГТГ-ыг оролцуулна.
- н) Гэрээлэгч нь ГТГ-ын төлөөлөгчидтэй газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар ажил төрлийн уулзалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулах бөгөөд уулзалттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.
- о) Гэрээлэгч нь газрын тостой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөлтэй уулзалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, өөрийн үйл ажиллагааг сурталчилж, танилцуулах бөгөөд уулзалттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ, ЗАРДАЛ БОЛОН ӨРТӨГ НӨХӨЛТ

- а) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг Гэрээлэгч хариуцна. Гэрээлэгч нь зардлаа нөхөхийн тулд нийт олборлосон гэрээт түүхий тосноос роаялтийг хасаад үлдэх тосноос хувийг зарцуулах эрхтэй. Гэрээнд оролцогч аль ч тал эдийн засгийн үр ашги тай нээлт болно гэсэн баталгаа гаргахгүй.

- б) Гэрээлэгчийн авч ашиглах эрхтэй нийт өртөгт тосны хэмжээ нь Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардлуудын нийлбэртэй тэнцүү байна.
- в) Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад зарцуулсан өртөг, зардлаа борлуулалт хийсэн тухай бүр нөхөж авна. Гэрээлэгч нь үйл ажиллагааны нийт зардлаа нөхөж дуусгал үлдэгдэл нь дараагийн хуанлийн саруудад шилжигдэн тооцогдоно.
- г) Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад баримтлах төлөвлөлтийн болон бүртгэл тооцооны загварыг Засгийн газрын төлөөлөгчтэй лөхирх бөгөөд газрын тостой холбогдох зардлын бүртгэлийн хувийг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө. Гэрээлэгч нь газрын тостой холбогдох зардлын дүн болон эцэсэрийг нөхөж авах аргачлалын талаар Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ.
- д) Гэрээлэгч нь газрын тостой холбогдох зардлыг давхардуулалгүйгээр хайгуул, олборлолтын болон үйл ажиллагааны зардал гэж ангилна.
 - 1) Дүгээр газрын тостой холбогдох зардал нь дараах дарааллаар нөхөгдөнө.
 - 1 хайгуулын зардал;
 - 2 Захирааны зардал;
 - 3 олборлолтын зардал;
 - Тодруулга хийх үүднээс, олборлолтын зардал нь хайгуулын хугацаанд, хайгуулын зардал нь олборлолтын хугацаанд гарч болно гэдгийг зөвшөөрөв.
- е) Дээр дурьдсаныг үл харгалзан, 8.1 дүгээр зүйлийн дагуу төлөгдөх роялти болон 10 дугаар зүйлийн дагуу төлөгдөх урамшууллауд болон бусад төлбөрүүд нөхөн төлөгдөхгүй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУГАЦАА

5.1. ХАЙГУУЛЫН ХУГАЦАА

Хайгуулын ажил явуулах хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тав (5) жил байна. Энэхүү 5 жилийг 3 үе шатад ангилна. Нэгдүгээр үе шат нь 1 жил, хоёрдугаар үе шат нь 2 жил, гуравдугаар үе шат нь 2 жил байна.

5.2. ХАЙГУУЛЫН ХУГАЦААГ СУНГАХ

- а) Хайгуулын ажил явуулах хугацааг Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу сунгаж болно.
- б) Гэрээлэгч нь хайгуулын ажил явуулах хугацааг сунгах хүсэлт тавихдаа өмнөх хайгуулын үе шатны хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв, заавал гүйцэтгэх ажил үүргийг биелүүлсэн байна. Хайгуулын ажил явуулах хугацааг сунгахдаа дараагийн үе шатанд заавал хийх хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг Засгийн газрын төлөөлөгч батална.
- в) Хэрэв хайгуулын эцсийн хугацаа дуусгавар болох өдөр хүртэл үр ашигтай нээлт болох эрх нь тодорхойгүй нээлийн цооног байгаа бол уг нээлийн цооног бүхий үр ашгийн талбайн хувьд нээлийн хайгуулын хугацаа нь дуусах төхөөлүүдийн аль нэг нь болох хүртэл хүчин төгөлдөр үргэжүүлнэ. Үүнд:

1. тухайн нээлтийг үр ашигтай нээлт гэж тогтоох.
2. тухайн нээлтийг үр ашигтай бус нээлт гэж тогтоох.
3. нэмэгдэл хайгуулын хугацаа нь зургаан (6) сараас бүтээгүй байна.

5.3 НЭЭЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

а) Хайгуулын цооногт хийсэн туршилтын ажлын явцад дараах хүснэгтээр тодорхойлсон тосны ундарга өгч байвал уг цооногийг нээлтийн цооног гэж үзэж Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ. Засгийн газрын төлөөлөгч нь нээлтийн цооног тогтоосон тухай мэдэгдсэн өдрийг тухайн нээлтийн цооногийн бүртгэсэн өдөрт тооцно.

| Цооногийн гүн (метр) | < 500 | 500-1000 | 1000-2000 | >2000 |
|---------------------------|-------|----------|-----------|-------|
| Тосны ундарга (тонн/өдөр) | 0.5 | 1.0 | 3.0 | 5.0 |

б) Хэрэв Гэрээлэгч тухайн нээлтэд үнэлгээ өгөх нь зүйтэй гэж үзвэл, уг Нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч тус Нээлт нь Үр ашигтай нээлт мөн эсэхийг тогтоох үнэлгээний хөтөлбөр ба төсөв, үнэлгээ хийгдэх талбай (үнэлгээний талбай)-н зураг, бусад тодорхойлолтыг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө. Засгийн газрын төлөөлөгч үнэлгээний хөтөлбөр, төсвийг баталсаны дараа Гэрээлэгч үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлнэ.

5.4 ҮР АШИГТАЙ НЭЭЛТ

а) Үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан, төсвэл нэг болон түүнээс дээш Нээлтүүд нь Үр ашигтай нээлт гэж тогтоогдвол Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ. Засгийн газрын төлөөлөгч үр ашигтай нээлт тогтоосон тухай мэдэгдсэн өдрийг тухайн Үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдөрт тооцно.

б) Үр ашигтай нээлт нэг бүрийг бүртгэсэн өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид олборлолтын хөтөлбөр, төсөв, олборлолтын үйл ажиллагаа явуулах талбай (олборлолтын талбай)-н зураг, олборлолтын талбайн зөвшөөрөл авахтай холбогдсон бусад тодорхойлолт, хүсэлтээ гаргаж өгнө. Газрын тосны газар олборлолтын хөтөлбөр, төсвийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор хянаж, олборлолтын хөтөлбөр, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзвэл ер (90) хоногийн дотор олборлолтын төлөвлөгөө, төсвийг баталж, газрын тос олборлох тухай шийдвэр гаргана. Хэрэв олборлолтын хөтөлбөр, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын төлөөлөгч олборлолтын хөтөлбөр, төсвийг батлах хугацааг нэг зуун наян (180) хоног хүртэл сунгах эрхтэй.

в) Гэрээлэгч нь Газрын тос олборлох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Олборлолтын үйл ажиллагааг эхэлнэ.

5.5 ҮР АШИГТАЙ НЭЭЛТ, ТУРШИЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦА

а) Үр ашигтай нээлт бүрийг тогтоох хугацаа нь туршилтын олборлолтыг оролцуулаад гурван зуун жар (360) өдөр хүртэл байна.

- б) Үр ашигтай нээлт бүрийн олборлолтын хугацаа нь тухайн үр ашигтай нээлтээс олборлолт явуулахыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш хорь (20) хүргэл жил байж болно.

5.6. ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙГ ХЯНАХ

Гэрээлэгч нь нэмэлт мэдээлэл буюу судалгааг үндэслэн үнэлгээний хөтөлбөр, олборлолтын хөтөлбөр болон талбайг өөрчлөх тухай шийдвэрээ гаргахаас арван таван /15/ хоногийн өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тэдгээрт өөрчлөлт оруулж болно. Гэхдээ 7 дугаар зүйлийн дагуу нэгэнт буцааж өгсөн гэрээт талбайн аль ч хэсгийг үнэлгээний болон олборлолтын талбайд оруулж болохгүй.

5.7. ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ

Гэрээлэгч нь боловсруулах үйлдвэр барих, шингэн тос, байгалийн хий тээвэрлэх хоолой тавих зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц шинээр барьж байгуулах тохиолдолд өрд ашиглах хугацааг Засгийн газрын төлөөлөгч хоёр удаа тус бүр таван (5) жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болно. Гэрээлэгч нь олборлолтын хугацаа дуусахаас жараас (60) доошгүй хоногийн өмнө олборлолтын хугацааг сунгах саналаа Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгнө.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ, ХАЙГУУЛЫН АЖИЛ

6.1. ЗААВАЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

- а) Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг зуун хорь (120) хоногийн дотор Гэрээний Хавералт "В"-д заагдсан хайгуулын үйл ажиллагаа явуулж эхэлнэ. Хайгуулын хугацаанд заавал хийх ажил үүргийг биелүүлж, (Хавералт В)-д төлөвлөсөнөөс багагүй хэмжээний мөнгө зарцуулсан байна. Гэрээлэгч энэхүү үүргээ бүрэн биелүүлээгүй бол гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор ГТГ-т төлнө.
- б) Тухайн жил Гэрээлэгч заавал гүйцэтгэх ажил үүргээс илүү ажил, үүрэг гүйцэтгэж, төлөвлөснөөс илүү зардал гаргасан тохиолдолд дараа жилийн гүйцэтгэх ажил, зардалд шилжүүдэн тооцож болно.
- в) Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эхний гэрээт жилд заавал гүйцэтгэх, ажил үүргийн баталгаа болгож Монгол Улсын Худалдаа хөгжлийн банк дахь Эскроу дансанд байршуулсан ~~10000000~~ доллартай холбогдолтой асуудлыг ГТГ болон Гэрээлэгчийн хооронд 2008 оны 5 дугаар сарын 27-ний өдөр байгуулсан Эскроу дансанд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээний дагуу шийдвэрлэнэ.

6.2. ӨРӨМДӨХ АРГУУД

Гэрээлэгч нь 6.1-д заасан ажил үүрэг, хайгуулын нооног өрөмдөх ажиллагааг олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг дэвшилттэй аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Дараах тохиолдолд хайгуулын нооногийн өрөмдөхийг дууссанд тооцож, зардлыг өртөг нөхөх зардалд оруулна. Үүнд:

- а) өрөмдөх гүнд болон эсхүл зорилтот давхаргал хурдан

- б) нэгдлийн дооног болсон.
- в) ором нь суурь чулуулагт хүрсэн.
- г) ором нь үд нэвтрэх биет, геологийн хэт халуун градиентэд хүрсэн.

6.3. ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР БА ТОСОВ

Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, цаашид гэрээт жил эхлэхээс ерээс (90) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч нь тухайн гэрээт жилд гүйцэтгэх хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг нэр төрөл бүрээр нарийвчлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөр батлуулна. Мөн өмнөх жилд хийсэн ажлын тайланг танилцуулж, ГТГ-г өгнө.

Тухайн гэрээт жил эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч хамтран хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг хянан хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч батална. Гэрээлэгч нь энэхүү ажлын хөтөлбөр, төсвийг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд өөрийн саналыг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид нэн даруй гаргаж өгнө. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч саналыг авснаас хойш ажлын арван таван (15) өдрийн дотор Гэрээлэгчтэй уулзаж, өөрчлөлтийг хянан хэлэлцэж батална. Хэрэв тухайн жилийн батлагдсан төсөвт ажлаас илүү ажил хийгдэх бол илүү хийсэн ажлын хэмжээ, зардлын төсвийн хэмжээг ГТГ-аар батлуулсанаар ортог нөхөгдөх зардалд тусгана.

ДОЛДУГААР ЗҮЙЛ, ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

7.1. ГЭРЭЭ ЭСООР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

Гэрээлэгч нь :

- а) Хайгуулын ажлын хугацааны эхний үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор гэрээт талбайн хорин тав (25)-аас тавин (50) хувийг буцаан өгч болно.
- б) Хайгуулын ажлын хугацааны хоёр дахь үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор гэрээт талбайн үлдсэн хэсгийн хорь (20) -оос гучин (30) хувийг буцаан өгч болно.
- в) Хайгуулын нийт хугацаа дуусахад үнэлгээний болон олборлолтын талбайнаас бусад бүх талбайг буцааж өгнө. Гэрээлэгч нь анхдагч гэрээт талбайг бүхэлд нь болон аль ч хэсгийг буцааж өгөхийн өмнө түүний гадаргуугийн унаган төрхийг анх байсан байдалд нь сэргээх арга хэмжээ авсан байна.
- г) Олборлолтын талбайг буцааж өгөхийн өмнө бүх цооногуудыг хааж битүүмжилж, олборлох, хадгалах, боловсруулах, дамжуулах бүх тоног төхөөрөмжүүдийг талбайгаас зайлуулж, талбайг хог хаягдлаас цэвэрлэн, хөрс, усны бохирдлыг арилгаж, талбайн гадаргуугийн унаган төрхийг сэргээсэн байна.
- д) Энэхүү зүйлийн “в”, “г” заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

7.2. ООРИЙН ХҮСЭЛТЭЭР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

- а) Гэрээлэгч энэхүү Гэрээний хавсралт "В"-д заасан ажил үүргээ гүйцэтгэсэн тохиолдолд талбайг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг өөрийн хүсэлтээр буцааж өгч болно. Ийнхүү сайн дураараа буцааж өгсөн хэсгүүдийг 7.1-д дурьдсан гэрээ ёсоор буцааж өгсөн талбайд оруулан тооцно.
- б) Гэрээлэгч нь энэхүү гэрээний хавсралт "В"-д заасан заавал гүйцэтгэх ажил үүргээ гүйцэтгээгүй талбайгаа сайн дураараа буцааж өгөх тохиолдолд гүйцэтгээгүй ажилд ногдох мөнгийг тухайн талбайг буцааж өгөхөөс гучаас (30) доошгүй хоногийн өмнө ПТГ-г төлнө.

7.3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ

Гэрээлэгч үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч үр ашигтай нээлт тогтоогдоогүй тохиолдолд уг үнэлгээний талбайг буцааж өгнө. Үнэлгээний хөтөлбөрийн дагуу заавал гүйцэтгэх ажил үүргээ гүйцэтгээгүй байгаа үнэлгээний талбайг сайн дураараа буцааж өгөх тохиолдолд гүйцэтгээгүй ажилд ногдох мөнгийг тухайн үнэлгээний талбайг буцааж өгөхөөс гучаас (30) доошгүй хоногийн өмнө ПТГ-г төлнө.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. РОЯЛТИ БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

8.1. РОЯЛТИ

1. Гэрээлэгч борлуулалт хийсэн тухай бүрт Гэрээт тосноос тосноосж Роялти төлнө. Роялти нь нийт олборлосон гэрээт түүхий тосны [redacted] хувьтай тэнцүү байх ба роялтийг бэлэн мөнгөөр буюу эсвэл бүтээгдэхүүнээр /тосоор/ төлж болно.
2. Роялтид төлөх төлбөрийг 8.4 дүгээр зүйлд заасны дагуу тооцож, борлуулалт хийсэн тухай бүр төлнө. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч энэ талаар өөр журам тогтоож болох ба энэ тухайгаа Гэрээлэгчид гуч (30) хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

8.2. ТҮҮХИЙ ТОС БОРЛУУЛАХ

- а) Роялти болон Монгол Улсын Засгийн газарт ногдох гэрээт түүхий тосыг хэмжилт хийсэн цэгээс тооцох бөгөөд түүхий тосыг борлуулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Түүхий тосны үнэлгээг худалдан авагчтай хийсэн түүхий тос борлуулах гэрээнд төхирсон үнээр тооцно.
- б) Монгол Улсын Засгийн газар нь өөрт ногдох тосыг мөнгөөр авах тохиолдолд борлуулсан түүхий тосноос, тосоор авах тохиолдолд олборлож, хуримтлуулсан тосноос тооцох ба энэ тухайгаа хуанлийн улирал эхлэхээс гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Гэрээлэгчид бичгээр мэдэгдэнэ.

8.3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

- а) Хуанлийн сар бүрийн гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хасаад үлдэх хэмжээ (Хуваах тос)-г Монгол Улсын Засгийн газар болон Гэрээлэгчийн хооронд доорх хувиар хуваарилна. Үүнд:
 1. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 5000 баррельтай тэнцүү буюу түүнээс бага байвал Монгол Улсын Засгийн газарт [redacted]

Гэрээлэгчид

2. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 5001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 10000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

3. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 10001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 15000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

4. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 15001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 20000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

5. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

- б) Гэрээлэгчийн нөхөж авах зардлын үлдэгдэл нь зардал нөхөх талаар гэрээгээр тохирсон 40 хувиас бага байх тохиолдолд Гэрээлэгчийн зардлыг нөхөөд үлдсэн тосыг энэхүү гэрээний 8.3-ын "а"-д тохирсон хувиар Талууд хувааж авна.
- в) Гэрээт түүхий тосны өдрийн дундаж хэмжээг тогтоохдоо тухайн сард олборлосон түүхий тосны нийт хэмжээг тухайн сард олборлолт явуулсан өдрийн гоонд хуваана.
- г) Хуваах тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны үнэлгээг Гэрээний 8.4 дүгээр зүйлд заасны дагуу хийх бөгөөд Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны гөлбөрийг борлуулж дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор ГТГ-г төлөх бөгөөд эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд өөр хэлбэрээр гүйцэтгэж болно.

8.4 ГЭРЭЭТ ТОСНЫ ҮНЭЛГЭЭ

- а) Энэхүү Гэрээний 8.1 дүгээр зүйлд заасан, Монгол Улсын Засгийн газарт төлөх роялти, 8.3-г заасан хуваах тосны үнэлгээг худалдан авагчтай хийсэн түүхий тос борлуулах гэрээнд тохирсон үнээр тооцно.
- б) Роялти болон Монгол Улсын Засгийн газарт ногдох гэрээт түүхий тосыг Гэрээлэгч зуучлан борлуулах тохиолдолд түүхий тос борлуулах, тээвэрлэхтэй холбогдсон гэрээ байгуулахын өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид танилцуулж, харилцан тохиролцсон үндсэн дээр гурвалсан гэрээ байгуулна. Монгол Улсын нутаг дэвсгэртээ олборлосон Гэрээлэгчид ногдох түүхий тосны үнийг ижил хугацаанд түүхий тосны дундаж зах зээлийн борлуулсан өдрийн үнээр тооцно.

- в) Гэрээт түүхий тосны үнийн дүнг Гэрээлэгчийн армз-ленгф аргачлалаар чөлөөт хөрвөх талноогаар борлуулсан үгээр тоошио.

8.5 БОРЛУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

- а) Үр ашигтай нээлт бүрийн хувьд Гэрээлэгч нь хуанлийн улирал эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн дотор олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн шийтлэг аргачлалын дагуу Гэрээлэгчийн олборлож борлуулахаар тооцож буй түүхий тосны дэд хэмжээ, зах зээлийн үнэ болон холбогдох бусад хүчин зүйлүүдийн тухай урьдчилсан мэдээ Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.
- б) Гэрээлэгч гэрхүү мэдээнд Роялти, түүхий тосны үнэ болон Монгол Улсын Засгийн газар, Гэрээлэгчид ногдох Гэрээт түүхий тосны тооцоог багтаасан байна. Гэрээлэгч урьдчилан төлөвлөсөн хэмжээний газрын тосыг олборлохыг эрмэлзэнэ. Гэрээлэгч Үр ашигтай нээлт бүхий хэд хэдэн орд цооногоос олборлох хэмжээг нэгтгэн тооцож болно.

8.6 ДУТАЛТ БА ХЭГРҮҮЛЭЛТ

Аль нэг тал нь гэрээт түүхий тосоо зарим үед бүрэн хэмжээгээр нь авах боломжгүй байж болохыг хүлээн зөвшөөрч байна. (энэ тохиолдолд уг талыг дутуу авагч гэнэ). Ийм тохиолдолд нөгөө тал нь ашиглалтыг бүрэн хэмжээгээр үргэлжлүүлэн орлогыг өөрийн галдаа хуваарилж (энэ талыг хэгрүүлэн авагч гэнэ) болно.

Гэрээлэгч хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагчийн нөхөн авах түүхий тосны хэмжээг тооцон бүртгэнэ. Хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагч талд ногдох түүхий тосыг нөхөж өгнө. Гэхдээ энэ хуваарилалтыг үйлдвэрлэл, борлуулалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцлөөр хийж гүйцэтгэнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ, ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

Хэрэв үр ашигтай болох нь тогтоогдсон аливаа нээлтээс хий олборлох /түүхий тосны хамт буюу ямарваа нэг өөр хэлбэрээр/ бололцоотой бол уг хийг олборлож, борлуулах талаар Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчтэй харилцан тохиролцож, шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах давуу эрх эдэлнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ. УРАМШУУЛАЛ, ШИМТГЭЛ БОЛОН БУСАД ТӨЛБӨРҮҮД

10.1 УРАМШУУЛАЛ

- а) Гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал: Гэрээ Монгол Улсын Засгийн газраар батлагдсан өдрөөс хойш жар /60/ хоногийн дотор Гэрээлэгч ГТГ-т _____ -н ам.доллар төлнө.
- б) Олборлолт эхэлсний урамшуулал: Гэрээлэгч олборлолт эхлүүдсэн тохиолдолд олборлолт эхэлсний урамшуулал _____ ам.долларыг Олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор ГТГ-т _____

в) Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газарт олборлолт нэмэгдүүлсний урамшууллыг дараах тохиолдол бүрт 1/нэг/ удаа төлнө:

1. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 0-5001 баррелиас илүү гармагц _____ -н ам. доллар;
2. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 5001 баррелиас илүү гармагц _____ -н ам. доллар;
3. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 10001 баррелиас илүү гармагц _____ ам. доллар;
4. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 15001 баррелиас илүү гармагц _____ н ам. доллар;
5. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 20001 баррелиас илүү гармагц _____ ам. доллар;

10.2 СУРГАЛТЫН УРАМШУУЛАЛ

а) Гэрээлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш жил бүр Гэрээт жилийн эхнээс гуч (30) хоногийн дотор сургалтын урамшууллыг ГТГ-г төлнө. Үүнд:

- 1/ 1 дэх жил
- 2/ 2 дахь жил
- 3/ 3 дахь жил
- 4/ 4 дэх жил
- 5/ 5 дахь жил

10.3 ТАЛБАЙН ДЭЛЧИН

а) Гэрээлэгч Монгол Улсын Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу Гэрээт талбайн хэмжээгээр дэнчин жил бүр Засгийн газарт төлнө.

- i. Хайгуулын ажлын эхний үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй)
- ii. Хайгуулын ажлын хоёр дахь үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй)
- iii. Хайгуулын ажлын гурав дахь үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт (Олборлолтын талбайг оруулахгүй)
- iv. Эрэл, хайгуулын ажлын хугацааг Засгийн газрын шийдвэрээр сунгасан хайгуулын хугацаанд тэрэг талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй)

в. Олборлолтын талбайн нэг хавтгай дөрвөлжин километр талбайд ногдох

б) Гэрээлэгч нь талбайн дэнчинг Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар /60/ хоногийн дотор, дараагийн гэрээт жилүүдийн талбайн дэнчинг тухайн гэрээт жил эхэлснээс хойш гуч (30) хоногийн дотор тус тус төлөх бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчид төлбөр хийгдсэнийг нотлох баримт гаргаж өгнө.

10.4 ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

Гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газарт газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу захиргааны үйлчилгээний шимтгэл төлнө. Энэхүү шимтгэлд гэрээт талбай авах захиалга, хайгуулын хугацааг сунгах, олборлолтын талбай авах захиалга, олборлолтын талбайн хэмжээг өөрчлөх, олборлолтын хугацааг сунгах, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа эрх үүргийг шилжүүлэхэд төлөх төлбөрүүд орно.

Гэрээлэгч нь дор дурдсан захиргааны шимтгэл төлнө. Үүнд:

- а) Гэрээт талбай авах захиалга
- б) Хайгуулын хугацааг сунгах
- в) Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хайгуулын хугацааг сунгах
- г) Олборлолтын талбай авах захиалга
- д) Олборлолтын талбайн хэмжээг өөрчлөхөд
- е) Олборлолтын хугацааг сунгах
- ё) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа эрх, үүргийг шилжүүлэх

10.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ

Гэрээлэгч нь байгаль орчныг нөхөн сэргээх ажилд жил бүр дараахь байдлаар хөрөнгө, мөнгө зарцуулна.

- 1/ 1 дэх жил
- 2/ 2 дахь жил
- 3/ 3 дахь жил
- 4/ 4 дэх жил
- 5/ 5 дахь жил

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ХЭМЖИЛТ

11.1 БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ХЭМЖИЛТ

а) Гэрээнд оролцогч талуудын хооронд хуваах Гэрээт түүхий тосны хэмжээг тодорхойлох зорилгоор хэмжилтийг (Бүтээгдэхүүн хуваах хэмжилт) олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал зарчмыг үндэслэн гүйцэтгэнэ. Гэхдээ дээрхээс бусад (үүнд ганцаарчилсан цооногийн олборлолтыг хэмжээг тогтоох хэмжилт орно) зорилгоор оор гөрлийн хэмжилт хийгдэж болохыг харилцан тохиролцов.

б) Энэхүү хэмжих хэрэгсэл, хэмжилтийн аргачлал нь Монгол Улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна.

в) Энэхүү Гэрээнд заасны дагуу бүтээгдэхүүн хуваах хэмжилтийг Хэмжилт хийх цэг дээр хийнэ.

г) Талууд энэхүү 11 дүгээр зүйлд заасны дагуу бүтээгдэхүүн хуваах хэмжилт хийгдэхээс өмнө түүхий тосыг авч ашиглах эрхгүй болохыг харилцан хүлээн зөвшөөрөв.

11.2 ХЭМЖИЛТИЙГ ЗАЛРУУЛАХ

а) Хэрэв Гэрээлэгч нь Бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн аль нэг багаж хэрэгсэлд тохируулна хийх, засварлах эсвэл солихыг хүсвэл Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч эрх бүхий байгууллагад мэдэгдэж хянуулна.

б) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь бүтээгдэхүүн хуваах аливаа хэмжилтийг ямар ч үед ажиглах, үнэн зөвийг тодорхойлох зорилгоор шалгалт хийх эрхтэй. Хэрэв шалгалтаар хэмжилт нь олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг аргачлал болон стандартад нийцэхгүй болох нь илэрвэл Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч түүнийг залруулах арга хэмжээ авахыг Гэрээлэгчээс шаардана. Хэрэв Гэрээлэгч нь энэ шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор залруулах арга хэмжээ авч эхлээгүй, эхэлсэн ч явц нь удаашралтай байвал Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч олборлолтыг зогсоож, эрх бүхий хөндлөнгийн гүйцэтгэгчээр хэмжилтийг хийлгэж зардлыг Гэрээлэгчээр төлүүлнэ.

в) Гэрээлэгч хэмжилтийн алдаатай байх үеийн олборлолтын үнэн бодит хэмжээг тогтоож өмнөх хэмжилтийг залруулах бүхий л арга хэмжээ авна. Гэрээлэгч нь гүйцэтгэсэн залруулгын ажлын тухай тайланг ГТТ-т хүргүүлж батлуулна. Хэрвээ хэмжилтийн алдаа анх гарсан хугацааг тогтоох боломжгүй бол урьд хийгдсэн шалгалтын одор ба алдааг илрүүлсэн өдрийн хоорондох хугацааны дундах үеийг алдаатай хэмжилт эхэлсэн цагаар тооцно.

11.3 ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ

Гэрээлэгч олборлосон гэрээт түүхий тос болон бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн бүртгэлийн нэг хувийг хэмжилт хийсэн тухай бүр Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ. Эдгээр баримтуудыг таван (5) жилийн хугацаанд хадгалах бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь эдгээр бүртгэлтэй танилцах эрхтэй. Гэрээлэгч нь танилцах боломжийг хангах үүрэгтэй.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ

12.1 ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨХ

Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагааны хотолбор, тосов, судалгааны үр дүнд цуглуулсан геологи, геофизик, петрофизик, геохими, гидрогеологи, цооногийн хаалтын тайлан болон бусад бүх эх мэдээлэл, эдгээрийг боловсруулж тайлал хийж дүгнэсэн үр дүнгийн тайлан, геодези, байр зүйн мэдээлэл, зураг зэрэг мэдээллийн бүх эх хувийг өмчилнө. Хоёр тал газрын тосны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нөгөө талаасаа бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч талд шилжүүлэхийг хориглоно.

12.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ

Гэрээлэгч газрын тосны хайгуул, олборлолт, борлуулалт, ашиглалт, боловсруулах болон бусад үйл ажиллагааны тухай бүртгэлийг ГТГ-тай тохиролцсон загварын дагуу хөтөлнө. Эдгээр бүртгэлийг англи хэл дээр хөтөлнө. Гэрээлэгч нь энэхүү бүртгэл, тайлангийн хувийг гүйцэтгэсэн өдөр, сар, улирал, жилд нь Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө.

12.3 ГЕОФИЗИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч нь геофизикийн анхдагч мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс баталсан Дүрмийн дагуу нэг хувийг Засгийн газрын төлөөлөгчид өгнө.

12.4 ХАЙГУУЛ, ПЕТРОФИЗИК, ЛАБОРАТОРИЙН СУДАЛГАА БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУРШИЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч энэхүү мэдээллийг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал, зарчмыг үндэслэн боловсруулж, үр дүнгийн тайлал хийсэн тайлан, мэдээллийг цахим, мөн цаасан хэлбэрээр Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ. Гэрээлэгч нь петрофизик, лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор чөмөг чулуу /тавь хүртэл хувь/, шлам /тавь хүртэл хувь/, чулуулаг болон газрын тосны сорьц дээжийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын хилээр гаргаж болно. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч эдгээр дээжийг буцааж авах хүсэлтээ түүнийг гаргаснаас хойш нэг (1) жилийн дотор ирүүлэхгүй бол Гэрээлэгч нь уг сорьц, дээжийг өөрийн үзэмжээр ашиглана. Гэрээлэгч нь цооногт хийсэн туршилт үйлчилгээний ажил, туршилтаын олборлолтын тайлан, мэдээллийг тус (30) хоногийн дотор ирүүлнэ.

12.5 БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ, ГАЗРЫН ТОС ТУХАЙ ТАЙЛАНГУУД

Гэрээлэгч нь газрын тосны хайгуулын боловсруулсан мэдээлэл болон нөөцийн гооцоо, үнэлгээний тайлангуудыг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид түүний баталсан дүрмийн дагуу ирүүлж байна.

12.6 ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч нь олборлолтын үйл ажиллагаа явуулж буй цооног бүрээ олборлосон тос, хийн хэмжээ болон цооногийн монтажийн өөрчлөлтийг үзүүлсэн бүртгэлийг хөтөлж

ба холбогдох мэдээлэл, тайланг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчийн баталсан дүрмэнд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ.

12.7 АВТОМАШИН, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БА РИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

- а) Гэрээлэгч нь газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд зориулан импортлох автомашин, техник, тоног төхөөрөмжийн зураг тосол, техникийн баримт бичгийг Монгол Улсад оруулж прэхийн өмнө ГТГ-т ирүүлнэ.
- б) Барилга, байгууламжийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу барьж байгуулах бөгөөд зураг төслийг барилгын ажил эхлэхийн өмнө, барилгын ажилтай холбогдсон бусад баримт бичгийг ашиглалтанд хүлээн авахын өмнө ГТГ-т ирүүлнэ.

12.8 ХАМТАРСАН ХОРОО

Газрын тосны олборлолт эхэлмэгц Гэрээлэгч болон Засгийн газрын төлөөлөгч олборлолт явуулж байгаа бүх агууламжийн ашиглалтын үйл ажиллагаа, мэдээллийг судлах, түүнчлэн талуудын хоорондох асуудлыг зохицуулах зорилгоор хамтарсан хороо байгуулна.

12.9 БУСАД АШИГТ МАЛТМАЛ

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааныхаа явцад бусад ашигт малтмал илрүүлбэл энэ тухай ГТГ-т арван тав (15) хоногийн дотор мэдэгдэнэ. Эдгээр ашигт малтмал Монгол Улсын төрийн өмч байна.

12.10 НУУЦЛАЛ

Энэхүү гэрээний 12 дугаар зүйлд дурдсан бүх тайлан мэдээг нууцалж, нөгөө талын зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд дамжуулж үл болно. Дээр өгүүлсэн нууцлалын талаар хүлээх үүрэг нь дараах зүйлд хамаарахгүй. Үүнд :

- 1) аль нэг тал өөрийн ажиллагсад, хувь нийлүүлэгчид, зөвлөгчид, зээл олгох этгээдүүд, мөн Туслан гүйцэтгэгчид газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах шаардлагын хэмжээнд нууцлалыг задлана.
- 2) аль нэг тал нь дагаж мөрдөж буй зохих хуулийн хүрээнд, Гэрээлэгчийн харьяа байгууллагын үнэт цаас бүртгэгдсэн аливаа хөрөнгийн биржийн дүрэм журмын хүрээнд нууцыг задалж болно.
- 3) Гэрээлэгч нь хөрөнгө оруулж болзошгүй этгээдээ ГТГ-т мэдэгдэнэ. Уг этгээд нь мэдээллийн нууцыг хадгалах баталгаа гаргасан байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

13.1 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хавсралт Г-д заасан журам, болон

холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл Монгол, Англи хэл дээр давхар хөтөлнө.

13.2 БҮРТГЭЛ ТООЦООНЫ ТАЙЛАН

Гэрээлэгч нь бүртгэл тооцооны тайлангаа Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид энэхүү Гэрээний дагуу бүрдүүлж, хүргүүлж байна. Гэрээлэгч Монголд төлөөлөгчийн газраа нээсний дараа ийм бүртгэл тооцооны тайлангийн хувийг төлөөлөгчийн газартаа байлгах бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч түүнтэй хүссэн цагтаа танилцана.

13.3 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ

- а) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардал, санхүүгийн данс, дансны бичилт, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа төрдний гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, бусад баримт бичиг, бичилтүүд зэрэг газрын тосны үйл ажиллагааны талаарх бүхий л төлбөр тооцоог жил бүр шалгах эрхтэй. Түүнчлэн, тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад газар орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторг очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- б) Бүх баримт бичиг нь тэдгээрийн бий болсон цагаас таван (5) жил эсхүл хуульд заасан журмын дагуу шаардагдах хугацаанд хадгалагдаж, шалгуулахад бэлэн байна.
- в) Санхүүгийн хяналттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАЛЦАА

14.1 ЕРӨНХИЙ ТУСЛАЛЦАА

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж, энэ гэрээний зорилгыг биелүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг тусалцаа хүсч болохыг талууд хүлээн зөвшөөрч байна. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчээс газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бусад эрхээ хэрэгжүүлэхэд зохих дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчид туслуулахаар өөрийн нэг буюу хэд хэдэн ажилтныг томилон ажиллуулж болно.

14.2 БУСАД ТУСЛАЛЦАА

Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч өөрийн эрх хэмжээний хүрээнд Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах, ажиллах хүч бэлтгэх, тээвэрлэлт хийх, аюулгүй байдлыг хангах, газар ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлнэ. Эдгээр барилга байгууламж, сэдэв хэрэгсэл, ажиллах хүч дутагдсан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь тэдгээрээр хангах арга хэмжээ авна. Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс дээрх арга хэмжээний холбоотой гарсан зардлуудыг

Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид нохож төлөх бөгөөд уг зардлыг үйл ажиллагааны зардалд оруулна. Эдгээр нохон төлбөрийг тухайн үеийн ханшаар АНУ-ын ам. доллараар гүйцэтгэнэ.

14.3 ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛАГАА

Гэрээлэгч нь ГТГ-аас Гэрээт талбайд ажиллах Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд зориулан Гэрээт жил эхэлснээс хойш гуч /30/ хоногийн дотор ГТГ-г _____ -н ам.долларыг жил бүр төлнө.

14.4 ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛАГАА

Гэрээлэгч нь жил бүр Гэрээт жил эхэлснээс хойш гуч /30/ хоногийн дотор орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан _____ ам. долларыг гэрээт талбайд хамаарах орон нутгийн засаг захиргаанд төлнө.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ӨМЧИЙГ АШИГЛАХ, ӨМЧЛӨХ, ЭРХ БА ӨМЧ ШИЛЖҮҮЛЭХ

15.1 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн өртөг нь похөгдсөн тоног төхөөрөмж, барьж байгуулсан барилга байгууламж, материал түүхий эд нь Гэрээний хугацаа дууссаны дараа нэмэгдэл төлбөргүйгээр Монгол Улсын өмч болно.

Үүнд Гэрээлэгчийн түрээсээр авч ашиглаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бусад эд хөрөнгө хамаарахгүй болно.

15.2 ГАЗРЫН ТОСЫГ ЭЗЭМШИХ

Энэхүү Гэрээний 8 зүйлийн дагуу Гэрээлэгчийн хуваарьт түүхий тос хэмжээт хийсэн цэг дээр Гэрээлэгчийн мэдэлд шилжинэ.

15.3 ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оролцох эрх, үүргээ Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр бусдад шилжүүлж болно.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР, ХУРААМЖ БОЛОН ТӨЛБӨР

Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагаа явуулахтай холбогдсон татвар, хураамж, төлбөр нь Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актуудын дагуу зохицуулагдана. Гэрээлэгч нь Монгол Улсын аливаа хуульд болон энэхүү гэрээнд заагаагүй төлбөр, хураамжийг төлөмгүй.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ. ВАЛЮТ СОЛЛЦООНЫ ЭРХ

17.1 ГАДААД ВАЛЮТ

Гадаад валютыг худалдах буюу худалдан авахад Монгол Банкнаас тогтоосон тухайн өдрийн албан ханшаар тооцно.

17.2 ГАДААДЫН БАНКИНДАХЬ ДАНС

Гэрээлэгч Монгол Улсад болон хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютын данс нээх, гүйлгээ хийх, мөнгөн хөрөнгийг гадаадад гаргах ба чөлөөтэй ашиглах, хадгалах бүрэн эрхтэй болно.

17.3 ВАЛЮТ СОЛНХ ЭРХ

Гэрээлэгч нь валют солих дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- а) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бүхий л хөрөнгийг чөлөөтэй мөрвөх валютаар гаргаж, эдгээр валютыг 17.1-д заасан ханшаар Монгол Улсын ирилжааны банкаар дамжуулан төгрөгөөр солих;
- б) Хилийн чанадад мөнгөн хөрөнгөтэй байж, үүнийг чөлөөтэй зарцуулах;
- в) Өөрт ногдох гэрээт түүхий тосыг экспортолох, худалдах буюу солих замаар хилийн чанадад олсон бүх орлогоо гадаадад байлгах, чөлөөтэй зарцуулах;
- г) Өөрт ногдох гэрээт түүхий тосыг худалдах, солих, экспортолох замаар Монгол Улсад олсон бүх орлогоо гадаадад гаргах буюу чөлөөтэй зарцуулах;
- д) Энэ гэрээний дагуу Монгол Улсад төлөх төлбөр, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бусад төлбөрийг гүйцэтгэхийн тулд Гэрээлэгчийн сонгож авсан Монгол Улсын банкинд данстай байх.

17.4 ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР

Гэрээлэгч тал энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөрийг АНУ-ын доллараар хийнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСАД

18.1 МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСДЫГ СОНГОХ ТУХАЙ

Гэрээлэгч ба түүний туслан гүйцэтгэгчид нь:

- а) Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санал болгож буй үнэ, мэргэжлийн чадвар болон чанар нь Гэрээлэгчийн шаардлагыг хангаж байгаа нөхцөлд юуны өмнө монголын Туслан гүйцэтгэгчийг сонгох ба Туслан гүйцэтгэгчтэй Гэрээ байгуулахын өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид танилцуулж, тохиролцоно.
- б) Монгол Улсад үйлдвэрлэсэн материал, технологийн төхөөрөмж, техник хэрэгсэл болон өргөн хэрэглээний барааны үнэ, чөлөөтэй зөвхөн ишиггүйг хугацаагаар гадаадаас авч болох

материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, өргөн хэрэглээний бараатай жишиж болох нөхцөлд Монголд үйлдвэрлэсэн зүйлийг сонгоно.

- в) Ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа юуны өмнө зохих ёсны мэргэжилтэй монголын иргэдийг сонгож авахыг эрмэлзэнэ. Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хувь хэмжээнд багтаан эрх бүхий газраас зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр Гэрээлэгч нь нарийн мэргэжлийн ажлын байр, чухал албан тушаалд гадаадын ажиллагсдыг ажиллуулах эрхтэй. Гэрээлэгч нь Монгол Улсын Туслал гүйцэтгэгчийг сонгох. Монголд үйлдвэрлэсэн бараа, материал худалдан авах, Монгол Улсын ажиллагсдыг авч ажиллуулахын тулд Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүсч болох ба энэ зүйлийн дагуу Гэрээлэгчийн хүлээх үүрэг, нөхцлийг Засгийн газрын төлөөлөгчөөс Гэрээлэгчид урьдчилан мэдэгдсэн байхыг үзсэн зөвшөөрөв. Гэрээлэгч нь гэрээний дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж яваад үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа түр буюу бүрмөсөн алдсан тохиолдолд ажиллагсдал хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу толно.
- г) Ажиллах хүчний талаарх бүхий л асуудлыг Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- д) Гэрээлэгч нь Монгол Улсын газрын тосны мэргэжилтэй боловсон хүчинг ажиллуулахдаа Гэрээлэгчийн гадаадаас авч ажиллуулж буй ижил мэргэжил, боловсрол, ур чадвартай гадаадын мэргэжилтэн боловсон хүчний цалингийн дунджаас доошгүйгээр цалинжуулна.
- е) Гэрээлэгч нь өөрийн зардлаар Монгол Улсын иргэдийг сургах, дадлага хийлгэх замаар газрын тосны аж үйлдвэрийн бүх шатны боловсон хүчин бэлтгэхийг эрхэмлэнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ОНЦ БАЙДАЛ

19.1 ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БОЛОХ ОНЦ БАЙДАЛ

Онц байдал тохиолдоход Гэрээлэгч шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээг авах ба энэ тухай Засгийн газрын төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ.

19.2 ОНЦ БАЙДАЛ

- а) Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт онц байдал зарласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нь Гэрээт талбайгаас олборлох Гэрээлэгчийн хуваарьт тосыг нөхөн төлөх нөхцөлтэйгээр бүхлээр нь буюу хэсэгчлэн дайчлан авч болох бөгөөд олборлолтыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг Гэрээлэгчээс шаардаж болно. Талууд олборлолтын дээд хэмжээг харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.
- б) Газрын тосыг ийнхүү дайчлан авах тухай асуудлаар саналаа илэрхийлэх боломжийг Гэрээлэгчид олгоно.

- в) Газрын тосны ноц буюу түүнтэй холбогдох аливаа байгууламжийг дайчлан авах шийдвэр нь Монгол Улсын хуулийн дагуу Гэрээлэгчид зохих ёсоор мэдэгдэсний үндсэн дээр явагдах ба онц байдлыг зогсоох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 20.1 Давагдашгүй хүчин зүйл гэж гонд халдварт өвчний тархалт, дайн, үймгэн, самуун, бослого хөдөлгөөн, ажил хаялт, гал түймэр, үер, хүчтэй салхи, шуурга, газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт үзэгдлийг ойлгоно.
- 20.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээлэгч нь ямар нэгэн үүргээ биелүүлээгүй, гэрээнд заасан ямар нэгэн эрхээ эдэлж чадаагүй бол үйл ажиллагаагаа сэргээж үргэлжлүүлэх, эхлүүлэхэд шаардагдах үндэслэлтэй хугацааг нэмж, гэрээнд заасан болон тухайн Хайгуул, Олборлолтын үе дээр Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрснөөр нэмж тооцож болно.
- 20.3 Хэрэв нэг буюу түүнээс дээш үр ашигтай нээлтээс олборлож байсан буюу олборлож болох байсан газрын тосны үйлдвэрлэлийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас зогсоосон, хязгаарласан бол олборлож болох байсан хэмжээнд хүргэхийн тулд шаардагдах хугацааг 5 дугаар зүйлд заасан хугацаанд дээр нэмж тооцно. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн "хэмжээ" гэсэн ойлголт нь олборлолтын үйл ажиллагааг зогсоогоогүй тохиолдолд үр ашигтай нээлийн хүрээнд өрөмдсөн цоонуудаас олборлолтын төлөвлөгөөний дагуу олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн практикийн дагуу олборлож болох байсан газрын тосны нийт хэмжээг хэлнэ. Гэрээлэгч нь энд заасан олборлох ёстой газрын тосны нийт хэмжээний тухай Засгийн газрын төлөөлөгчид Хуанлийн жил бүрийн дараа ер (90) хоногийн дотор мэдэгдэж байна.
- 20.4 Гэрээлэгч нь 20 дугаар зүйлд заасан давагдашгүй хүчин зүйл тохиолдсон өдрөөс эхлэн 30 хоногийн дотор Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид эрх бүхий байгууллагаар нотлуулсан нотолгоог гаргаж өгнө.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 21.1 Хэрэв энэ гэрээнд гарын үсэг зурсны дараа (нэг зуун наяд) 180 хоногийн дотор гэрээ хүчин төгөлдөр болохгүй бол Гэрээлэгч нь ГТГ-г гэрээг цуцлах тухай мэдэгдэж болно.
- 21.2 Хэрэв Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш (нэг зуун хорь) 120 хоногийн дотор хайгуулын хөтөлбөрт ажлаа эхлээгүй бол ГТГ нь энэ гэрээг цуцална.
- 21.3 Хэрэв Гэрээлэгч энэ Гэрээг санаатайгаар зөрчсөн, уг зөрчлийг арилгах талаар Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс тогтоосон хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй, мөн Гэрээ хэрэгжүүлэх үүднээс хөтөлбөрт болон төсөвт ажлаа эхлээгүй бол Монгол Улсын Засгийн газар өөрийн төлөөлөгчийн саналын дагуу энэ Гэрээг цуцлах эрхтэй болно.
- 21.4 Хэрэв Монгол Улсын Засгийн газар 21.2, 21.3 зүйлийн дагуу эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэвэл Засгийн газрын төлөөлөгчид Гэрээлэгчид бичгээр

мэдэгдэл өгнө. Мэдэгдэл өгснөөс хойш 30 хоногийн дотор Гэрээлэгч нь дээрх зөрчлийг арилгаагүй буюу арилгаж эхлээгүй ба зөрчлийг арилахад нь давагдашгүй хүчин зүйл саад болоогүй, тасалдуулаагүй бол энэ гэрээг цуцлах шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч гаргана. Ийм шийдвэрийн эерэг Гэрээлэгч нь 22 дугаар зүйл дэх арбитрагийн тухай заалтыг ашиглах эрхтэй. Гэрээг цуцалсан тохиолдолд Гэрээлэгч нь тухайн гэрээг жинд хийгээгүй ажлынхаа голборийг ГТГ-т төшнө.

- 21.5 Гэрээг цуцалсны дараа Гэрээлэгч нь 15.1-д зааснаас бусад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа хэрэглэхээр түрээсэлсэн буюу өөрийн бүрэн эзэмшлийн зооворлож болох бүх эд хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргах эрхтэй.
- 21.6 Гэрээлэгч нь дараах тохиолдолд энэхүү гэрээг цуцлах эрхтэй ба энэ тухайгаа Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид 90 (ер) хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Үүнд:

- а) Гэрээг талбайд эдийн засгийн үр ашигтай газрын тос илрээгүй бол,
б) Олборлолтын хугацаа дууссан бол.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 22.1 Гэрээнд оролцогч талуудын хооронд уг гэрээний заалттай холбогдон гарах (түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх, хугацаа дуусах, цуцлах эсвэл сунгах) аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлээгүй бол маргааныг Монгол Улсын арбитраар шийдвэрлүүлнэ.
- 22.2 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүссэн эд хөрөнгийн маргааныг газрын тосны тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэнэ.
- 22.3 Газрын тосны тухай гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг хүчингүй болгох зэрэг гэрээтэй холбогдох асуудлаар үүссэн маргааныг Талууд хүсвэл НҮБ-ын Олон Улсын худалдааны эрх зүйн комисс (UNICITRAL)-ийн дүрмийн дагуу зохицуулан шийдвэрлүүлж болно.
- 22.4 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг дур мэдэн буюу зөвшөөрөлгүй явуулсан бол тухайн эгзээдийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад хэрэглэсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгө, олборлосон бүтээгдэхүүн, орлогыг Монгол Улсын эрх бүхий байгууллага хураан авч улсын орлогод шилжүүлнэ. Харин уг үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй байвал Монгол Улсын хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 22.5 Гэрээлэгч талууд нь энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгууллага, иргэдэд хохирол учруулсан бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцан хариуцна.

- 22.6 Гэрээлэгч талууд нь гэрээний үүргийг зорчсоноос учирсан хохирлыг гэрээнд буюу Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай тал нь нөхөн төлнө.
- 22.7 Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүрээр гэрээгээр туслан гүйцэтгэгч сонгосон тохиолдолд тухайн туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны улмаас учирсан бүх хохирлыг Монгол Улсын Засгийн газрын өмнө Гэрээлэгч хариуцна.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ

- 23.1 Гэрээлэгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна.

Үүнд:

- а) Тухайн төлөөлөгчийн газарт ажиллаж буй Гэрээлэгчийн төлөөлөгчид болон 23.3 дугаар зүйлд заасан Гэрээлэгчийн удирдах төвд факсаар явуулсан;
- б) Тухайн төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа Гэрээлэгчийн төлөөлөгчид хүргүүлж, түүнийг хүлээн авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд Гэрээлэгчийн төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс нь хүлээн авсан тухай хариу авсан, мөн мэдэгдлийн хувийг 23.3 дугаар зүйлд заасан Гэрээлэгчийн удирдах төвд факсаар явуулсан байх.

- 23.2 Гэрээлэгчээс Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараахь тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд :

Мэдэгдлийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид факсаар явуулсан;
Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчийн ажлын газарт хүргүүлж, түүнийг хүлээж авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс мэдэгдлийг хүлээн авсан тухай хариу авсан байх зэрэг болно.

- 23.3 Дээрх 23.1 ба 23.2-т заасан мэдэгдлийг дараах хаягаар илгээнэ. Үүнд :

- а) Монгол Улсын Засгийн газар :
Газрын тосны газар
18080 Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг,
Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37,
Утас: (976-11) 631208,
Факс: (976-11) 631239
- б) Гэрээлэгч :
DWM Петролеум AG
Bahnhofstr. 9
CH-6341 Ваар
Утас: 0041-(0)1-7181030
Факс: 0041-(0)1-7181039
E-Mail: info@dwm-ag.com

Гомас Флотман

- 23.4 Талууд нөгөө талдаа 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр мэдэгдэл хүлээж авах хаягаа өөрчилж болно.
- 23.5 Аль нэг тал нь нөгөө талын мэдэгдлийг хүлээж авахаас татгалзах буюу хүлээж авах боломжгүй тохиолдолд нөгөө талын эрх ашиг ямар нэг байдлаар хохирох ёсгүй.

ХОРИН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДААТГАЛ

- 24.1 Энэхүү гэрээний дагуу Гэрээлэгчийн явуулж буй бүх нийл үйл ажиллагааны хувьд Гэрээлэгч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгуулах үүрэгтэй.
- 24.2 Гэрээлэгч нь өөрийн Туслан гүйцэтгэгчдийг нэгэн адил даатгуулсан байхыг шаардах бөгөөд Гэрээлэгчийн шаардлагатай гэж үзсэн нэмэлт даатгал нь даатгалын гэрчилгээгээр баталгаажуулагдсан байх болно.
- 24.3 Гэрээлэгч болон Туслан гүйцэтгэгч нь эд хөрөнгө, ашиг сонирхлоо Монгол Улсын Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу тус Улсын даатгалын компанид даатгуулна.
- 24.4 Хэрвээ Монгол Улсын даатгалын компани ийм даатгалыг хийх чадваргүй буюу татгалзвал Гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр гадаадын даатгалын компаниар даатгуулж болно.
- 24.5 Даатгалын байгууллага болон Гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд гарсан хохирлыг Монгол Улсын Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ТАВ ДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗААЛТ

25.1 ХАВСРАЛТУУД

Хавсралт А, Б, В, Г - нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.

25.2 ХУУЛЬ

Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжтой нийцсэн байна.

25.3 САЙН САНАА

Талууд энэхүү гэрээний дагуу харилцаагаа сайн санааны зарчимд үндэслэж, нэгдмэл зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж, гарч болох аливаа үл ойлголцол, маргааныг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэхийг эрмэлзэнэ.


25.4 ГЭРЭЭНИЙ ХЭЛ

Гэрээг монгол, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүдийг ийнхүү үндэстэн хоорондоо зөрчилдвөл монгол хэлний хувилбар нь шийдвэрлэх хүчинтэй болно.

25.5 ГЭРЭЭ ХҮЧИН ТОГОЛДОР БОЛОХ, ГЭРЭЭНД НЭМЭЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ

1. Энэхүү гэрээг Монгол Улсын Засгийн газар баталсан өдрийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр гэж үзнэ.
2. Талууд харилцан тохиролцож энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газраар батлуулсанаар хүчин төгөлдөр болно.


ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ТӨЛӨӨЛЖ:



.....

ГТГ-ЫН ДАРГА Д. АМАРСАЙХАН

ГЭРЭЭЛЭГЧ "DWM ПЕТРОЛЕУМ
АГ" ИЙГ ТӨЛӨӨЛЖ:



.....

АЛЕКСАНДР БЕККЕР



ЦАГААН ЭЛС - XIII ТАЛБАЙН ТАЛААР
 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
 "DWM ПЕТРОЛИУМ АГ" -ИЙН
 ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
 ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ГЭРЭЭТ ТАЛБАЙ

ХАВСРАЛТ "А"

Энэхүү хавсралт "А" нь Газрын тосны газар, "DWM Петролиум АГ" -ийн хооронд 2009 оны 04 дугаар сарын 21 - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭТ ТАЛБАЙН ЗУРАГ



ЦАГААН ЭЛС - XIII ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
"DWM ПЕТРОЛИУМ АГ" -ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ "Б"

ГЭРЭЭГ ТАЛБАЙ

Энэхүү хавсралт "Б" нь Газрын тосны газар, "DWM Петролиум АГ" -ийн хооронд 2009 оны 04 дугаар сарын 21 - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭГ ТАЛБАЙН БАЙРЛАЛ

1. Талбайн нэр
2. Талбайн хэмжээ
3. Сэлбилцөлийн нэг

Цагаан Элс - XIII
11590 кв.км.

| Дугаар | Уртраг | Өргөрөг |
|--------|------------|-----------|
| 1 | 108°19'59" | 43°50'00" |
| 2 | 108°19'59" | 44°10'00" |
| 3 | 108°29'59" | 44°10'00" |
| 4 | 108°29'59" | 44°30'00" |
| 5 | 108°49'59" | 44°30'00" |
| 6 | 108°49'59" | 44°40'00" |
| 7 | 109°29'59" | 44°40'00" |
| 8 | 109°29'59" | 44°35'00" |
| 9 | 109°20'00" | 44°35'00" |
| 10 | 109°20'00" | 44°10'00" |
| 11 | 109°40'00" | 44°10'00" |
| 12 | 109°40'00" | 43°55'00" |
| 13 | 110°00'00" | 43°55'00" |
| 14 | 110°00'00" | 44°10'00" |
| 15 | 110°10'00" | 44°10'00" |
| 16 | 110°10'00" | 44°20'00" |
| 17 | 111°00'00" | 44°20'00" |
| 18 | 111°00'00" | 43°50'00" |

**ЦАГААН ӨЛС-ХИИ ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ**

(-) Хасах

ХАВСРАЛТ “В”

**ГЭРЭЭТ ТАВАН ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,
ЗАВАЛ ХИЙХ НААД ЗАХЫН АЖИЛ, ҮҮРЭГ.**

| Үе Шан | Гэрэл Жил | Хайгуулах Ажлын Төлөвлөгөө | Зардал | Жилийн Хөрөнгө Оруулалт |
|-----------|--------------|--|-----------|-------------------------------|
| I | 1 | Геологийн мэдээлэл цуглуулах | 150,000 | 625,000 |
| | | Газарууны геологийн судалгааны өрмд 4000 кв.км | 40,000 | |
| | | Геологийн Зураглал 500 кв.км | 50,000 | |
| | | Геологийн Зураглал 100 кв.км | 30,000 | |
| | | Геологийн бүтэц тодорхойлох 400 кв.км | 140,000 | |
| | | Литолог бүтэц тодорхойлох 900м | 95,000 | |
| | | Палентологийн бүтэц тодорхойлолт | 40,000 | |
| | | Дээжлэл 300 | 15,000 | |
| | | Лабораторийн судалгааны ажил | 35,000 | |
| | | Мэдээлэл тайлал | 30,000 | |
| II | 2 | Геологийн Зураглал 850 кв.км | 85,000 | 825,000 |
| | | Геологийн Зураглал 400 кв.км | 120,000 | |
| | | Литолог бүтэц тодорхойлох 3200м | 160,000 | |
| | | Палентологийн бүтэц тодорхойлолт | 80,000 | |
| | | Дээжлэл 800 | 40,000 | |
| | | Лабораторийн судалгааны ажил | 75,000 | |
| | 3 | Тайлан боловруулалт | 55,000 | 1,740,000 |
| | | Тайлан боловруулалт | 15,000 | |
| | | Байр зүйн зураглал | 50,000 | |
| | | 2D чичирхийллийн судалгаа, 200 кв.км | 1,600,000 | |
| III | 4 | 3D чичирхийллийн судалгаа, 5 кв.км | 75,000 | 4,360,000 |
| | | Тайлан боловруулалт | 40,000 | |
| | | Байр зүйн зураглал | 20,000 | |
| | | 2D чичирхийллийн судалгаа, 100 кв.км | 800,000 | |
| | | 3D чичирхийллийн судалгаа, 20 кв.км | 300,000 | |
| | | Өрөмдлөгийн бэлтгэл ажил, 1 цооног | 20,000 | |
| | | Цооног өрөмдөлт, 1 цооног | 2,870,000 | |
| III | 5 | Цооногийн геофизикийн судалгаа, 1 цооног | 300,000 | 6,900,000 |
| | | Тайлан боловруулалт | 50,000 | |
| | | Өрөмдлөгийн бэлтгэл ажил, 2 цооног | 60,000 | |
| | | Цооног өрөмдөлт, 2 цооног | 5,740,000 | |
| | | Цооногийн геофизикийн судалгаа, 1 цооног | 600,000 | |
| | | Цооногийн туршилт үйлчилгээ, 3 цооног | 450,000 | |
| | | TOTAL | | 14,450,000 |

ЦАГААН ЭЛС-ХИШ ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-НИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ “Г”

БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРАМ

НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ

ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

1. НЭР ТОМЬЁО

2009 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2 дугаар зүйлд тодорхойлсон нэр томьёонууд энэхүү Бүртгэл тооцооны журамд хамаарах бөгөөд адилутга агуулна.

2. БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРМЫН ЗОРИЛГО БОЛОН
БАРИМТ БИЧГИЙН ДАВАМГАЙЛАХ БАЙДАЛ

Гэрээний дагуу зарцуулсан зардал, эд хөрөнгийн өртгийг үнэн зөв тооцоолох аргыг тодорхойлоход бүртгэл тооцооны журмын зорилго нь оршино. Хэрэв энэхүү арга нь ГТГ буюу Гэрээлэгчийн хувьд шударга бус, зохисгүй байна гэж үзвэл талууд тохиролцон зохих өөрчлөлтүүдийг оруулна.

Энэхүү бүртгэл тооцооны журмын заалтууд гэрээний заалттай үл тохирох буюу зөрчилдөх аливаа тохиолдолд олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийгмэл зарчмыг баримтлана.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГУУД

- а) Гэрээлэгч нь ГТГ-т хайгуулын ажлын туршид хуанлийн улирал бүрийн эцсээс хойш гуч (30) хоногийн дотор дараах тайлангуудыг шилжүүлнэ. Үүнд:
1. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;
 2. орлого зарлагын тайлан;
- б) Олборлолтын үед Гэрээлэгч нь ГТГ-т хуанлийн улирал бүрийг дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор дараах тайлангуудыг гаргаж өгнө. Үүнд:
1. олборлолтын тайлан;
 2. олборлолтын үнэлгээний тайлан;
 3. зардал тус бүрээр гаргасан өртөг нөхөлтийн тайлан;
 4. орлого зарлагын тайлан;
 5. хуваах тус ба ашигт тосны тайлан;
 6. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;

Дээрх тайлангуудыг хуримтлагдсан дүнгээр бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн олонүзлэлийн стандарт болон энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу хийж, тайлант жил дууссаны дараа жар (60) хоногийн дотор ГТГ-г гаргаж өгнө.

4. САИХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- а) Гэрээний 13 дугаар зүйлийн дагуу шалгалт хийхдээ, Засгийн газрын төлөөлөгч нь өргөтг тосоор нөхөгдөх зардал, Гэрээлэгчийн санхүүгийн данс, дансны бичилт, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа торлийн гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, бусад баримт бичиг, бичилтүүд зэрэг газрын тосны үйл ажиллагааны талаарх бүхий л төлбөр тооцоог жил бүр шалгах эрхтэй. Түүнчлэн, Засгийн газрын төлөөлөгч нь тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад газар орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторт очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- б) Гэрээлэгчийн бүх баримт бичиг нь тэдгээрийн үүсэн байгуулагдсан өдрөөс хойш таван (5) жил эсхүл хуульд заасан журмын дагуу шаардагдах хугацаанд хадгалагдаж, шалгуулахад бэлэн байна.

5. ВАЛЮТ СОЛИХ

Гэрээлэгчийн газрын тостой холбогдох үйл ажиллагааны бүртгэл нь АНУ-ын доллараар хийгдэнэ. АНУ-ын доллараар гарсан бүх зардал нь зарцуулсан тоо хэмжээгээрээ бүртгэгдэнэ. Монгол улсын мөнгөн нэгжээр гаргасан зардлыг гэрээний 17 дугаар зүйлд заасны дагуу АНУ-ын долларт шилжүүлж, АНУ-ын доллараас бусад мөнгөн нэгжээр гарсан зардал нь тухайн валютыг Гэрээлэгчийн АНУ-ын долларын данснаас худалдан авсан тохиолдолд худалдан авсан үгээр АНУ-ын долларт шилжүүлэгдэх ба үүнээс бусад тохиолдолд Монгол Банкны албан ханшаар тооцно.

Монгол төгрөг болон АНУ-ын доллараас бусад валютыг АНУ-ын долларт шилжүүлсэн ханшаар бүртгэл хөтөлнө.

6. БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь бүртгэлийг Англи хэл дээр нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө.

7. БҮРТГЭЛИЙН ЖУРМЫГ ХЯНАХ

Энэхүү Бүртгэлийн журмыг Гэрээлэгч, ГТГ хоёр бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр ирээдүйн үйл ажиллагааг зохицуулахаар Засгийн газрын төлөөлөгч нь хянан шалгаж болно.

8. БҮРТГЭЛИЙН ЦАРИЙВЧИЛСАН АРГАЧЛАЛ

Гэрээлэгчийн төлөөлөр болсон өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч нь Гэрээ болон энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу боловсруулсан дансны гүйцэтгэлийг

бүдүүвч, зардлын нарийвчилсан ангилал, баримтлагдах зардлын товийн нарийвчлан тодорхойлсон хэлбэр, үйл ажиллагааны бичлэг болон бүртгэлийн аргачлалын талаарх саналыг ГТГ-г ирүүлж хэлэлцэнэ. Энэхүү аргачлалыг санхүүгийн нийтлэг бүртгэл, олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд хэвлэсэн зарчим, Монгол Улсын хууль, журмын дагуу боловсруулна. Ийнхүү хэлэлцээний дагуу Засгийн Газрын төлөөлөгчийн зөвшөөрснөөр Гэрээлэгч нь цаашид ашиглагдах дансны гүйлгээний бүдүүвч, зааварчлагыг боловсруулж ГТГ-г гаргаж огно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ ЗАРДАЛ, ОРЛОГО

1. НӨХӨН ТӨЛӨГДӨХ ЗАРДАЛ

Гэрээлэгч нь Гэрээний дагуу дараах зардлуудыг харинаж шууд төлөх бөгөөд эдгээр зардлуудыг Гэрээний 4 дүгээр зүйлийн дагуу ангилж, нөхөн авна.

а) Газрын эрх

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах барилга байгууламж барих талбайн эрх авахтай холбогдон гарсан зардал

б) Хөдөлмөр эрхлэлт

1. Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй ажиллагсдын цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, томилолт, хөдөлмөрийн чадвар түр алдах, тахир дутуугийн нөхөн олговорууд.
2. Гэрээлэгчийн Монголд ажиллахаар томилогдсон галаадын иргэдийн амьжиргааны, орон байрны болон бусад хөнгөлөлтүүд.
3. Засгийн газрын байгууллагаас хуулийн дагуу Гэрээлэгчийн ажиллагсдын цалин хөлсөнд хамааруулж ногдуулж буй хураамжтай холбогдсон зардлууд.

в) Ажиллагсдад үзүүлэх хөнгөлөлт, олгох тэтгэвэр, тэтгэмж

Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй гадаад болон монгол ажиллагсдын цалин хөлсөнд хамаарагдах ажиллагсдын амь нас болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдон гарах зардал.

Энэтг халагдсаны тэтгэмж монгол болон гадаад улсын ажиллагсдын хувьд адил байх бөгөөд тэтгэмжийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу зохицуулна.

г) Материал, тоног төхөөрөмж ба сэлбэг хэрэгсэл

Гэрээлэгчийн худалдаж авсан, түрээслэсэн буюу нийлүүлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл.

1. Худалдаж авсан материал

Гэрээлэгчийн худалдаж авсан материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардлыг тооцоход Гэрээлэгчид үзүүлсэн бүх хөнгөлөлтийг нь хасаад түүний жинхэнэ төлсөн үнийг энэхүү журмын 2 дугаар зүйлийн 3.1-г заасан үнэлгээний зарчмын дагуу тогтооно.

2. Гэрээлэгч буюу салбар байгууллагаас нийлүүлсэн материал

Гэрээлэгч нь аливаа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн өөрийн буюу салбар байгууллагынхаа ноцтоос авч нийлүүлэхээс бусад тохиолдолд Монголын иргэн, аж ахуйн нэгжээс худалдаж авна. Гэхдээ дээр дурдсан

нөөцөөс нийлүүлсэн материалын үнэ нь даатгал, нийлүүлэгчийн адил нөхцөлд гуравдахь этгээдээ тосгоотой эд зүйлийг худалдаж авч болох үнээс өндөр байх ёсгүй. Уг материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнэлгээг энэхүү журмын 2 дугаар зүйлийн 3.2-г заасны дагуу тогтооно.

3. Баталгаа

Гэрээлэгч нийлүүлж буй материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлдээ үйлдвэрлэгчийн буюу худалдагчийн чанарын баталгаанаас оор ямар нэгэн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд хэрэв нийлүүлсэн материал гэмтэл согогтой байвал үйлдвэрлэгч буюу худалдагчаас Гэрээлэгчид зорүүт нөхөн төлөх хүргэл үүнийг орлогод авахгүй.

4. Түрээс

Түрээсэлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнийг бодитой төлсөн үнээр тооцно.

д) Тээвэрлэлт

Газрын тосгой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг тээвэрлэхэд гарсан зардал

е) Үйлчилгээ

1. Гэрээлэгч нь гуравдагч этгээдээ зөвлөх, гэрээг үйлчилгээ болон хангамжаар үйлчлүүлэхтэй холбогдсон зардлын зөвшөөрлийг ГТГ-аас урьдчилан бичгээр авна. Уг зардал нь ижил төстэй ажил, үйлчилгээ үзүүлэх гадаадын болон Монголын байгууллагад төлөх зардалтай ойролцоо байна.

2. Гэрээлэгч болон түүний салбар байгууллагаас Монголд болон хилийн чанадад лабораторийн шинжилгээ хийх, загварчлах, геологи, геофизикийн боловсруулалт, тайлал хийх, инженерийн болон мэдээлэл боловсруулах зэрэг үйлчилгээний зардал нь тухайн үед олон улсын газрын тосны аж үйлдвэрт дагаж буй үнэлгээтэй дүйцэхүйц байна.

Гэрээлэгч буюу түүний салбар байгууллагаас үзүүлсэн үйлчилгээ нь ашиг нэмэлгүйгээр зарцуулсан зардлаар тооцогдоно. Уг зардал нь тухайн үйлчилгээг ижил нөхцөлөөр гүйцэтгэх бусад салбар байгууллага, гуравдагч этгээдэд гарах хэвийн зардлаас илүүгүй байна.

Шаардлагатай бол, тухайн үйлчилгээ, түүнийг зохион байгуулсаны зардал зэргийг баталсан баримтыг Гэрээлэгч, түүний салбар байгууллага, ГТГ-аар гаргуулан авна.

Гэрээлэгч, түүний салбар байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний зардал нь олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд газрын тосны компаниуд тэдгээрийн салбар байгууллагуудад төстэй үйлчилгээ үзүүлсний төлбөрт төлдөг зардлаас өндөр өртөгтэй бол тухайн зардлыг ГТГ нь энэхүү журмын 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хамааруулж өртөг нөхөлтөөс хасах эрх эдэлнэ.

ж) Хохирол болон алдагдал

Доорхи з) бүлгийн дагуу даатгалд хамрагдахаас бусад тохиолдолд газар хөдлөлт, гал түймэр, үер, шуурга, хулгай, осол буюу бусад Гэрээлэгчээс хамаарахгүй шалтгааны улмаас учирсан хохирол, алдагдлыг нөхөн сэргээхэд гарах бүхий л зардал, Гэрээлэгч нь хохирол болон алдагдалд орсон тухайгаа нийлэггүй ГТГ-г бичгээр мэдэгдэнэ.

з) Даатгалын зардал

Гэрээний 24 дүгээр зүйлд заасанчлан даатгалын компанитай байгуулсан гэрээний дагуу төлсөн даатгалын зардлыг өртөг нөхөлтийн тооцоонд оруулна.

и) Хэргийн анги, агуулах болон бусад байгууламж

Хэргийн ангиуд, агуулахууд, тэвэрлэлтийн болон холбооны систем, усан хамгааж, зам болон бусад байгууламжуудийг хадгалж хамгаалах, тоноглох, ажилдуулахтай холбогдон Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор гарч буй зардал.

к) Эрх зүйн зардал

Гэрээт галбай, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг хамгаалах, шүүх хурлын буюу хууль зүйн туслалцаа авсан, үүний дотор омгөөлөгчийн хөлс, шагнал, зөвлөхийн цалин хөлсний тодорхой хувь, мөн Гэрээний дагуух газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар талууд болон аль нэгний нь эсрэг шийдвэр гарсангай холбоотой зардал, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа буюу энэ гэрээний эсрэг чиглэсэн аливаа үйлдэл, гомдол, заргаас хамгаалах зорилгоор гэрээнд оролцогч талууд буюу аль нэг тал нь урьдчилан сэргийлэхээр авсан арга хэмжээний зардууд. Дээр дурдсан арга хэмжээг гэрээнд оролцогч талууд буюу аль нэгнийх нь хуулинд хэрэгжүүлсэн тохиолдолд тэдгээрт энэхүү үйлчилгээ үзүүлсний зөмх хэмжээний мөнгө төлнө.

л) Захиргааны зардал

1. Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС-1-ийн 82)-д заасны дагуу борлуулалт өртгийн аргад хамааралтай харууллагын төвөөр нь ангилдаг аргаар удирдлагын зардлыг тусад нь бүртгэнэ. Энэ зардалд Гэрээлэгчийн Монголд буюу гадаад дахь ерөнхий удирдлага (үүний дотор хувьцаа эзэмшигчид багтана / хянах, зөвлөх, үйлчлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнуудтай холбоотой гарсан зардлуудыг бүртгэнэ. Үүнд: Цалин хөлс, амралтын нөхөн олговор, нэмэгдэл урамшуулал, хуулийн дагуу буюу Засгийн газрын харьяа байгууллагаас ногдуулсан татвар хураамж, шимтгэл, удирдлагын байрлаж буй албан контор болон техник хэрэгсэл, тавилга, эд хогшил худалдан авах, түрээс, ашиглалтын зардал, шатахуун, томилолт сургалт зэрэг зардлуудыг оруулна. Гэрээний дагуу дээр дурдсан газрын тостой холбогдсон удирдлагын үйл ажиллагааны зардал нь газрын тостой холбогдсон гэрээлэгчийн жилийн зардлын **1.2%** хэтрэхгүй байна. Захиргааны зардлын бусад зардалд давхардуулан тооцохгүй.

2. Дээр дурьдсан захиргааны зардлыг бусад (энэ зүйлийн 1.а-к хүртэлх) зардалд давхардуулан тооцохгүй.

2. ОРЛОГО

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцаас орсон орлогыг зохих дансанд бүртгэж авна. Уг орлого нь дараах ажил гүйлгээнээс бүрдэнэ:

а) Гомдол заргаас авсан орлого

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх зарга, даатгалын орлого буюу хөрөнгө.

б) Гуравдагч талын орлого

Омч хөрөнгө ашиглуулсны, Гэрээлэгчээс үзүүлсэн үйлчилгээний буюу аливаа мэдээллийн төлбөр хэлбэрээр гуравдагч талаас олсон орлого.

в) Орлого бичилт

Өмнө нь дансанд бүртгэгдсэн гэмтэл согогтой материал, тоног төхөөрөмжид гүүний нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс Гэрээлэгчид буцаан олгосон нөхөн олговор.

г) Буцааж төлсөн төлбөр

Өмнө нь дансанд бүртгэгдсэн байсан зардлаас Гэрээлэгчид буцаан төлсөн түрээс, нөхөн төлбөр буюу бусад орлого.

д) Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг худалдах, экспортлох

Энэхүү гэрээнд тусгайлан заагаагүй бол Гэрээлэгч дансанд бүртгэлтэй байсан аливаа эд материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг салбар байгууллага, эсвэл бусад байгууллага, хувь хүнд худалдах, экспортлох буюу шилжүүлэх тохиолдолд уг шилжүүллийн дүн бүртгэлд тусгагдсан байна.

3. ЭД МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 1(г)-д заасны дагуу дансанд бүртгэлтэй эсвэл 2(д)-д зааснаар бүртгэлд тусгагдсан материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэлгээ дорх зарчмаар хийгдэнэ. Үүнд:

1. Доорх (3.2) зүйлд өөрөөр заагаагүй бол Гэрээлэгчийн худалдан авсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэ нь эдгээртэй адил чанарын барааны олон улсын зах зээл дэх үнэ, худалдан авах хэлэлцээр байгуулсан тухайн үед олон улсын зах зээлд давамгайлж байсан нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигтэй тохирч байх ёстой. Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн худалдан авах үнэ нь зохих тохиолдолд худалдааны болон бэлэн мөнгөний хямдралууд, нийлүүлэлтийн төлбөр, тээврийн болон хүргэх зардал, даатгал, татвар, гаалийн татвар, консулын төлбөрүүд болон бусад импортын бараанд ногдуулах төлбөрүүдийг урьд өмнө өөр тооцоонд оруулсан эсэхийг харгалзан үзэж хамруулна.
2. Салбар байгууллагуудаас худалдан авсан болон тэдэнд худалдсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг доорх (а), (б)-д заасны дагуу үнэлнэ.
 - а) Шинэ эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь (А ангилал) Гэрээлэгчийн гэрээ байгуулах үеийн адил чанарын барааны олон улсын зах зээлийн үнэ, нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигт нийцэж байх.
 - б) Хэрэглэж байсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд (Б, В ангилал).
 - i) Эвдрэлгүй, гэмтэлгүй, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглаж байгаа засвар үйлчилгээ шаардагдахгүй ашиглах боломжтой түүхий эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь Б ангилалд хамрах бөгөөд дээрх (а)-д тодорхойлсон шинэ материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн 75 хувиар (75%) үнэлэгдэнэ.
 - ii) Б ангилалд хамруулах боломжгүй материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд, гэхдээ:
 - ♦ засвар үйлчилгээний дараа үндсэн зориулалтаар нь Б ангилалын дагуу хэрэглэж байсан боловч сайн эд материал, тоног төхөөрөмж

болон сэлбэг хэрэгслүүдийн ажил дахин ашиглах боломжтой;
эсвэл

- * үндсэн зориулалтаараа ашиглагдах боломжтой боловч ерөнхийдөө засвар үйлчилгээ хийх боломжгүй эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь В ангилалд орох бөгөөд дээрх (а)-д тодорхойлсон шинэ эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн тавин хувиар (эсвэл) үнэлэгдэнэ. В ангиллын эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнэ засвар үйлчилгээний өртөг нийлгээд Б ангиллын эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнээс хэтрэхгүй байх нөхцөлд, засвар үйлчилгээний үнэ өртийг засварлагдсан эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдэд оруулна.Б. В ангилалд орохгүй эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийг хэрэглээтэй нь уялдуулж үнэлнэ.
- ix) Эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн Газрын тосны үйл ажиллагаанд түр ашигласнаар 2)б)ii)-д заасны дагуу хямдруулах боломжгүй нөхцөлд эдгээр эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь хийгдсэн үйлчилгээний үнийн дүнтэй нийцэх дансны цэвэр тооцооны дүнд үндэслэн үнэлэгдэх болно.

4. ЗАРДЛЫН ТӨВҮҮД

Гэрээний дагуу нөхөн төлөгдөх зардалд үр дүнтэй хяналт хийх боломжийг хангах зорилгоор бүх зардлуудыг зардлын төвүүд болон тэдний дэд ангилалуудад хуваан ангилж, ГТГ-г танилцуулна.

Нарийвчилсан ангиллыг Хавсралт "Г"-ын 1.8 дугаар зүйлийн дагуу тохиролцоно. Гэхдээ доорх ангилалууд заавал хийгдэнэ. Үүнд:

- а) Талбай тус бүрээр зардлууд дараах маягаар хуваарилагдана:
 - 1. Хайгуулын талбай.
 - 2. Олборлолтын талбай нэг бүрчлэн.
 - 3. Дамжуулах хоолой гэх мэт талбайн гадуур үйл ажиллагааны зардал.
 - 4. Тодорхой талбайд хамааруулах боломжгүй зардлууд.
 - 5. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт
- б) Газрын тосны үйл ажиллагаа бүрт зардлууд дараах маягаар хуваарилагдана:
 - i) Хайгуулын үйл ажиллагаа. Үүнд:
 - 1. Агаарын, геологийн, геохимийн, палеонтологийн, топографийн болон бусад судалгаа.
 - 2. Чичирхийлэлийн судалгаа нэг бүрчлэн.
 - 3. Хайгуулын болон үнэлгээний цооног нэг бүрчлэн.
 - 4. Дэд бүтэц (зам, шисэх онгоцны буудал).
 - 5. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний өртөг хуваарилалт орно. Газрын тосны үйл ажиллагаатай холбоогдох зардлууд).
 - 6. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.

7. Бусад зардлууд.

ii) Олборлолтын үйл ажиллагаа. Үүнд:

1. Агаарын, геологийн, геохимийн, геофизикийн болон бусад судалгаа.
2. Олборлолтын цооног нэг бүрчлэн.
3. Хуримтлуулах шугамууд.
4. Талбайн байгууламжууд.
5. Хадгалах байгууламжууд.
6. Дамжуулах хоолой, тээврийн цистернууд.
7. Дэд бүтэц.
8. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний ортог хуваарилалт орно (Газрын тосны үйл ажиллагаатай холбогдох зардлууд).
9. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.

iii) Ашиглалтын үйл ажиллагааг олборлолтын үйл ажиллагаатай адил ангилна.

v) Олборлогдож, хадгалагдсан газрын түүхий тос болон байгалийн хийтэй холбогдох зардлыг дараах зарчмыг баримталж хуваарилна. Үүнд:

1. Зардлын дийлэнх хувь нь түүхий газрын тос эсвэл байгалийн хийн аль нэгэнд хамааралтай бол аль нэгэнд нь бүрэн хуваарилна.
2. Зардлыг түүхий тос болон байгалийн хий хоёуланд нь хамааруулах боломжтой тохиолдолд уг зардал нь талуудын харилцан тохиролцсон аргачлалын үндсэн дээр олон улсын газрын тосны аж үйлдвэрийн туршлагын дагуу хуваарилагдана.

5. **НӨХӨН ТӨЛӨГДӨХГҮЙ ЗАРДЛУУД**

Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Үүнд:

- а) Бүртгэл байхгүй болон биет зүйлийн хувьд зөрчилтэй зардлууд.
- б) Холбогдох Ажлын хөтөлбөр, Төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй, эсвэл Гэрээнд зөвшөөрөөгүй ангилалд хамрах зардал.
- в) Осол, гамшгийн улмаас гарсан зардлаас бусад Гэрээлэгчийн худалдан авсан бараа, гүйцэтгүүлсэн болон захиалсан үйлчилгээний үнэ тухайн үеийн адил чанарын бараа үйлчилгээний олон улсын зах зээлийн үнэ, олон улсын зах зээлд давамгайлж буй нийлүүлэлтийн адилхан нөхцөлийн үнийн жишгээс илүү гарсан зардал.
- г) Туслан гүйцэтгэгч болон нийлүүлэгчтэй байгуулсан холбогдох Гэрээтэй үл нийцэх бараа, үйлчилгээний төлбөрүүд.
- д) Дээрх "в" хэсэгт заасны дагуу эд материалын байдал үнэтэйгээ таарахгүй нөхцөлд энэ зөрчилтэй холбогдон гарсан нэмэгдэл зардал.
- е) Газрын тосны үйл ажиллагаанд онцын шаардлагагүй зардал. Үүнд нийлүүлэх цэгээс хойш гарах үйл ажиллагааны, тухайлбал газрын түүхий тосыг Монгол Улсаас гаргахаар ашигласан вагон мэтний тээврийн хэрэгсэлд авсаны дараах зардал.
- ж) Монгол Улсын бусад улсад төлсөн гатвар, хуримтжууд.

- з) Гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу төлөгдох урамшууллауд болон бусад төлбөрүүд.
- и) Шүүгч, Арбитрч буюу шинжээчийн асуудлыг өөрөөр шийдвэрлээгүй бол Гэрээний 22 дугаар зүйлийн дагуу шүүх, арбитражийн болон шинжээчдийн зардал.
- к) Монгол Улсын Шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан хүү, торгууль, авз.
- л) ГТГ-аас бичгээр зөвшөөрогдоогүй ажил үйлчилгээ, аливаа хандив тусламж
- н) Газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулсан шингэ тоног төхөөрөмж, материал болон аргачлал, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор судалгаа хийхтэй холбогдон гарсан зардал.
- о) Талбайн дэнчин
- ө) БХГ-ний 7 дугаар зүйлийн "в", "г" заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал
- ү) Зээлийн хүүгийн зардал
- ф) Төлөөлогчийн газрыг дэмжих зардал
- р) Орон нутгийн дэмжих зардал
- с) Гэрээт талбайд ажил гүйцэтгэсэн боловч холбогдох мэдээлэл, тайлан, баримт материалыг ГТГ-т хүлээлгэн өгөөгүй ажил, үйлчилгээний зардал
- г) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны теримыг зорчсоноос гарсан зардал

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

ТООЛЛОГО БОЛОН ТООЛЛОГЫН ТАЙЛАН

1. ТОГТМОЛ ТООЛЛОГО ХИЙХ, МЭДЭГДЭХ БОЛОН ТӨЛӨӨЛӨХ

ГТГ болон Гэрээлэгч харилцан тохиролцож тогтоосон зохих хугацаанд Гэрээлэгч үйл ажиллагааны бүх эд материал, биет хөрөнгө болон барилга угсралтын төслүүдийн тооллогыг явуулж байна. Тооллогод ГТГ оролцох боломжийг хангах үүднээс Гэрээлэгч тооллого эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн өмнө тооллого хийх тухай ГТГ-т бичгээр мэдэгдэнэ. Гэрээлэгч жил бүр доод тал нь нэг удаа, мөн Гэрээг цуцлах тохиолдолд тооллого явуулна.

2. ТООЛЛОГЫН БҮРТГЭЛИЙГ ТУЛГАН ШАЛГАЖ, ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

Гэрээлэгч, ГТГ хоёр хамтран эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг тулган шалгаад, илүүдэл буюу дуталтын жагсаалтыг гаргаж, Гэрээлэгч нь зөрүүт залруулна.

3. ТООЛЛОГЫН ТАЙЛАН

- а) Гэрээлэгч нь олон улсын газрын тосны аж үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу газрын тосны үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй эд хөрөнгийн нарийвчилсан бүртгэл хийнэ.
- б) Гэрээлэгч нь доорх зүйлүүдийг агуулсан тооллогын тайланг ГТГ-т удирдлагын тусламж ирүүлнэ. Үүнд:
 - 1. Хянах боломжтой бүх эд хөрөнгө, материалын тодорхойлолт болон үнэ.

2. Эд хоронго тус бүрийн дансанд бүртгэгдсэн үнийн дүн.
3. Эд хоронгийг дансанд бүртгэсэн он, сар, өдөр.
4. Эдгээр эд хоронгийн өртөг Гэрээний 15 дугаар зүйлийн дагуу нөхөгдсөн эсэх.

4. ТЭМДЭГЛЭГЭЭ

Эдгээр хавсралт "Г" -ийн 1.8 дугаар зүйлд зааснаар тохиролцсон аргуудын дагуу бүх эд хоронго нь хяналтын үйл ажиллагааг хялбарчлах зохих код буюу тэмдэглэгээтэй байх ёстой.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫГ ХЭМЖИХ БА ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАН

1. Олборлолтын тайлан доорх зарчмуудын дагуу бэлтгэнэ. Үүнд:
 - а) Хуваах тос буюу хий, өртөгт тос буюу өртөг нөхөх хийг Гэрээний VIII, IX зүйлд заасан талбайгаас олборлосон болон хадгалсан нийт түүхий тос буюу нийт хийн хэмжээг үндэслэн тодорхойлно.
 - б) Олборлосон хийгээд нөөцөлсөн түүхий тос болон хийн нийт хэмжээг Олборлолтын талбай дахь ачих цэгт өдөр бүр тодорхойлно. Уг талбайн ачих цэгт олон төрлийн эрэглэл бүхий түүхий тосыг юүлэх бөгөөд ийм түүхий тосны зэрэглэлийг ГТГ, Гэрээлэгчийн хооронд хэлэлцэн тохироогүй бол тус бүрчлэн ангилан тогтооно. Ачих цэг нь Олборлолтын талбайд байх агаад дамжуулах хоолой, төмөр зам, машинаар Олборлолтын талбайгаас тээвэрлэхээс өмнө энэ цэгт түүхий тосыг хэмжиж тодорхойлно.
 - в) Олборлож хадгалсан түүхий тос болон байгалийн хийг өдөр болгон баррелиар бүтээгдэхүүн хуваах цэг дээр, харин ГТГ, Гэрээлэгчийн харилцан тохиролцсон цэгт хэмжих ба тээвэрлэлтийн цэг(үүд)-ээр чанарын хувьд ялгаатай түүхий тос ирж байвал гэрээнд өөрөөр заагаагүй бол хэмжээг нь тусад нь тодорхойлно.
 - г) Түүхий тосны хэмжээг хэвийн температур, даралтад байхад нь тодорхойлох ба агуулах усны хэмжээ, тунамал хурдасны байдлаас шалтгаалан засвар оруулна. Түүхий тосны нягт, хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлолтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байх ёстой.
 - д) Байгалийн хийн хэмжээг хэвийн температур болон даралтад байхад нь тодорхойлно. Дулаан ялгаруулах чадвар (калоринность), хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлолтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байна.
 - е) Газрын тосны үйл ажиллагаанд зарцуулсан түүхий тосны хэмжээг өдөр болгон хэмжиж, бүртгэж байна. Эдгээр нь:
 - I. дахин шахах;
 - II. дахин боловсруулах;
 - III. хайгуул, олборлолтын болон дамжуулах хоолойд шахахад шаардагдах тус мэт талбайн үйл ажиллагааны эрчим хүчний хэрэглээг зарсан.
 - ж) Шаардлагагүй ууршсан түүхий тос, бусад хийг өдөр болгон бүртгэнэ.

3) Түүхий тосны бэлтгэл нөөцийн хэмжээг хуанлийн сар бүрийн эхэн, эцэст хамгийн Стаар нь тооцож тогтоосон байна.

2. Тухайн цооног ба талбайгаас анхны (туршилтын ба эдийн засгийн үр ашигтай) олборлолт эхэлмэгц олборлолтын талбай бүрээр доор заасан мэдээллүүдийг багтаасан олборлолтын тайланг Гэрээлэгч сар бүр гаргаж өгнө. Үүнд:

- а) Олборлож, хадгалсан түүхий тосны хэмжээ
- б) Олборлож, хадгалсан байгалийн хийн хэмжээ
- в) Өрөмдлөг явуулах, олборлох болон хадгалах сав уруу шахахад ашигласан түүхий тосны хэмжээ
- г) Ууршуулсан байгалийн хийн хэмжээ
- д) Сарын эхний түүхий тосны нөөцийн хэмжээ
- е) Сарын эцсийн түүхий тосны нөөцийн хэмжээ
- ё) Борлуулсан түүхий тосны хэмжээ

ТАВДУГААР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭ

1. Гэрээлэгч нь хуанлийн улирал бүр энэхүү Гэрээний дагуу олборлож, нийлүүлэх цэгт борлуулсан түүхий тос, байгалийн хийн үнэлгээг тооцоолсон тайланг бэлтгэх ёстой. Олборлолтын тайлангийн үнэлгээ нь дараах зүйлүүдийг агуулна. Үүнд:

- а) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улиралын турш гуравдагч этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- б) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улиралын турш гуравдагч этгээдээс өөр этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- в) Гэрээний 8-4 зүйл хамаарагдах тохиолдолд түүхий тосны үнэлгээ тогтоох зорилгоор газрын тос экспортологч гол гол орнуудын түүхий тосны үнэлгээний талаарх боломжтой мэдээлэл
- г) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан борлуулсан байгалийн хийн хэмжээ, үнэ

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

ӨРТӨГ НӨХӨЛТИЙН ТАЙЛАН

1. Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр дорх зүйлүүдийг агуулсан өртөг нөхөлтийн тайлан бэлтгэх ёстой. Үүнд:

- а) Хуанлийн улиралын туршид гарсан нөхөгдөх зардал;
- б) Хуанлийн улиралд нөхөгдөх нийт зардал;

- г) Хуанлийн улирлын туршид Гэрээлэгчийн авсан өртөгт тос ба өртөг нөхөлтийн байгалийн хийн хэмжээ, үнэ;
- д) Хуанлийн улиралд нөхсөн зардлын хэмжээ;
- е) Дараагийн хуанлийн улиралд шилжүүлэн нөхөгдөх зардал;

2. ХЯНАЛТЫН ТАЙЛАНГУУД

Гэрээлэгч нь өртөг нөхөлтийн данс ба тэнцүүлэх сөрөг данс нгээж нөхөгдөх зардлын үлдэж буй хэмжээ, нөхөгдсөн хэмжээг хянах бөгөөд энэ дансны мэдээллийг улирал бүр ГТГ-т гаргаж өгнө.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

ОРЛОГО ЗАРЛАГЫН ТАЙЛАН

Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр орлого зарлагын тайланг гаргаж өгнө. Энэ тайлан нь дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

- а) Энэхүү Бүртгэл тооцооны журамд тохирсон зардлын ангилал ба зардлын төвд үндэслэн, төсөвт тусгах хуанлийн жилийн зардал, орлого;
- б) Энэхүү Гэрээний дагуу нөхөгдөх зардал гэж тогтоосон, тухайн хуанлийн улиралд хуримтлагдсан зардал ба орлого;
- в) Хараахан шийдвэрлээгүй байгаа хуанлийн жилийн хуримтлагдсан зардал ба орлого;
- г) Төсөвт оруулах Гэрээний дагуу зөвшөөрсөн өөрчлөлтүүд;
- д) Жилийн эцсийн хуримтлагдсан зардлын урьдчилсан тооцоо;
- е) Дээрх (г) зүйлийн дагуу засварласан төсөв ба урьдчилсан тооцооны хоорондын ялгаа, тайлбар.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

ХУВААХ ТОС БА АШИГТ ТАЙЛАН МЭДЭЭ

Гэрээлэгч доорх тайлан, мэдээг улирал бүр ГТГ-т ирүүлнэ. Үүнд:

- а) Тухайн улирлын турш олборлосон Түүхий тос;
- б) Тухайн улирлын эцэст олборлосон болон хуримтлагдсан Түүхий тосны хэмжээ;
- в) Тухайн улирлын ГТГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тос;
- г) Тухайн улирлын эцэст ГТГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тосны хуримтлагдсан нийт хэмжээ;
- д) Тухайн улиралд Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хэмжээ;
- е) Тухайн улирлын эцэст Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хуримтлагдсан хэмжээ;

12

ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ЦАГААН ЭЛС-ХИ II ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-НИЙ
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ

ГЭРЭЭ

2009 оны 04 дугаар сарын 21-ний өдөр

| | |
|--|-----------|
| БРОИХНИЙ ЗҮЙЛ..... | 5 |
| НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨЛӨӨЛӨГЧИД..... | 5 |
| 1.1. Төлөөлөгч томилгох..... | 5 |
| 1.2. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ХЯНАН ШАЛГАХ ЭРХ..... | 5 |
| ХОЁР ДУГААР ЗҮЙЛ. ТОДОРХОЙЛОЛТУУД..... | 5 |
| 2.1. НЭР ТОМЬЁО..... | 5 |
| ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ..... | 9 |
| 3.1. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЭРХ..... | 9 |
| 3.2. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮҮРЭГ..... | 10 |
| 3.3. ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ..... | 10 |
| 3.4. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮҮРЭГ..... | 11 |
| ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАРДАЛ БОЛОН ӨРТӨГ НӨХӨЛГӨӨ | 12 |
| ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУГАЦАА..... | 13 |
| 5.1. Хайгуулын хугацаа..... | 13 |
| 5.2. Хайгуулын хугацааг сунгах..... | 13 |
| 5.3. НЭЭЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ..... | 14 |
| 5.4. ҮР АШИГТАЙ НЭЭЛТ..... | 14 |
| 5.5. ҮР АШИГТАЙ НЭЭЛТ, ТУРШИЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦАА..... | 14 |
| 5.6. ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙГ ХЯНАХ..... | 15 |
| 5.7. ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ..... | 15 |
| ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ХАЙГУУЛЫН АЖИЛ..... | 15 |
| 6.1. ЗААВАЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ..... | 15 |
| 6.2. ӨРӨМДӨХ АРГУУД..... | 15 |
| 6.3. ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР БА ТӨСӨВ..... | 16 |
| ДОЛДУГААР ЗҮЙЛ. ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.1. ГЭРЭЭ ЁСООР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.2. ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ..... | 16 |
| 7.3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ..... | 17 |
| НАЙМДУГААР ЗҮЙЛ. РОЯЛТИ БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ..... | 17 |
| 8.1. РОЯЛТИ..... | 17 |
| 8.2. ТҮҮХИЙ ТОС БОРЛУУЛАХ..... | 17 |
| 8.3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ..... | 17 |
| 8.4. ГЭРЭЭТ ТОСНЫ ҮНЭЛГЭЭ..... | 18 |
| 8.5. БОРЛУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО..... | 19 |
| 8.6. ДУТАЛТ БА ХЭТРҮҮЛЭЛТ..... | 19 |
| ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ..... | 19 |
| АРАВДУГААР ЗҮЙЛ. УРАМШУУЛАЛ, ШИМТГЭЛ БОЛОН БУСАД ТӨЛБӨРҮҮД..... | 19 |
| 10.1. УРАМШУУЛАЛ..... | 19 |
| 10.2. СУРГАЛТЫН УРАМШУУЛАЛ..... | 20 |
| 10.3. ТАЛБАЙН ДЭНЧИН..... | 20 |
| 10.4. ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ..... | 21 |
| 10.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ..... | 21 |
| АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЭМЖИЛТ..... | 22 |
| 11.1. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ХЭМЖИЛТ..... | 22 |
| 11.2. ХЭМЖИЛТИЙГ ЗАЛРУУЛАХ..... | 22 |
| 11.3. ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ..... | 22 |
| АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ..... | 23 |

| | | |
|---|---|-----------|
| 121 | ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨХ..... | 23 |
| 122 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ..... | 23 |
| 123 | ГЕОФИЗИКИЙН МЭДЭЭЛЭЛ..... | 23 |
| 124 | ХАЙГУУЛ, ПЕТРОФИЗИК, ЛАБОРАТОРИЙН СУДАЛГАА БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУРШИЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ..... | 23 |
| 125 | БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ, ГАЗРЫН ТОС ТУХАЙ ТАЙЛАНГУУД..... | 23 |
| 126 | ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ..... | 23 |
| 127 | АВТОМАШИНЫ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ..... | 24 |
| 128 | ХАМТАРСАН ХОРОО..... | 24 |
| 129 | БУСАД АШИГТ МЭЛТМАЛ..... | 24 |
| 1210 | НУУЦЛАЛ..... | 24 |
| АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ..... | | 24 |
| 131 | НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ..... | 24 |
| 132 | БҮРТГЭЛ ТООЦООНЫ ТАЙЛАН..... | 25 |
| 133 | САНХҮҮГИЙН ХЯНАЛТ..... | 25 |
| АРВАН ДОРОВДУГЭЭР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАЛЦАА..... | | 25 |
| 141 | ЕРӨНХИЙ ТУСЛАЛЦАА..... | 25 |
| 142 | БУСАД ТУСЛАЛЦАА..... | 25 |
| 143 | ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА..... | 26 |
| 144 | ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА..... | 26 |
| АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ӨМЧИЙГ АШИГЛАХ, ӨМЧЛӨХ, ЭРХ БА ӨМЧ ШИЛЖҮҮЛЭХ..... | | 26 |
| 151 | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖ..... | 26 |
| 152 | ГАЗРЫН ТОСЫГ ЭЗЭМШИХ..... | 26 |
| 153 | ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ..... | 26 |
| АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР, ХУРААМЖ БОЛОН ТӨЛБӨР..... | | 26 |
| АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ. ВАЛЮТ СОЛИЛЦООНЫ ЭРХ..... | | 27 |
| 171 | ГАДААД ВАЛЮТ..... | 27 |
| 172 | ГАДААДЫН БАНКИН ДАХЬ ДАНС..... | 27 |
| 173 | ВАЛЮТ СОЛИХ ЭРХ..... | 27 |
| 174 | ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР..... | 27 |
| АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСАД..... | | 27 |
| 181 | МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ..... | 27 |
| АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ОНЦ БАЙДАЛ..... | | 28 |
| 191 | ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БОЛОХ ОНЦ БАЙДАЛ..... | 28 |
| 192 | ОНЦ БАЙДАЛ..... | 28 |
| ХОРЬДУГААР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ..... | | 29 |
| ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ..... | | 29 |
| ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА..... | | 30 |
| ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ..... | | 31 |
| ХОРИН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДААТГАЛ..... | | 32 |
| ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗААЛТ..... | | 32 |
| 25.1 | ХАВСРАЛТУУД..... | 32 |
| 25.2 | ХУУЛЬ..... | 32 |
| 25.3 | САЙН САЛМ..... | 32 |
| 25.4 | ГЭРЭЭНИЙ ХЭЛ..... | 32 |

| | |
|-------------------|----|
| ОРУУЛАХ..... | 33 |
| ХАВСРАЛТ "А"..... | 34 |
| ХАВСРАЛТ "Б"..... | 35 |
| ХАВСРАЛТ "В"..... | 36 |
| ХАВСРАЛТ "Г"..... | 37 |

Энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээг нэг талаас Газрын тосны газар /цаашид ГТГ гэгддэгөө талаас "DWM Петролеум AG" /цаашид Гэрээлэгч гэнэ/-ийн хооронд /хамтад нь Тагруд гэнэ/ 2009 оны 04 дугаар сарын 21-ний өдөр байгуулав.

ЕРӨНХНИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллага болох ГТГ болон Гэрээлэгч нарын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хавсралтаар тодорхойлсон хайгуулын зорилдлаар ашиглах газрын тосны гэрээт талбайд Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эдэлнэ.

НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨЛӨӨЛӨГЧИД

1.1. ТӨЛӨӨЛӨГЧ ТОМИЛОХ

- а) Монгол Улсын Засгийн газар нь энэхүү Гэрээний дагуу Засгийн газрын төлөөлөгчөөр ГТГ-ын даргыг болон түүний эрх олгосон этгээдийг томилж байна.
- б) Гэрээлэгч энэхүү Гэрээний дагуу "DWM Петролеум AG" өөрийн төлөөлөгч (Гэрээлэгчийн төлөөлөгч)-өөр Александр Беккер болон түүний эрх олгосон этгээдийг томилж байна.
- в) Засгийн газрын төлөөлөгч болон Гэрээлэгчийн төлөөлөгчийг өөрчлөгдсөн тухай энэхүү Гэрээний 23 дугаар зүйлд заасны дагуу нөгөө талдаа мэдэгдэнэ.

1.2. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ, ХЯНАН ШАЛГАХ ЭРХ

- а) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч (эсвэл Засгийн газрын төлөөлөгчийн томилсон эрх бүхий этгээд) нь гэрээт талбайд нэвтрэх болон газрын тостой холбогдсон бүхий л үйл ажиллагаатай танилцах, хянан шалгах эрхтэй. Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчийг энэхүү эрхээ хэрэгжүүлэх бүрэн боломжоор хангана. Ийнхүү танилцахдаа, Засгийн газрын төлөөлөгч нь тодорхой шалтгаангүйгээр Гэрээлэгчийн үйл ажиллагаанд саад учруулахгүй.
- б) Хуулиар эрх олгогдсон этгээд газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай танилцах, хянан шалгах эрхтэй.

ХОЁР ДУГААР ЗҮЙЛ. ТОДОРХОЙЛОЛТУУД

2.1. НЭР ТОМЬЁО

Энэхүү Гэрээнд тодорхойлсон нэр томьёонууд болон тэднээс үндэслэсэн бусад ухагдахуун, хэлбэрүүд нь хэрэв тухайн тохиолдолд өөрөөр тайлбарлаагүй бол энэхүү 2 дугаар зүйлд заасан агуулгатай байна.

"Газрын тосны газар" гэж Монгол Улсын Засгийн газраас газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулах, түүнийг биелэлтэд хяналт тавих зэрэг олгосон байгууллагыг хэлнэ.

"Армз-ленгф худалдааны зарчим" гэж Гэрээлэгч гэрээт түүхий тосыг гуравдагч тээгдээлд (Гэрээлэгчийн өөрийн салбар нэгж бус)-д худалдаалах гэрээнд дараахь нөхцөлүүдийг тусгасаныг хэлнэ. Үүнд:

1. Гэрээт түүхий тосны үнийг бууруулсан, эсвэл бууруулахад чиглэсэн аливаа үгссэн хуйвалдааны шинжийг агуулаагүй байх;
2. Төлбөрийн чөлөөтэй хөрвөх валютаар хийх;
3. Гэрээт түүхий тосыг худалдаалахад санхүүгийн ямар нэгэн хөнгөлөлтийг илүүтэйгээр үзүүлэх; Тухайлбал: бараа солилцоо, үнийн хямдрал, нөхөн төлбөр зэрэг хөнгөлөлтийн хэлбэрүүдийг хэрэглээгүй байх;

"Байгалийн хий" гэж агаарын даралт, температурын хэвийн нөхцөлд мийн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлэх бөгөөд үүнд хүнд ба хөнгөн хий, газрын тосны олборлолтын хий болон хүнд хийгээс шингэн нүүрс-устөрөгчийг ялгаж авсны дараа үлдэх хий, түүнчлэн шингэн буюу хийжүүлсэн нүүрс-устөрөгчтэй хамт гарган авсан бусад хий тус тус багтана.

"Баррель" гэж 1.01325 барын агаарын даралтын дор Фаренгейтын жаран (60) хэмийн дулаанд буй буюу тийм нөхцөлд тааруулсан 158.987 литрийн хэмжээг хэлнэ.

"Бүртгэл тооцооны журам" гэж Хавсралтад заасан бүртгэл тооцооны журмыг хэлнэ.

"Бүтээгдэхүүн хуваах гэрээ" гэж гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар ГТГ болон Гэрээлэгчийн хооронд байгуулж, Монгол Улсын Засгийн газар баталсан гэрээг хэлнэ.

"Газрын тос" гэсэн ойлголтод газрын хэвлийд байгаа шингэн тос, хий болон хатуу байдалтай хамтад нь буюу дангаар нь олборлож болох нүүрс-устөрөгчийн төрөл бүрийн нэгдлийг хамааруулна.

"Газрын тосны тухай хууль" гэж 1991 оны 1 дүгээр сарын 18-ны -ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Газрын тосны тухай хууль, энэхүү хуультай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.

"Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам" гэж Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам", энэхүү журамтай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.

"Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа" гэсэн ойлголтод газрын тос хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, бууруулах ажиллагааг хамааруулна.

“Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх” гэж Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд тухайн гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах эрхийг зөвхөн Гэрээлэгч эдгэхийг хэлнэ.

“Гэрээлэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааг энэ гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу явуулахыг зөвшөөрч гэрээ байгуулсан “DWM Petroleum AG”-ийг хэлнэ.

“Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр” гэж энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газарбаталсан өдрийг хэлнэ.

“Гэрээт жил” гэж Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр буюу дараагийн жилүүдийн уг өдрөөс эхлэн тооцсон дараалсан хуанлийн арван хоёр (12) сарын хугацааг хэлнэ.

“Гэрээт талбай” гэж энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрээний хавьтлаар тодорхойлсон талбайг хэлэх бөгөөд энэ талбай нь 7 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх хэмжээгээр тухай бүр багасч байна.

“Гэрээт түүхий тос” гэж гэрээт талбайгаас олборлож хуримтлуулсан Түүхий тосыг хэлнэ. Уг нэр томъёог тайлбарлах үүднээс “олборлосон” гэдэг нь газрын хэвлийгээс гарган бүтээгдэхүүн хуваах хэмжүүрийн хэрэгсэлээр нэвтрүүлсэн. “хуримтлуулсан” гэдэг нь авч борлуулах боломжийг бүрдүүлсэн тосыг хэлнэ.

“Дагалдах байгалийн хий” гэж эдийн засгийн хувьд үр ашигтайгаар олборлож болох газрын тосыг дагалдан илэрсэн байгалийн хийг хэлнэ.

“Дагалдах бодис” гэж газрын тос ба байгалийн хийгээс гаргаж болох буюу тэдгээрийг дагалдан илэрсэн бусад бодисыг хэлнэ.

“Дүрэм” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны гөдөрхой төрлийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, горимыг хэлнэ.

“Захиргааны зардал” гэж Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарсан хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааны зардлаас бусад зардлыг хэлнэ.

“Нэгж талбай” гэж уртрагийн арван (10) минут, өргөргийн арван (10) минутын үржвэртэй тэнцэх хэмжээний газрыг хэлнэ.

“Нээлтийн цооног” гэж Үр ашигтай нээлт болох эсэхийг нь тогтоох шаардлагатай гэж Талууд үзэж буй байгалийн агууламжийг илрүүлсэн цооногийг хэлнэ.

“Орд” гэж нэг буюу хэд хэдэн цооногоор илрүүлсэн, геологийн бүтцээрээ болон давхарга зүйн онцлогоороо төсөөтэй бөгөөд газрын тос олборлож болох нэг буюу хэд хэдэн байгалийн агууламж бүхий талбайг хэлнэ.

“Олборлолтын зардал” гэж олборлолтын үйл ажиллагаатай холбогдон гарах бүх зардал (захиргааны болон хайгуулын зардлаас бусад)-ыг хэлнэ.

“Олборлолтын талбай” гэж Гэрээт талбай дахь Үр ашигтай нээлт бүхий талбайг хэлнэ.

“Олборлолтын үйл ажиллагаа” гэж нэг буюу хэд хэдэн Үр ашигтай нээлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

“Олборлолтын хугацаа” гэж Гэрээний 5.5 дугаар зүйлд заасны дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаа, мөн 5.7 дугаар зүйлд заасны дагуу сунгасан хугацааг хэлнэ.

“Олборлолтын хөтөлбөр” гэж үр ашигтай нээлттэй холбоотой Олборлолтын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлнэ.

“Өртөгт тос” гэж Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардыг нөхөхөд зориулах гэрээт түүхий тосыг хэлнэ.

“Роялти” гэж Монгол Улсын байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ.

“Талбай буцааж өгөх” гэж Гэрээний дагуу Гэрээлэгчээс гэрээт талбайг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаахыг хэлнэ.

“Талбайн дэнчин” гэж Гэрээлэгч гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх эдэлснийхээ төлөө Газрын тосны хуулийг хэрэгжүүлэх журамд заасны дагуу гэрээт талбайн хэмжээгээр нөхөн төлөгдөхгүйгээр ГТГ-г жил бүр төлөх төлбөрийг хэлнэ.

“Төсөв” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой үе шатанд хийгдэх ажлын хөтөлбөрийн мөнгөн илэрхийллийг хэлнэ.

“Туршилтын олборлолт” гэж нээлтийн болон үр ашигтай нээлтийн цооног мөн эсэхийг тогтоох зорилгоор цооногт олон улсын газрын тосны аж үйлдвэрт мөрддөг жишгийн дагуу явуулдаг туршилтын ажлын явцад хийх олборлолтыг хэлнэ.

“Туслах гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр Гэрээлэгчтэй гэрээ хийсэн аж ахуйн нэгж, иргэнийг хэлнэ.

“Түүхий тос” гэж газар доорхи байгалийн агууламжид байгаа, эсвэл гадаргуу дээр ялгагч болон боловсруулах төхөөрөмжөөр оруулан гаргасны дараа агаарын даралтад шингэн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлнэ. Түүнчлэн “түүхий тос” гэсэн нэр томъёонд байгалийн барагшин, конденсат ба ялгагч үйлдвэр, эсвэл боловсруулах бусад төхөөрөмжид шингэрүүлсэн байгалийн шингэн хий багтана.

“Үнэлгээний талбай” гэж үнэлгээний хөтөлбөрийн дагуу үнэлгээ хийх нь зүйтэй гэж Талуудын үзсэн геологийн нэг буюу хэд хэдэн бүтэц буюу илрэлийг хэлнэ.

“Үнэлгээний хөтөлбөр” гэж Нээлтийн цооногоор илрүүлсэн байгалийн агууламж нь Үр ашигтай нээлт болох эсэхийг тодорхойлох зорилгоор хийх ажлын төлөвлөгөөг хэлнэ.

“Үр ашигтай нээлт” гэж Гэрээлэгчийн гаргаж өгсөн олборлож болох тосны газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг үзүүлэлтэд тулгуурлан Талуудын боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу үр ашигтай олборлох боломжтой газрын тосны нэг буюу хэд хэдэн байгалийн агууламжийг хэлнэ.

“Хайгуулын зардал” гэж хайгуулын үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардал (захиргааны болон олборлолтын зардаас бусад) -ыг хэлнэ.

“Хайгуулын үйл ажиллагаа” -нд дараах үйл ажиллагаа багтана:

1. агаарын болон сансрын зураглал, геологи, геофизик, геохимийн судалгаа, керн авах, давхарга зүйн судалгаа явуулах, хайгуулын болон үнэлгээний цөөнөг оромдож ажиллуулах, мэдээллийн тайлал хийх болон дээрхтэй холбоотой бусад бүхний л үйл ажиллагаа;
2. тухайн үед үр ашигтай нээлтийн хүрээнд багтах нь тогтоогдсонгүй нэг буюу хэд хэдэн агууламжийг нээн илрүүлэх;
3. үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх.

“Хайгуулын хугацаа” гэж Гэрээний 5.1 дүгээр зүйлд заасны дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулах хугацаа, мөн 5.2 дугаар зүйлд заасны дагуу сунгасан хугацааг хэлнэ.

“Хуваах тос” гэж гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ.

“Хуанлийн сар” гэж аргын тооллын арван хоёр (12) сарын нэг (1) нь бөгөөд энэ нь тухайн сарын эхний өдрөөс эхлэн, сүүлчийн өдрийг дуусгал үргэлжилнэ.

“Хуанлийн улирал” гэж а/нэг, хоёр, гурав дугаар сарууд; б/ дөрөв, тав, зургадугаар сарууд; в/ долоо, найм, есдүгээр сарууд; г/ арав, арваннэг, арванхоёр дугаар сарууд зэрэг аргын тооллын улирлын нэгийг хэлнэ.

“Хуанлийн жил” гэж аргын тооллын 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусах нэг (1) жилийг хэлнэ.

“Хуулийн этгээд” гэж хуульд заасан журмаар хуулийн этгээд болох нь нотлогдсон аливаа аж ахуйн нэгжийг хэлнэ.

“Хууль тогтоомж” гэж Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актыг хэлнэ.

“Хэмжилт хийх цэг” гэж олборлосон түүхий тосоо худалдах зорилгоор гэрээт талбай дээр цэвэршүүлсэн тосыг хэмжих цэгийг хэлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЭРХ

а) Гэрээлэгчийн гаргаж өгсөн олборлох болох тосны газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг үзүүлэлтэд тулгуурлан Талуудын боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу үр ашигтай олборлох боломжтой газрын тосны нэг буюу хэд хэдэн байгалийн агууламжийг хэлнэ.

- б) Геологи, геофизик, гидрогеологи, геохими, петрофизик, лабораторийн шинжилгээ зэрэг газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүхий л мэдээллийн эх хувийг өмчилно.
- в) Гэрээлэгчийн явуулж буй үйл ажиллагаатай холбогдсон баримт бичиг болон хэрэглэж буй тоног тохоромж, багаж хэрэгсэл, барилга байгууламжийн заавар, техникийн тодорхойлолт, зураг зэрэг техникийн баримт бичгийн хувийг авна.
- г) Гэрээлэгчээс түүний хуваарьт Газрын тосыг Монгол Улсын дотоодын хэрэглээнд шилдүүлэхийг хүсэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үнийг дэлхийн зах зээлийн үнээр ам. доллараар толно.
- д) Монгол Улсын Засгийн газарт ногдох Газрын тосны борлуулалтанд хяналт тавьж, захиран зарцуулна.
- е) Энэхүү гэрээнд заагдсан бусад эрхийг эдэлнэ.

3.2. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮҮРЭГ

- а) Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад Гэрээлэгчид дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- б) Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, дүрэм, энэхүү Гэрээний бие даалтанд хяналт тавина.
- в) Энэхүү гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ.

3.3. ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ

- а) Гэрээлэгч нь Монгол Улсын Газрын тосны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү Гэрээний дагуу Гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх эдэлнэ.
- б) Зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр дамжуулах хоолой, гүүр, зам, орон сууц, агуулах байгууламж, нисэх онгоцны талбай, радио цамхаг, хөлбооны төхөөрөмж барьж байгуулна.
- в) ГТ-ын мэдээллийн санд хадгалагдаж буй гэрээт талбайд холбоотой урьд өмнө хийгдсэн хайгуул, геофизик, петрофизик, геохими, цооногийн талаарх мэдээ, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай тохиолдолд худалдан авах эрхтэй.
- г) Энэхүү Гэрээний дагуу өөрт ногдох газрын тосыг захиран зарцуулна.
- д) Гэрээлэгч нь Монгол Улсын хуулийн этгээд, иргэдийн нэгэн адил Монгол Улсын эрхзүйн хамгаалалтад байна.
- е) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оролцох эрх, үүргээ Засгийн газраас бичгээр зөвшөөрлийн үндсэн дээр бүрдэл шинжлүүлж болно.

- ё) Гэрээлэгчийн ажиллагаад болон гэрээт талбайд ажиллагаад хүнд өвчин тусах, байгалийн гамшигт гэрвэгдэх, гэмт халдлагад өртөх, нонтой осолд орох тохиолдолд Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газраас дэмжлэг хүснэ.
- з) Гэрээлэгч нь ажиллагааг ажилд авах, ажлаас халах, туслан гүйцэтгэгч сонгох, газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардлагатай бараа материал худалдан авах эрхтэй.
- ж) Гэрээнд заасан бусад эрхийг эдлэнэ.

3.4. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮҮРЭГ

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулахдаа дараах үүргийг хүлээнэ:

- а) Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, энэхүү хуультай холбогдон гарсан аливаа нэмэлт, өөрчлөлт, эрх бүхий байгууллагаас баталсан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад мөрдөх дүрэм, журам, Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээг дагаж мөрднө.
- б) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг олон улсын болон Монгол Улсын стандарт, дүрэм, журамд нийцүүлэн явуулна.
- в) Хэрэв хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчинг хамгаалахтай холбогдсон осол, зөрчлийг гарсан тохиолдолд холбогдох байгууллагууд болон ГТГ-т нэн даруй мэдэгдэж, уг зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авна.
- г) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсад оруулж ирж буй техник, технологи, тоног төхөөрөмж нь газрын тосыг үр ашигтай олборлох шаардлагад нийцсэн байна.
- д) Газрын тосны газар Гэрээлэгчийн хуваарьт газрын тосыг Монгол Улсын дотоодын хэрэгцээнд нийлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Гэрээлэгч өөрийн хуваарьт газрын тосыг тэргүүн ээлжинд Монгол Улсын дотоодын хэрэгцээнд нийлүүлнэ.
- е) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, үнэлгээний ажлын тайлангийн эх хувийг ГТГ-т хүлээлгэн өгсөн байна.
- ё) Монгол Улсын хүн ам, ан амьтан, байгаль, түүх, соёлын үнэт зүйл, газрын гадаргууг хамгаалах шаардлагатай дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Гэрээлэгч нь Монгол Улсын хүн ам, мал, ан амьтан, агаар, ус, түүх, соёлын үнэт зүйл, газрын гадаргуу, байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын төлөөлөгч болон эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;
2. Гэрээний хугацаа дуусах, гэрээ хүчингүй болох, эсхүл гэрээт талбайгаас төлөрхой хэсгийг буцааж өгөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгөноос бусад бүх тоног төхөөрөмж, байгууламж, зориулалт талбайгаас гаргаж, байгаль орчныг

нөхөн сэргээх;

3. Жил бүрийн олборлолтын хөтөлбөртөө хаах но~~н~~ Оногуудын талбайн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын хөтөлбөр, түүний сал~~т~~ Ихүүжилтийн талаар гутаах;
 4. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа яв~~уу~~ Уулахыг хориглосон нутаг дэвсгэрийн ойр орчимд үйл ажиллагаа яву~~уу~~ Улах тохиолдолд түүнийг хамгаалахтай холбогдсон тодорхой арга хэмжээ ав~~ч~~ Г хэрэгжүүлэх;
 5. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хайгу~~у~~ Үйл олборлолттой холбогдсон аливаа тээвэрлэлийг Монгол Улсын холбогдо~~х~~ Хуульд нийцүүлэн зохих дүрэм, журмын дагуу хүн амын эрүүл мэнд хүр~~э~~ Эзлэн байгаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр зохион байгуулна.
- ж) Гэрээт хугацаанд олж хуримтлуулсан геологи, гидрогеоло~~ги~~ Г, геохими, геофизикийн судалгаа, петрофизик, лабораторийн шинжилгээ, өрө~~м~~ Длөг, цооног, цооногийн гуршилт, олборлолтын болон бусад бүх анхдагч мэд~~э~~ Эзлэлийн эх хувь, тайлан баталсан дүрмийн дагуу бэлтгэж, жил бүр ГТГ-т өгнө.
- з) Газрын тосны салбарыг хөгжүүлэх, боловсон хүчин бэлт~~г~~ Э Хэд дэмжлэг үзүүлнэ.
- к) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны горимыг зөрч~~с~~ Сөний улмаас гарах бүх хохирлыг хариуцна.
- л) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэс~~т~~ Ийг гүйцэтгүүлдхээр Туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ГТГ-ын төлөөл~~л~~ Ийг санал өгөх эрхтэйгээр оролцуулах, туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмн~~ө~~ Гэрээний төслийг Засгийн газрын төлөөлөгчид урьдчилан танилцуулж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулах бөгөөд гэрээний нэг хувийг Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.
- м) Гэрээлэгч нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хий~~х~~ Эрх бүхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ГТГ-ыг оролцуулна.
- н) Гэрээлэгч нь ГТГ-ын төлөөлөгчидтэй газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар ажил төрлийн уулзалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулах бөгөөд уулзалттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.
- о) Гэрээлэгч нь газрын тостой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөлтэй уулзалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, өөрийн үйл ажиллагааг сурталчилж, танилцуулах бөгөөд уулзалттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ, ЗАРДАЛ БОЛОН ӨРТӨГ НӨХӨЛТ

- а) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг Гэрээлэгч хариуцна. Гэрээлэгч нь зардлаа нөхөхийн тулд нийт олборлосон гэрээт түүхий тосноос роялтийг хасаад үлдэх тосноос 40 хувийг зарцуулах эрхтэй. Гэрээнд оролцогч аль ч тал эдийн засгийн үр ашги тай нээлт болно гэсэн баталгаа гаргахгүй.

- б) Гэрээлэгчийн авч ашиглах эрхтэй нийт өртөгт төсны хэмжээ нь Гэрээлэгчийн газрын төстэй холбогдсон үйл ажиллагааны зардлуудын нийлбэртэй тэнцүү байна.
- в) Гэрээлэгч газрын төстэй холбогдсон үйл ажиллагааны явцад зарцуулсан өртөг, зардлаа борлуулалт хийсэн тухай бүр нөхөж авна. Гэрээлэгч нь үйл ажиллагааны нийт зардлаа нөхөж дуусгал үлдэгдэл нь дараагийн хуанлийн саруудад шилжигдэн тооцогдоно.
- г) Гэрээлэгч нь газрын төстэй холбогдсон үйл ажиллагаа явуулахад баримтлах төлөвлөлтийн болон бүртгэл тооцооны загварыг Засгийн газрын төлөөлөгчтэй лөхирх бөгөөд газрын төстэй холбогдох зардлын бүртгэлийн хувийг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө. Гэрээлэгч нь газрын төстэй холбогдох зардлын дүн болон эцэсэрийг нөхөж авах аргачлалын талаар Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ.
- д) Гэрээлэгч нь газрын төстэй холбогдох зардлыг давхардуулалгүйгээр хайгуул, олборлолтын болон үйл ажиллагааны зардал гэж ангилна.
 - 1) Дүгээр газрын төстэй холбогдох зардал нь дараах дарааллаар нөхөгдөнө.
 - 1 хайгуулын зардал;
 - 2 Захирааны зардал;
 - 3 олборлолтын зардал;
 - Тодруулга хийх үүднээс, олборлолтын зардал нь хайгуулын хугацаанд, хайгуулын зардал нь олборлолтын хугацаанд гарч болно гэдгийг зөвшөөрөв.
- е) Дээр дурьдсаныг үл харгалзан, 8.1 дүгээр зүйлийн дагуу төлөгдөх роялти болон 10 дугаар зүйлийн дагуу төлөгдөх урамшууллауд болон бусад төлбөрүүд нөхөн төлөгдөхгүй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУГАЦАА

5.1. ХАЙГУУЛЫН ХУГАЦАА

Хайгуулын ажил явуулах хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тав (5) жил байна. Энэхүү 5 жилийг 3 үе шатад ангилна. Нэгдүгээр үе шат нь 1 жил, хоёрдугаар үе шат нь 2 жил, гуравдугаар үе шат нь 2 жил байна.

5.2. ХАЙГУУЛЫН ХУГАЦААГ СУНГАХ

- а) Хайгуулын ажил явуулах хугацааг Газрын төсны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу сунгаж болно.
- б) Гэрээлэгч нь хайгуулын ажил явуулах хугацааг сунгах хүсэлт тавихдаа өмнөх хайгуулын үе шатны хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв, заавал гүйцэтгэх ажил үүргийг биелүүлсэн байна. Хайгуулын ажил явуулах хугацааг сунгахдаа дараагийн үе шатанд заавал хийх хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг Засгийн газрын төлөөлөгч батална.
- в) Хэрэв хайгуулын эцсийн хугацаа дуусгавар болох өдөр хүртэл үр ашигтай нээлт болох эсэх нь тодорхойгүй нээлийн цооног байгаа бол уг нээлийн цооног бүхий үр ашгийн талбайн хувьд нээлийн хайгуулын хугацаа нь дуусах төхөөлүүдийн аль нэг нь болох хүртэл хүчин төгөлдөр үргэжлэнэ. Үүнд:

1. тухайн нээлтийг үр ашигтай нээлт гэж тогтоох.
2. тухайн нээлтийг үр ашигтай бус нээлт гэж тогтоох.
3. нэмэгдэл хайгуулын хугацаа нь зургаан (6) сараас эхлүүгүй байна.

5.3 НЭЭЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

а) Хайгуулын цооногт хийсэн туршилтын ажлын явцад дараах хүснэгтээр тодорхойлсон тосны ундарга өгч байвал уг цооногийг нээлтийн цооног гэж үзэж Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ. Засгийн газрын төлөөлөгч нь нээлтийн цооног тогтоосон тухай мэдэгдсэн өдрийг тухайн нээлтийн цооногийн бүртгэсэн өдөрт тооцно.

| Цооногийн гүн (метр) | < 500 | 500-1000 | 1000-2000 | >2000 |
|---------------------------|-------|----------|-----------|-------|
| Тосны ундарга (тонн/өдөр) | 0.5 | 1.0 | 3.0 | 5.0 |

б) Хэрэв Гэрээлэгч тухайн нээлтэд үнэлгээ өгөх нь зүйтэй гэж үзвэл, уг Нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч тус Нээлт нь Үр ашигтай нээлт мөн эсэхийг тогтоох үнэлгээний хөтөлбөр ба төсөв, үнэлгээ хийгдэх талбай (үнэлгээний талбай)-н зураг, бусад тодорхойлолтыг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө. Засгийн газрын төлөөлөгч үнэлгээний хөтөлбөр, төсвийг баталсаны дараа Гэрээлэгч үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлнэ.

5.4 ҮР АШИГТАЙ НЭЭЛТ

а) Үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан, төсвэл нэг болон түүнээс дээш Нээлтүүд нь Үр ашигтай нээлт гэж тогтоогдвол Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ. Засгийн газрын төлөөлөгч үр ашигтай нээлт тогтоосон тухай мэдэгдсэн өдрийг тухайн Үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдөрт тооцно.

б) Үр ашигтай нээлт нэг бүрийг бүртгэсэн өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид олборлолтын хөтөлбөр, төсөв, олборлолтын үйл ажиллагаа явуулах талбай (олборлолтын талбай)-н зураг, олборлолтын талбайн зөвшөөрөл авахтай холбогдсон бусад тодорхойлолт, хүсэлтээ гаргаж өгнө. Газрын тосны газар олборлолтын хөтөлбөр, төсвийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор хянаж, олборлолтын хөтөлбөр, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзвэл ер (90) хоногийн дотор олборлолтын төлөвлөгөө, төсвийг баталж, газрын тос олборлох тухай шийдвэр гаргана. Хэрэв олборлолтын хөтөлбөр, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын төлөөлөгч олборлолтын хөтөлбөр, төсвийг батлах хугацааг нэг зуун наян (180) хоног хүртэл сунгах эрхтэй.

в) Гэрээлэгч нь Газрын тос олборлох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Олборлолтын үйл ажиллагааг эхэлнэ.

5.5 ҮР АШИГТАЙ НЭЭЛТ, ТУРШИЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦА

а) Үр ашигтай нээлт бүрийг тогтоох хугацаа нь туршилтын олборлолтыг оролцуулаад гурван зуун жар (360) өдөр хүртэл байна.

- б) Үр ашигтай нээлт бүрийн олборлолтын хугацаа нь тухайн үр ашигтай нээлтээс олборлолт явуулахыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш хорь (20) хүргэл жил байж болно.

5.6. ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ, ОЛБОРЛОЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙГ ХЯНАХ

Гэрээлэгч нь нэмэлт мэдээлэл буюу судалгааг үндэслэн үнэлгээний хөтөлбөр, олборлолтын хөтөлбөр болон талбайг өөрчлөх тухай шийдвэрээ гаргахаас арван таван /15/ хоногийн өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тэдгээрт өөрчлөлт оруулж болно. Гэхдээ 7 дугаар зүйлийн дагуу нэгэнт буцааж өгсөн гэрээт талбайн аль ч хэсгийг үнэлгээний болон олборлолтын талбайд оруулж болохгүй.

5.7. ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ

Гэрээлэгч нь боловсруулах үйлдвэр барих, шингэн тос, байгалийн хий тээвэрлэх хоолой тавих зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц шинээр барьж байгуулах тохиолдолд өрд ашиглах хугацааг Засгийн газрын төлөөлөгч хоёр удаа тус бүр таван (5) жилтээ илүүгүй хугацаагаар сунгаж болно. Гэрээлэгч нь олборлолтын хугацаа дуусахаас жараас (60) доошгүй хоногийн өмнө олборлолтын хугацааг сунгах саналаа Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгнө.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ, ХАЙГУУЛЫН АЖИЛ

6.1. ЗААВАЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

- а) Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг зуун хорь (120) хоногийн дотор Гэрээний Хавералт "В"-д заагдсан хайгуулын үйл ажиллагаа явуулж эхэлнэ. Хайгуулын хугацаанд заавал хийх ажил үүргийг биелүүлж, (Хавералт В)-д төлөвлөсөнөөс багагүй хэмжээний мөнгө зарцуулсан байна. Гэрээлэгч энэхүү үүргээ бүрэн биелүүлээгүй бол гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор ГТГ-т төлнө.
- б) Тухайн жил Гэрээлэгч заавал гүйцэтгэх ажил үүргээс илүү ажил, үүрэг гүйцэтгэж, төлөвлөснөөс илүү зардал гаргасан тохиолдолд дараа жилийн гүйцэтгэх ажил, зардал шилжүүдэн тооцож болно.
- в) Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эхний гэрээт жилд заавал гүйцэтгэх, ажил үүргийн баталгаа болгож Монгол Улсын Худалдаа хөгжлийн банк дахь Эскроу дансанд байршуулсан 1 /нэг/ сая ам. доллартай холбогдолтой асуудлыг ГТГ болон Гэрээлэгчийн хооронд 2008 оны 5 дугаар сарын 27-ний өдөр байгуулсан Эскроу дансанд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээний дагуу шийдвэрлэнэ.

6.2. ӨРӨМДӨХ АРГУУД

Гэрээлэгч нь 6.1-д заасан ажил үүрэг, хайгуулын нооног өрөмдөх ажиллагааг олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг дэвшилттэй аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Дараах тохиолдолд хайгуулын нооногийн өрөмдөхийг дууссанд тооцож, зардлыг өртөг нөхөх зардалд оруулна. Үүнд:

- а) өрөмдөх гүнд болон эсхүл зорилтот давхаргал хурим

- б) нэгдлийн дооног болсон.
- в) ором нь суурь чулуулагт хүрсэн.
- г) ором нь үд нэвтрэх биет, геологийн хэт халуун градиентэд хүрсэн.

6.3. ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР БА ТОСОВ

Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, цаашид гэрээт жил эхлэхээс ерээс (90) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч нь тухайн гэрээт жилд гүйцэтгэх хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг нэр төрөл бүрээр нарийвчлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөр батлуулна. Мөн өмнөх жилд хийсэн ажлын тайланг танилцуулж, ГТГ-г өгнө.

Тухайн гэрээт жил эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч хамтран хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг хянан хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч батална. Гэрээлэгч нь энэхүү ажлын хөтөлбөр, төсвийг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд өөрийн саналыг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид нэн даруй гаргаж өгнө. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч саналыг авснаас хойш ажлын арван таван (15) өдрийн дотор Гэрээлэгчтэй уулзаж, өөрчлөлтийг хянан хэлэлцэж батална. Хэрэв тухайн жилийн батлагдсан төсөвт ажлаас илүү ажил хийгдэх бол илүү хийсэн ажлын хэмжээ, зардлын төсвийн хэмжээг ГТГ-аар батлуулсанаар ортог нөхөгдөх зардалд тусгана.

ДОЛДУГААР ЗҮЙЛ, ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

7.1. ГЭРЭЭ ЁСООР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

Гэрээлэгч нь :

- а) Хайгуулын ажлын хугацааны эхний үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор гэрээт талбайн хорин тав (25)-аас тавин (50) хувийг буцаан өгч болно.
- б) Хайгуулын ажлын хугацааны хоёр дахь үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор гэрээт талбайн үлдсэн хэсгийн хорь (20) -оос гучин (30) хувийг буцаан өгч болно.
- в) Хайгуулын нийт хугацаа дуусахад үнэлгээний болон олборлолтын талбайнаас бусад бүх талбайг буцааж өгнө. Гэрээлэгч нь анхдагч гэрээт талбайг бүхэлд нь болон аль ч хэсгийг буцааж өгөхийн өмнө түүний гадаргуугийн унаган төрхийг анх байсан байдалд нь сэргээх арга хэмжээ авсан байна.
- г) Олборлолтын талбайг буцааж өгөхийн өмнө бүх цооногуудыг хааж битүүмжилж, олборлох, хадгалах, боловсруулах, дамжуулах бүх тоног төхөөрөмжүүдийг талбайгаас зайлуулж, талбайг хог хаягдлаас цэвэрлэн, хөрс, усны бохирдлыг арилгаж, талбайн гадаргуугийн унаган төрхийг сэргээсэн байна.
- д) Энэхүү зүйлийн “в”, “г” заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

7.2. ООРИЙН ХҮСЭЛТЭЭР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

- а) Гэрээлэгч энэхүү Гэрээний хавсралт "В"-д заасан ажил үүргээ гүйцэтгэсэн тохиолдолд талбайг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг өөрийн хүсэлтээр буцааж өгч болно. Ийнхүү сайн дураараа буцааж өгсөн хэсгүүдийг 7.1-д дурьдсан гэрээ ёсоор буцааж өгсөн талбайд оруулан тооцно.
- б) Гэрээлэгч нь энэхүү гэрээний хавсралт "В"-д заасан заавал гүйцэтгэх ажил үүргээ гүйцэтгээгүй талбайгаа сайн дураараа буцааж өгөх тохиолдолд гүйцэтгээгүй ажилд ногдох мөнгийг тухайн талбайг буцааж өгөхөөс гучаас (30) доошгүй хоногийн өмнө ПТГ-г төлнө.

7.3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ

Гэрээлэгч үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч үр ашигтай нээлт тогтоогдоогүй тохиолдолд уг үнэлгээний талбайг буцааж өгнө. Үнэлгээний хөтөлбөрийн дагуу заавал гүйцэтгэх ажил үүргээ гүйцэтгээгүй байгаа үнэлгээний талбайг сайн дураараа буцааж өгөх тохиолдолд гүйцэтгээгүй ажилд ногдох мөнгийг тухайн үнэлгээний талбайг буцааж өгөхөөс гучаас (30) доошгүй хоногийн өмнө ПТГ-г төлнө.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. РОЯЛТИ БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

8.1. РОЯЛТИ

1. Гэрээлэгч борлуулалт хийсэн тухай бүрт Гэрээт тосноос тосноос Роялти төлнө. Роялти нь нийт олборлосон гэрээт түүхий тосны [redacted] хувьтай тэнцүү байх ба роялтийг бэлэн мөнгөөр буюу эсвэл бүтээгдэхүүнээр /тосоор/ төлж болно.
2. Роялтид төлөх төлбөрийг 8.4 дүгээр зүйлд заасны дагуу тооцож, борлуулалт хийсэн тухай бүр төлнө. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч энэ талаар өөр журам тогтоож болох ба энэ тухайгаа Гэрээлэгчид гуч (30) хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

8.2. ТҮҮХИЙ ТОС БОРЛУУЛАХ

- а) Роялти болон Монгол Улсын Засгийн газарт ногдох гэрээт түүхий тосыг хэмжилт хийсэн цэгээс тооцох бөгөөд түүхий тосыг борлуулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Түүхий тосны үнэлгээг худалдан авагчтай хийсэн түүхий тос борлуулах гэрээнд төхирсон үнээр тооцно.
- б) Монгол Улсын Засгийн газар нь өөрт ногдох тосыг мөнгөөр авах тохиолдолд борлуулсан түүхий тосноос, тосоор авах тохиолдолд олборлож, хуримтлуулсан тосноос тооцох ба энэ тухайгаа хуанлийн улирал эхлэхээс гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Гэрээлэгчид бичгээр мэдэгдэнэ.

8.3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

- а) Хуанлийн сар бүрийн гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хасаад үлдэх хэмжээ (Хуваах тос)-г Монгол Улсын Засгийн газар болон Гэрээлэгчийн хооронд доорх хувиар хуваарилна. Үүнд:
 1. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 5000 баррельтэй тэнцүү буюу түүнээс бага байвал Монгол Улсын Засгийн газарт [redacted]

Гэрээлэгчид

2. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 5001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 10000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

3. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 10001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 15000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

4. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 15001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их боловч 20000 баррелээс бага байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

5. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррельтэй тэнцүү буюу түүнээс их байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

- б) Гэрээлэгчийн нөхөж авах зардлын үлдэгдэл нь зардал нөхөх талаар гэрээгээр тохирсон 40 хувиас бага байх тохиолдолд Гэрээлэгчийн зардлыг нөхөөд үлдсэн тосыг энэхүү гэрээний 8.3-ын "а"-д тохирсон хувиар Талууд хувааж авна.
- в) Гэрээт түүхий тосны өдрийн дундаж хэмжээг тогтоохдоо тухайн сард олборлосон түүхий тосны нийт хэмжээг тухайн сард олборлолт явуулсан өдрийн гоонд хуваана.
- г) Хуваах тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны үнэлгээг Гэрээний 8.4 дүгээр зүйлд заасны дагуу хийх бөгөөд Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны гөлбөрийг борлуулж дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор ГТГ-т төлөх бөгөөд эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд өөр хэлбэрээр гүйцэтгэж болно.

8.4 ГЭРЭЭТ ТОСНЫ ҮНЭЛГЭЭ

- а) Энэхүү Гэрээний 8.1 дүгээр зүйлд заасан, Монгол Улсын Засгийн газарт төлөх роялти, 8.3-т заасан хуваах тосны үнэлгээг худалдан авагчтай хийсэн түүхий тос борлуулах гэрээнд тохирсон үнээр тооцно.
- б) Роялти болон Монгол Улсын Засгийн газарт ногдох гэрээт түүхий тосыг Гэрээлэгч зуучлан борлуулах тохиолдолд түүхий тос борлуулах, тээвэрлэхтэй холбогдсон гэрээ байгуулахын өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид танилцуулж, харилцан тохиролцсон үндсэн дээр гурвалсан гэрээ байгуулна. Монгол Улсын нутаг дэвсгэртээ олборлосон Гэрээлэгчид ногдох түүхий тосны үнийг ижил зардал түүхий тосны дундажийн зах зээлийн борлуулсан өдрийн үнээр тооцно.

- в) Гэрээт түүхий тосны үнийн дүнг Гэрээлэгчийн армз-ленгф аргачлалаар чөлөөт хөрвөх талноогаар борлуулсан үгээр тоошио.

8.5 БОРЛУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

- а) Үр ашигтай нээлт бүрийн хувьд Гэрээлэгч нь хуанлийн улирал эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн дотор олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн шийтлэг аргачлалын дагуу Гэрээлэгчийн олборлож борлуулахаар тооцож буй түүхий тосны дээд хэмжээ, зах зээлийн үнэ болон холбогдох бусад хүчин зүйлүүдийн тухай урьдчилсан мэдээ Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.
- б) Гэрээлэгч гэрхүү мэдээнд Роялти, түүхий тосны үнэ болон Монгол Улсын Засгийн газар, Гэрээлэгчид ногдох Гэрээт түүхий тосны тооцоог багтаасан байна. Гэрээлэгч урьдчилан төлөвлөсөн хэмжээний газрын тосыг олборлохыг эрмэлзэнэ. Гэрээлэгч Үр ашигтай нээлт бүхий хэд хэдэн орд цооногоос олборлох хэмжээг нэгтгэн тооцож болно.

8.6 ДУТАЛТ БА ХЭГРҮҮЛЭЛТ

Аль нэг тал нь гэрээт түүхий тосоо зарим үед бүрэн хэмжээгээр нь авах боломжгүй байж болохыг хүлээн зөвшөөрч байна. (энэ тохиолдолд уг талыг дутуу авагч гэнэ). Ийм тохиолдолд нөгөө тал нь ашиглалтыг бүрэн хэмжээгээр үргэлжлүүлэн орлогыг өөрийн галдаа хуваарилж (энэ талыг хэгрүүлэн авагч гэнэ) болно.

Гэрээлэгч хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагчийн нөхөн авах түүхий тосны хэмжээг тооцон бүртгэнэ. Хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагч талд ногдох түүхий тосыг нөхөж өгнө. Гэхдээ энэ хуваарилалтыг үйлдвэрлэл, борлуулалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцлөөр хийж гүйцэтгэнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ, ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

Хэрэв үр ашигтай болох нь тогтоогдсон аливаа нээлтээс хий олборлох /түүхий тосны хамт буюу ямарваа нэг өөр хэлбэрээр/ бололцоотой бол уг хийг олборлож, борлуулах талаар Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчтэй харилцан тохиролцож, шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах давуу эрх эдэлнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ. УРАМШУУЛАЛ, ШИМТГЭЛ БОЛОН БУСАД ТӨЛБӨРҮҮД

10.1 УРАМШУУЛАЛ

- а) Гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал: Гэрээ Монгол Улсын Засгийн газраар батлагдсан өдрөөс хойш жар /60/ хоногийн дотор Гэрээлэгч ГТГ-т _____ -н ам.доллар төлнө.
- б) Олборлолт эхэлсний урамшуулал: Гэрээлэгч олборлолт эхлүүдсэн тохиолдолд олборлолт эхэлсний урамшуулал _____ ам.долларыг Олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор ГТГ-т _____

в) Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газарт олборлолт нэмэгдүүлсний урамшууллыг дараах тохиолдол бүрт 1/нэг/ удаа төлнө:

1. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 0-5001 баррелиас илүү гармагц [redacted] -н ам. доллар;
2. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 5001 баррелиас илүү гармагц [redacted] -н ам. доллар;
3. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 10001 баррелиас илүү гармагц [redacted] ам. доллар;
4. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 15001 баррелиас илүү гармагц [redacted] н ам. доллар;
5. Тухайн хуанлийн сард өдөрт олборлох Гэрээт түүхий тосны дундаж хэмжээ 20001 баррелиас илүү гармагц [redacted] ам. доллар;

10.2 СУРГАЛТЫН УРАМШУУЛАЛ

а) Гэрээлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш жил бүр Гэрээт жилийн эхнээс гуч (30) хоногийн дотор сургалтын урамшууллыг ГТГ-г төлнө. Үүнд:

- 1/1 дэх жил [redacted]
- 2/2 дахь жил [redacted]
- 3/3 дахь жил [redacted]
- 4/4 дэх жил [redacted]
- 5/5 дахь жил [redacted]

10.3 ТАЛБАЙН ДЭЛЧИН

а) Гэрээлэгч Монгол Улсын Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу Гэрээт талбайн хэмжээгээр дэнчин жил бүр Засгийн газарт төлнө.

- i. Хайгуулын ажлын эхний үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй) [redacted]
- ii. Хайгуулын ажлын хоёр дахь үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй) [redacted]
- iii. Хайгуулын ажлын гурав дахь үе шатанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт (Олборлолтын талбайг оруулахгүй) [redacted]
- iv. Эрэл, хайгуулын ажлын хугацааг Засгийн газрын шийдвэрээр сунгасан хайгуулын хугацаанд эрэл талбайн нэг хавтгай дөрвөлжин километрт ногдох (Олборлолтын талбайг оруулахгүй) [redacted]

в. Олборлолтын талбайн нэг хавтгай дөрвөлжин километр талбайд ногдох

б) Гэрээлэгч нь талбайн дэнчинг Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар /60/ хоногийн дотор, дараагийн гэрээт жилүүдийн талбайн дэнчинг тухайн гэрээт жил эхэлснээс хойш тус тус (30) хоногийн дотор тус тус төлөх бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчид төлбөр хийгдсэнийг нотлох баримт гаргаж өгнө.

10.4 ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

Гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газарт газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу захиргааны үйлчилгээний шимтгэл төлнө. Энэхүү шимтгэлд гэрээт талбай авах захиалга, хайгуулын хугацааг сунгах, олборлолтын талбай авах захиалга, олборлолтын талбайн хэмжээг өөрчлөх, олборлолтын хугацааг сунгах, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа эрх үүргийг шилжүүлэхэд төлөх төлбөрүүд орно.

Гэрээлэгч нь дор дурдсан захиргааны шимтгэл төлнө. Үүнд:

- а) Гэрээт талбай авах захиалга
- б) Хайгуулын хугацааг сунгах
- в) Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хайгуулын хугацааг сунгах
- г) Олборлолтын талбай авах захиалга
- д) Олборлолтын талбайн хэмжээг өөрчлөхөд
- е) Олборлолтын хугацааг сунгах
- ё) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа эрх, үүргийг шилжүүлэх

10.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ

Гэрээлэгч нь байгаль орчныг нөхөн сэргээх ажилд жил бүр дараахь байдлаар хөрөнгө, мөнгө зарцуулна.

- 1/ 1 дэх жил
- 2/ 2 дахь жил
- 3/ 3 дахь жил
- 4/ 4 дэх жил
- 5/ 5 дахь жил

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ХЭМЖИЛТ

11.1 БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ХЭМЖИЛТ

а) Гэрээнд оролцогч талуудын хооронд хуваах Гэрээт түүхий тосны хэмжээг тодорхойлох зорилгоор хэмжилтийг (Бүтээгдэхүүн хуваах хэмжилт) олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал зарчмыг үндэслэн гүйцэтгэнэ. Гэхдээ дээрхээс бусад (үүнд ганцаарчилсан цооногийн олборлолтыг хэмжээг тогтоох хэмжилт орно) зорилгоор оор гөрлийн хэмжилт хийгдэж болохыг харилцан тохиролцов.

б) Энэхүү хэмжих хэрэгсэл, хэмжилтийн аргачлал нь Монгол Улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна.

в) Энэхүү Гэрээнд заасны дагуу бүтээгдэхүүн хуваах хэмжилтийг Хэмжилт хийх цэг дээр хийнэ.

г) Талууд энэхүү 11 дүгээр зүйлд заасны дагуу бүтээгдэхүүн хуваах хэмжилт хийгдэхээс өмнө түүхий тосыг авч ашиглах эрхгүй болохыг харилцан хүлээн зөвшөөрөв.

11.2 ХЭМЖИЛТИЙГ ЗАЛРУУЛАХ

а) Хэрэв Гэрээлэгч нь Бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн аль нэг багаж хэрэгсэлд тохируулна хийх, засварлах эсвэл солихыг хүсвэл Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч эрх бүхий байгууллагад мэдэгдэж хянуулна.

б) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь бүтээгдэхүүн хуваах аливаа хэмжилтийг ямар ч үед ажиглах, үнэн зөвийг тодорхойлох зорилгоор шалгалт хийх эрхтэй. Хэрэв шалгалтаар хэмжилт нь олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг аргачлал болон стандартад нийцэхгүй болон нь илэрвэл Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч түүнийг залруулах арга хэмжээ авахыг Гэрээлэгчээс шаардана. Хэрэв Гэрээлэгч нь энэ шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор залруулах арга хэмжээ авч эхлээгүй, эхэлсэн ч явц нь удаашралтай байвал Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч олборлолтыг зогсоож, эрх бүхий хөндлөнгийн гүйцэтгэгчээр хэмжилтийг хийлгэж зардлыг Гэрээлэгчээр төлүүлнэ.

в) Гэрээлэгч хэмжилтийн алдаатай байх үеийн олборлолтын үнэн бодит хэмжээг тогтоож өмнөх хэмжилтийг залруулах бүхий л арга хэмжээ авна. Гэрээлэгч нь гүйцэтгэсэн залруулгын ажлын тухай тайланг ГТТ-т хүргүүлж батлуулна. Хэрвээ хэмжилтийн алдаа анх гарсан хугацааг тогтоох боломжгүй бол урьд хийгдсэн шалгалтын одор ба алдааг илрүүлсэн өдрийн хоорондох хугацааны дундах үеийг алдаатай хэмжилт эхэлсэн цагаар тооцно.

11.3 ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ

Гэрээлэгч олборлосон гэрээт түүхий тос болон бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн бүртгэлийн нэг хувийг хэмжилт хийсэн тухай бүр Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ. Эдгээр баримтуудыг таван (5) жилийн хугацаанд хадгалах бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь эдгээр бүртгэлтэй танилцах эрхтэй. Гэрээлэгч нь танилцах боломжийг хангах үүрэгтэй.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ

12.1 ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨХ

Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагааны хотолбор, тосов, судалгааны үр дүнд цуглуулсан геологи, геофизик, петрофизик, геохими, гидрогеологи, цооногийн хаалтын тайлан болон бусад бүх эх мэдээлэл, эдгээрийг боловсруулж тайлал хийж дүгнэсэн үр дүнгийн тайлан, геодези, байр зүйн мэдээлэл, зураг зэрэг мэдээллийн бүх эх хувийг өмчилнө. Хоёр тал газрын тосны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нөгөө талаасаа бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч талд шилжүүлэхийг хориглоно.

12.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ

Гэрээлэгч газрын тосны хайгуул, олборлолт, борлуулалт, ашиглалт, боловсруулах болон бусад үйл ажиллагааны тухай бүртгэлийг ГТГ-тай тохиролцсон загварын дагуу хөтөлнө. Эдгээр бүртгэлийг англи хэл дээр хөтөлнө. Гэрээлэгч нь энэхүү бүртгэл, тайлангийн хувийг гүйцэтгэсэн өдөр, сар, улирал, жилд нь Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө.

12.3 ГЕОФИЗИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч нь геофизикийн анхдагч мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс баталсан Дүрмийн дагуу нэг хувийг Засгийн газрын төлөөлөгчид өгнө.

12.4 ХАЙГУУЛ, ПЕТРОФИЗИК, ЛАБОРАТОРИЙН СУДАЛГАА БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУРШИЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч энэхүү мэдээллийг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал, зарчмыг үндэслэн боловсруулж, үр дүнгийн тайлал хийсэн тайлан, мэдээллийг цахим, мөн цаасан хэлбэрээр Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ. Гэрээлэгч нь петрофизик, лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор чөмөг чулуу /тавь хүртэл хувь/, шлам /тавь хүртэл хувь/, чулуулаг болон газрын тосны сорьц дээжийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын хилээр гаргаж болно. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч эдгээр дээжийг буцааж авах хүсэлтээ түүнийг гаргаснаас хойш нэг (1) жилийн дотор ирүүлэхгүй бол Гэрээлэгч нь уг сорьц, дээжийг өөрийн үзэмжээр ашиглана. Гэрээлэгч нь цооногт хийсэн туршилт үйлчилгээний ажил, туршилтаын олборлолтын тайлан, мэдээллийг тус (30) хоногийн дотор ирүүлнэ.

12.5 БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ, ГАЗРЫН ТОС ТУХАЙ ТАЙЛАНГУУД

Гэрээлэгч нь газрын тосны хайгуулын боловсруулсан мэдээлэл болон нөөцийн гооцоо, үнэлгээний тайлангуудыг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид түүний баталсан дүрмийн дагуу ирүүлж байна.

12.6 ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч нь олборлолтын үйл ажиллагаа явуулж буй цооног бүрээ олборлосон тос, хийн хэмжээ болон цооногийн монтажийн өөрчлөлтийг үзүүлсэн бүртгэлийг хөтөлж

ба холбогдох мэдээлэл, тайланг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчийн баталсан дүрмэнд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ирүүлнэ.

12.7 АВТОМАШИН, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

- а) Гэрээлэгч нь газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд зориулан импортлох автомашин, техник, тоног төхөөрөмжийн зураг тосол, техникийн баримт бичгийг Монгол Улсад оруулж прэхийн өмнө ГТГ-т ирүүлнэ.
- б) Барилга, байгууламжийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу барьж байгуулах бөгөөд зураг төслийг барилгын ажил эхлэхийн өмнө, барилгын ажилтай холбогдсон бусад баримт бичгийг ашиглалтанд хүлээн авахын өмнө ГТГ-т ирүүлнэ.

12.8 ХАМТАРСАН ХОРОО

Газрын тосны олборлолт эхэлмэгц Гэрээлэгч болон Засгийн газрын төлөөлөгч олборлолт явуулж байгаа бүх агууламжийн ашиглалтын үйл ажиллагаа, мэдээллийг судлах, түүнчлэн талуудын хоорондох асуудлыг зохицуулах зорилгоор хамтарсан хороо байгуулна.

12.9 БУСАД АШИГТ МАЛТМАЛ

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааныхаа явцад бусад ашигт малтмал илрүүлбэл энэ тухай ГТГ-т арван тав (15) хоногийн дотор мэдэгдэнэ. Эдгээр ашигт малтмал Монгол Улсын төрийн өмч байна.

12.10 НУУЦЛАЛ

Энэхүү гэрээний 12 дугаар зүйлд дурдсан бүх тайлан мэдээг нууцалж, нөгөө талын зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд дамжуулж үл болно. Дээр өгүүлсэн нууцлалын талаар хүлээх үүрэг нь дараах зүйлд хамаарахгүй. Үүнд :

- 1) аль нэг тал өөрийн ажиллагсад, хувь нийлүүлэгчид, зөвлөгчид, зээл олгох этгээдүүд, мөн Туслан гүйцэтгэгчид газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах шаардлагын хэмжээнд нууцлалыг задлана.
- 2) аль нэг тал нь дагаж мөрдөж буй зохих хуулийн хүрээнд, Гэрээлэгчийн харьяа байгууллагын үнэт цаас бүртгэгдсэн аливаа хөрөнгийн биржийн дүрэм журмын хүрээнд нууцыг задалж болно.
- 3) Гэрээлэгч нь хөрөнгө оруулж болзошгүй этгээдээ ГТГ-т мэдэгдэнэ. Уг этгээд нь мэдээллийн нууцыг хадгалах баталгаа гаргасан байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

13.1 НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хавсралт Г-д заасан журам, болон

холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл Монгол, Англи хэл дээр давхар хөтөлнө.

13.2 БҮРТГЭЛ ТООЦООНЫ ТАЙЛАН

Гэрээлэгч нь бүртгэл тооцооны тайлангаа Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид энэхүү Гэрээний дагуу бүрдүүлж, хүргүүлж байна. Гэрээлэгч Монголд төлөөлөгчийн газраа нээсний дараа ийм бүртгэл тооцооны тайлангийн хувийг төлөөлөгчийн газартаа байлгах бөгөөд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч түүнтэй хүссэн цагтаа танилцана.

13.3 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ

- а) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардал, санхүүгийн данс, дансны бичилт, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа төрдний гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, бусад баримт бичиг, бичилтүүд зэрэг газрын тосны үйл ажиллагааны талаарх бүхий л төлбөр тооцоог жил бүр шалгах эрхтэй. Түүнчлэн, тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад газар орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторт очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- б) Бүх баримт бичиг нь тэдгээрийн бий болсон цагаас таван (5) жил эсхүл хуульд заасан журмын дагуу шаардагдах хугацаанд хадгалагдаж, шалгуулахад бэлэн байна.
- в) Санхүүгийн хяналттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАЛЦАА

14.1 ЕРӨНХИЙ ТУСЛАЛЦАА

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж, энэ гэрээний зорилгыг биелүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг тусалцаа хүсч болохыг талууд хүлээн зөвшөөрч байна. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчээс газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бусад эрхээ хэрэгжүүлэхэд зохих дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь Гэрээлэгчид туслуулахаар өөрийн нэг буюу хэд хэдэн ажилтныг томилон ажиллуулж болно.

14.2 БУСАД ТУСЛАЛЦАА

Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч өөрийн эрх хэмжээний хүрээнд Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах, ажиллах хүч бэлтгэх, тээвэрлэлт хийх, аюулгүй байдлыг хангах, газар ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлнэ. Эдгээр барилга байгууламж, сэдэв хэрэгсэл, ажиллах хүч дутагдсан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь тэдгээрээр хангах арга хэмжээ авна. Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс дээрх арга хэмжээний холбоотой гарсан зардлуудыг

Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид нохож төлөх бөгөөд уг зардлыг үйл ажиллагааны зардалд оруулна. Эдгээр нохон төлбөрийг тухайн үеийн ханшаар АНУ-ын ам. доллараар гүйцэтгэнэ.

14.3 ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэрээлэгч нь ГТГ-аас Гэрээт талбайд ажиллах Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд зориулан Гэрээт жил эхэлснээс хойш гуч /30/ хоногийн дотор ГТГ-г _____ -н ам.долларыг жил бүр төлнө.

14.4 ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэрээлэгч нь жил бүр Гэрээт жил эхэлснээс хойш гуч /30/ хоногийн дотор орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан _____ ам. долларыг гэрээт талбайд хамаарах орон нутгийн засаг захиргаанд төлнө.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ӨМЧИЙГ АШИГЛАХ, ӨМЧЛӨХ, ЭРХ БА ӨМЧ ШИЛЖҮҮЛЭХ

15.1 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн өртөг нь похөгдсөн тоног төхөөрөмж, барьж байгуулсан барилга байгууламж, материал түүхий эд нь Гэрээний хугацаа дууссаны дараа нэмэгдэл төлбөргүйгээр Монгол Улсын өмч болно.

Үүнд Гэрээлэгчийн түрээсээр авч ашиглаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бусад эд хөрөнгө хамаарахгүй болно.

15.2 ГАЗРЫН ТОСЫГ ЭЗЭМШИХ

Энэхүү Гэрээний 8 зүйлийн дагуу Гэрээлэгчийн хуваарьт түүхий тос хэмжээт хийсэн цэг дээр Гэрээлэгчийн мэдэлд шилжинэ.

15.3 ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оролцох эрх, үүргээ Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр бусдад шилжүүлж болно.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР, ХУРААМЖ БОЛОН ТӨЛБӨР

Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагаа явуулахтай холбогдсон татвар, хураамж, төлбөр нь Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актуудын дагуу зохицуулагдана. Гэрээлэгч нь Монгол Улсын аливаа хуульд болон энэхүү гэрээнд заагаагүй төлбөр, хураамжийг төлөмгүй.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ. ВАЛЮТ СОЛЛЦООНЫ ЭРХ

17.1 ГАДААД ВАЛЮТ

Гадаад валютыг худалдах буюу худалдан авахад Монгол Банкнаас тогтоосон тухайн өдрийн албан ханшаар тооцно.

17.2 ГАДААДЫН БАНКИНДАХЬ ДАНС

Гэрээлэгч Монгол Улсад болон хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютын данс нээх, гүйлгээ хийх, мөнгөн хөрөнгийг гадаадад гаргах ба чөлөөтэй ашиглах, хадгалах бүрэн эрхтэй болно.

17.3 ВАЛЮТ СОЛНХ ЭРХ

Гэрээлэгч нь валют солих дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- а) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бүхий л хөрөнгийг чөлөөтэй мөрвөх валютаар гаргаж, эдгээр валютыг 17.1-д заасан ханшаар Монгол Улсын ирилжааны банкаар дамжуулан төгрөгөөр солих;
- б) Хилийн чанадад мөнгөн хөрөнгөтэй байж, үүнийг чөлөөтэй зарцуулах;
- в) Өөрт ногдох гэрээт түүхий тосыг экспортолох, худалдах буюу солих замаар хилийн чанадад олсон бүх орлогоо гадаадад байлгах, чөлөөтэй зарцуулах;
- г) Өөрт ногдох гэрээт түүхий тосыг худалдах, солих, экспортолох замаар Монгол Улсад олсон бүх орлогоо гадаадад гаргах буюу чөлөөтэй зарцуулах;
- д) Энэ гэрээний дагуу Монгол Улсад төлөх төлбөр, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бусад төлбөрийг гүйцэтгэхийн тулд Гэрээлэгчийн сонгож авсан Монгол Улсын банкинд данстай байх.

17.4 ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР

Гэрээлэгч тал энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөрийг АНУ-ын доллараар хийнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСАД

18.1 МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСДЫГ СОНГОХ ТУХАЙ

Гэрээлэгч ба түүний туслан гүйцэтгэгчид нь:

- а) Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санал болгож буй үнэ, мэргэжлийн чадвар болон чанар нь Гэрээлэгчийн шаардлагыг хангаж байгаа нөхцөлд юуны өмнө монголын Туслан гүйцэтгэгчийг сонгох ба Туслан гүйцэтгэгчтэй Гэрээ байгуулахын өмнө Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид танилцуулж, тохиролцоно.
- б) Монгол Улсад үйлдвэрлэсэн материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон өргөн хэрэглээний барааны үнэ, чөлөөтэй зөвхөн ийлүүлэх хугацаанд нь гадаадаас авч болох

материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, өргөн хэрэглээний бараатай жишиж болох нөхцөлд Монголд үйлдвэрлэсэн зүйлийг сонгоно.

- в) Ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа юуны өмнө зохих ёсны мэргэжилтэй монголын иргэдийг сонгож авахыг эрмэлзэнэ. Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хувь хэмжээнд багтаан эрх бүхий газраас зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр Гэрээлэгч нь нарийн мэргэжлийн ажлын байр, чухал албан тушаалд гадаадын ажиллагсдыг ажиллуулах эрхтэй. Гэрээлэгч нь Монгол Улсын Туслал гүйцэтгэгчийг сонгох. Монголд үйлдвэрлэсэн бараа, материал худалдан авах, Монгол Улсын ажиллагсдыг авч ажиллуулахын тулд Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүсч болох ба энэ зүйлийн дагуу Гэрээлэгчийн хүлээх үүрэг, нөхцлийг Засгийн газрын төлөөлөгчөөс Гэрээлэгчид урьдчилан мэдэгдсэн байхыг үзсэн зөвшөөрөв. Гэрээлэгч нь гэрээний дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж яваад үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа түр буюу бүрмөсөн алдсан тохиолдолд ажиллагсдал хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу толно.
- г) Ажиллах хүчний талаарх бүхий л асуудлыг Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- д) Гэрээлэгч нь Монгол Улсын газрын тосны мэргэжилтэй боловсон хүчинг ажиллуулахдаа Гэрээлэгчийн гадаадаас авч ажиллуулж буй ижил мэргэжил, боловсрол, ур чадвартай гадаадын мэргэжилтэн боловсон хүчний цалингийн дунджаас доошгүйгээр цалинжуулна.
- е) Гэрээлэгч нь өөрийн зардлаар Монгол Улсын иргэдийг сургах, дадлага хийлгэх замаар газрын тосны аж үйлдвэрийн бүх шатны боловсон хүчин бэлтгэхийг эрхэмлэнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ОНЦ БАЙДАЛ

19.1 ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БОЛОХ ОНЦ БАЙДАЛ

Онц байдал тохиолдоход Гэрээлэгч шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээг авах ба энэ тухай Засгийн газрын төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ.

19.2 ОНЦ БАЙДАЛ

- а) Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт онц байдал зарласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нь Гэрээт талбайгаас олборлох Гэрээлэгчийн хуваарьт тосыг нөхөн төлөх нөхцөлтэйгээр бүхлээр нь буюу хэсэгчлэн дайчлан авч болох бөгөөд олборлолтыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг Гэрээлэгчээс шаардаж болно. Талууд олборлолтын дээд хэмжээг харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.
- б) Газрын тосыг ийнхүү дайчлан авах тухай асуудлаар саналаа илэрхийлэх боломжийг Гэрээлэгчид олгоно.

- в) Газрын тосны ноц буюу түүнтэй холбогдох аливаа байгууламжийг дайчлан авах шийдвэр нь Монгол Улсын хуулийн дагуу Гэрээлэгчид зохих ёсоор мэдэгдэсний үндсэн дээр явагдах ба онц байдлыг зогсоох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 20.1 Давагдашгүй хүчин зүйл гэж гонд халдварт өвчний тархалт, дайн, үймгэн, самуун, бослого хөдөлгөөн, ажил хаялт, гал түймэр, үер, хүчтэй салхи, шуурга, газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт үзэгдлийг ойлгоно.
- 20.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээлэгч нь ямар нэгэн үүргээ биелүүлэггүй, гэрээнд заасан ямар нэгэн эрхээ эдэлж чадаагүй бол үйл ажиллагаагаа сэргээж үргэлжлүүлэх, эхлүүлэхэд шаардагдах үндэслэлтэй хугацааг нэмж, гэрээнд заасан болон тухайн Хайгуул, Олборлолтын үе дээр Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрснөөр нэмж тооцож болно.
- 20.3 Хэрэв нэг буюу түүнээс дээш үр ашигтай нээлтээс олборлож байсан буюу олборлож болох байсан газрын тосны үйлдвэрлэлийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас зогсоосон, хязгаарласан бол олборлож болох байсан хэмжээнд хүргэхийн тулд шаардагдах хугацааг 5 дугаар зүйлд заасан хугацаанд дээр нэмж тооцно. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн "хэмжээ" гэсэн ойлголт нь олборлолтын үйл ажиллагааг зогсоогоогүй тохиолдолд үр ашигтай нээлийн хүрээнд өрөмдсөн цоонуудаас олборлолтын төлөвлөгөөний дагуу олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн практикийн дагуу олборлож болох байсан газрын тосны нийт хэмжээг хэлнэ. Гэрээлэгч нь энд заасан олборлох ёстой газрын тосны нийт хэмжээний тухай Засгийн газрын төлөөлөгчид Хуанлийн жил бүрийн дараа ер (90) хоногийн дотор мэдэгдэж байна.
- 20.4 Гэрээлэгч нь 20 дугаар зүйлд заасан давагдашгүй хүчин зүйл тохиолдсон өдрөөс эхлэн 30 хоногийн дотор Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид эрх бүхий байгууллагаар нотлуулсан нотолгоог гаргаж өгнө.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 21.1 Хэрэв энэ гэрээнд гарын үсэг зурсны дараа (нэг зуун наяд) 180 хоногийн дотор гэрээ хүчин төгөлдөр болохгүй бол Гэрээлэгч нь ГТГ-г гэрээг цуцлах тухай мэдэгдэж болно.
- 21.2 Хэрэв Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш (нэг зуун хорь) 120 хоногийн дотор хайгуулын хөтөлбөрт ажлаа эхлээгүй бол ГТГ нь энэ гэрээг цуцална.
- 21.3 Хэрэв Гэрээлэгч энэ Гэрээг санаатайгаар зөрчсөн, уг зөрчлийг арилгах талаар Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчөөс тогтоосон хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй, мөн Гэрээ хэрэгжүүлэх үүднээс хөтөлбөрт болон төсөвт ажлаа эхлээгүй бол Монгол Улсын Засгийн газар өөрийн төлөөлөгчийн саналын дагуу энэ Гэрээг цуцлах эрхтэй болно.
- 21.4 Хэрэв Монгол Улсын Засгийн газар 21.2, 21.3 зүйлийн дагуу эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэвэл Засгийн газрын төлөөлөгчид Гэрээлэгчид бичгээр

мэдэгдэл өгнө. Мэдэгдэл өгснөөс хойш 30 хоногийн дотор Гэрээлэгч нь дээрх зөрчлийг арилгаагүй буюу арилгаж эхлээгүй ба зөрчлийг арилахад нь давагдашгүй хүчин зүйл саад болоогүй, тасалдуулаагүй бол энэ гэрээг цуцлах шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч гаргана. Ийм шийдвэрийн эерэг Гэрээлэгч нь 22 дугаар зүйл дэх арбитрийн тухай заалтыг ашиглах эрхтэй. Гэрээг цуцалсан тохиолдолд Гэрээлэгч нь тухайн гэрээг жинд хийгээгүй ажлынхаа голборийг ГТГ-т толно.

- 21.5 Гэрээг цуцалсны дараа Гэрээлэгч нь 15.1-д зааснаас бусад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа хэрэглэхээр түрээсэлсэн буюу өөрийн бүрэн эзэмшлийн зооворлож болох бүх эд хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргах эрхтэй.
- 21.6 Гэрээлэгч нь дараах тохиолдолд энэхүү гэрээг цуцлах эрхтэй ба энэ тухайгаа Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид 90 (ер) хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Үүнд:

- а) Гэрээг талбайд эдийн засгийн үр ашигтай газрын тос илрээгүй бол,
б) Олборлолтын хугацаа дууссан бол.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 22.1 Гэрээнд оролцогч талуудын хооронд уг гэрээний заалттай холбогдон гарах (түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх, хугацаа дуусах, цуцлах эсвэл сунгах) аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлээгүй бол маргааныг Монгол Улсын арбитраар шийдвэрлүүлнэ.
- 22.2 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүссэн эд хөрөнгийн маргааныг газрын тосны тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэнэ.
- 22.3 Газрын тосны тухай гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг хүчингүй болгох зэрэг гэрээтэй холбогдох асуудлаар үүссэн маргааныг Талууд хүсвэл НҮБ-ын Олон Улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-ийн дүрмийн дагуу зохицуулан шийдвэрлүүлж болно.
- 22.4 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг дур мэдэн буюу зөвшөөрөлгүй явуулсан бол тухайн эгзээдийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад хэрэглэсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгө, олборлосон бүтээгдэхүүн, орлогыг Монгол Улсын эрх бүхий байгууллага хураан авч улсын орлогод шилжүүлнэ. Харин уг үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй байвал Монгол Улсын хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 22.5 Гэрээлэгч талууд нь энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгууллага, иргэдэд хохирол учруулсан бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцан хариуцна.

15/11

- 22.6 Гэрээлэгч талууд нь гэрээний үүргийг зорчсоноос учирсан хохирлыг гэрээнд буюу Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай тал нь нөхөн төлнө.
- 22.7 Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүрхээр гэрээгээр туслан гүйцэтгэгч сонгосон тохиолдолд тухайн туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны улмаас учирсан бүх хохирлыг Монгол Улсын Засгийн газрын өмнө Гэрээлэгч хариуцна.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ

- 23.1 Гэрээлэгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд:
- а) Тухайн төлөөлөгчийн газарт ажиллаж буй Гэрээлэгчийн төлөөлөгчид болон 23.3 дугаар зүйлд заасан Гэрээлэгчийн удирдах төвд факсаар явуулсан;
 - б) Тухайн төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа Гэрээлэгчийн төлөөлөгчид хүргүүлж, түүнийг хүлээн авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд Гэрээлэгчийн төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс нь хүлээн авсан тухай хариу авсан, мөн мэдэгдлийн хувийг 23.3 дугаар зүйлд заасан Гэрээлэгчийн удирдах төвд факсаар явуулсан байх.
- 23.2 Гэрээлэгчээс Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараахь тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд :
- Мэдэгдлийг Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид факсаар явуулсан;
Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчийн ажлын газарт хүргүүлж, түүнийг хүлээж авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс мэдэгдлийг хүлээн авсан тухай хариу авсан байх зэрэг болно.
- 23.3 Дээрх 23.1 ба 23.2-т заасан мэдэгдлийг дараах хаягаар илгээнэ. Үүнд :
- а) Монгол Улсын Засгийн газар :
Газрын тосны газар
18080 Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг,
Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37,
Утас: (976-11) 631208,
Факс: (976-11) 631239
 - б) Гэрээлэгч :
DWM Петролеум AG
Bahnhofstr. 9
CH-6341 Ваар
Утас: 0041-(0)1-7181030
Факс: 0041-(0)1-7181039
E-Mail: info@dwm-ag.com

Гомас Флотман

- 23.4 Талууд нөгөө талдаа 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр мэдэгдэл хүлээж авах хаягаа өөрчилж болно.
- 23.5 Аль нэг тал нь нөгөө талын мэдэгдлийг хүлээж авахаас татгалзах буюу хүлээж авах боломжгүй тохиолдолд нөгөө талын эрх ашиг ямар нэг байдлаар хохирох ёсгүй.

ХОРИН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДААТГАЛ

- 24.1 Энэхүү гэрээний дагуу Гэрээлэгчийн явуулж буй бүх нийл үйл ажиллагааны хувьд Гэрээлэгч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгуулах үүрэгтэй.
- 24.2 Гэрээлэгч нь өөрийн Туслан гүйцэтгэгчдийг нэгэн адил даатгуулсан байхыг шаардах бөгөөд Гэрээлэгчийн шаардлагатай гэж үзсэн нэмэлт даатгал нь даатгалын гэрчилгээгээр баталгаажуулагдсан байх болно.
- 24.3 Гэрээлэгч болон Туслан гүйцэтгэгч нь эд хөрөнгө, ашиг сонирхлоо Монгол Улсын Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу тус Улсын даатгалын компанид даатгуулна.
- 24.4 Хэрвээ Монгол Улсын даатгалын компани ийм даатгалыг хийх чадваргүй буюу татгалзвал Гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр гадаадын даатгалын компаниар даатгуулж болно.
- 24.5 Даатгалын байгууллага болон Гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд гарсан хохирлыг Монгол Улсын Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ТАВ ДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗААЛТ

25.1 ХАВСРАЛТУУД

Хавсралт А, Б, В, Г - нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.

25.2 ХУУЛЬ

Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжтой нийцсэн байна.

25.3 САЙН САНАА

Талууд энэхүү гэрээний дагуу харилцаагаа сайн санааны зарчимд үндэслэж, нэгдмэл зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж, гарч болох аливаа үл ойлголцол, маргааныг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэхийг эрмэлзэнэ.


25.4 ГЭРЭЭНИЙ ХЭЛ

Гэрээг монгол, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүдийг ийбэрлэнэ. Хоёр тал хоорондоо зөрчилдвөл монгол хэлний хувилбар нь шийдвэрлэх хүчинтэй болно.

25.5 ГЭРЭЭ ХҮЧИН ТОГОЛДОР БОЛОХ, ГЭРЭЭНД НЭМЭЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ

1. Энэхүү гэрээг Монгол Улсын Засгийн газар баталсан өдрийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр гэж үзнэ.
2. Талууд харилцан тохиролцож энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газраар батлуулсанаар хүчин төгөлдөр болно.


ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ТӨЛӨӨЛЖ:



.....

ГТГ-ЫН ДАРГА Д. АМАРСАЙХАН

ГЭРЭЭЛЭГЧ "DWM ПЕТРОЛЕУМ
AG" ИЙГ ТӨЛӨӨЛЖ:



.....

АЛЕКСАНДР БЕККЕР



ЦАГААН ЭЛС - XIII ТАЛБАЙН ТАЛААР
 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
 "DWM ПЕТРОЛИУМ АГ" -ИЙН
 ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
 ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ГЭРЭЭТ ТАЛБАЙ

ХАВСРАЛТ "А"

Энэжүү хавсралт "А" нь Газрын тосны газар, "DWM Петролиум АГ" -ийн хооронд 2009 оны 04 дугаар сарын 21 - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭТ ТАЛБАЙН ЗУРАГ



ЦАГААН ЭЛС - XIII ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
"DWM ПЕТРОЛИУМ АГ" -ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ "Б"

ГЭРЭЭГ ТАЛБАЙ

Энэхүү хавсралт "Б" нь Газрын тосны газар, "DWM Петролиум АГ" -ийн хооронд 2009 оны 04 дугаар сарын 21 - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭГ ТАЛБАЙН БАЙРЛАЛ

1. Талбайн нэр
2. Талбайн хэмжээ
3. Сэлбилцөлийн цэг

Цагаан Элс - XIII
11590 кв.км.

| Дугаар | Уртраг | Өргөрөг |
|--------|------------|-----------|
| 1 | 108°19'59" | 43°50'00" |
| 2 | 108°19'59" | 44°10'00" |
| 3 | 108°29'59" | 44°10'00" |
| 4 | 108°29'59" | 44°30'00" |
| 5 | 108°49'59" | 44°30'00" |
| 6 | 108°49'59" | 44°40'00" |
| 7 | 109°29'59" | 44°40'00" |
| 8 | 109°29'59" | 44°35'00" |
| 9 | 109°20'00" | 44°35'00" |
| 10 | 109°20'00" | 44°10'00" |
| 11 | 109°40'00" | 44°10'00" |
| 12 | 109°40'00" | 43°55'00" |
| 13 | 110°00'00" | 43°55'00" |
| 14 | 110°00'00" | 44°10'00" |
| 15 | 110°10'00" | 44°10'00" |
| 16 | 110°10'00" | 44°20'00" |
| 17 | 111°00'00" | 44°20'00" |
| 18 | 111°00'00" | 43°50'00" |

**ЦАГААН ӨЛС-ХИИ ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ**

(-) Хасах

ХАВСРАЛТ “В”

**ГЭРЭЭТ ТАВАН ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,
ЗААВАЛ ХИЙХ НААД ЗАХЫН АЖИЛ, ҮҮРЭГ.**

| Үе Шан | Гэрэл Жил | Хайгуулын Ажлын Төлөвлөгөө | Зардал | Жилийн Хөрөнгө Оруулалт |
|--|--------------|---|-----------|-------------------------------|
| I | 1 | Геологийн мэдээлэл цуглуулах | 150,000 | 625,000 |
| | | Газарууны геологийн судалгааны төсөл 4000 кв.км | 40,000 | |
| | | Геологийн Зураглал 500 кв.км | 50,000 | |
| | | Геологийн Зураглал 100 кв.км | 30,000 | |
| | | Геологийн бүтэц тодорхойлох 400 кв.км | 140,000 | |
| | | Литолог бүтэц тодорхойлох 1900м | 95,000 | |
| | | Палентологийн бүтэц тодорхойлолт | 40,000 | |
| | | Дээжлэл 300 | 15,000 | |
| | | Лабораторийн судалгааны ажил | 35,000 | |
| | | Мэдээлэл тайлал | 30,000 | |
| II | 2 | Геологийн Зураглал 850 кв.км | 85,000 | 825,000 |
| | | Геологийн Зураглал 400 кв.км | 120,000 | |
| | | Литолог бүтэц тодорхойлох 3200м | 160,000 | |
| | | Палентологийн бүтэц тодорхойлолт | 80,000 | |
| | | Дээжлэл 800 | 40,000 | |
| | | Лабораторийн судалгааны ажил | 75,000 | |
| | 3 | Тайлан боловсруулалт | 55,000 | 1,740,000 |
| | | Тайлан боловсруулалт | 15,000 | |
| | | Байр зүйн зураглал | 50,000 | |
| | | 2D чичирхийллийн судалгаа, 200 кв.км | 1,600,000 | |
| III | 4 | 3D чичирхийллийн судалгаа, 5 кв.км | 75,000 | 4,360,000 |
| | | Тайлан боловсруулалт | 40,000 | |
| | | Байр зүйн зураглал | 20,000 | |
| | | 2D чичирхийллийн судалгаа, 100 кв.км | 800,000 | |
| | | 3D чичирхийллийн судалгаа, 20 кв.км | 300,000 | |
| | | Өрөмдлөгийн бэлтгэл ажил, 1 цооног | 30,000 | |
| | | Цооног өрөмдөлт, 1 цооног | 2,870,000 | |
| Цооногийн геофизикийн судалгаа, 1 цооног | 300,000 | | | |
| III | 5 | Тайлан боловсруулалт | 50,000 | 6,900,000 |
| | | Өрөмдлөгийн бэлтгэл ажил, 2 цооног | 60,000 | |
| | | Цооног өрөмдөлт, 2 цооног | 5,740,000 | |
| | | Цооногийн геофизикийн судалгаа, 1 цооног | 600,000 | |
| | | Цооногийн туршилт үйлчилгээ, 3 цооног | 450,000 | |
| TOTAL | | | | 14,450,000 |

ЦАГААН ЭЛС-ХИШ ТАЛБАЙН ТАЛААР
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,
“DWM ПЕТРОЛЕУМ АГ”-НИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ “Г”

БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРАМ

НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ

ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

1. НЭР ТОМЬЁО

2009 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2 дугаар зүйлд тодорхойлсон нэр томьёонууд энэхүү Бүртгэл тооцооны журамд хамаарах бөгөөд адилутга агуулна.

2. БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРМЫН ЗОРИЛГО БОЛОН
БАРИМТ БИЧГИЙН ДАВАМГАЙЛАХ БАЙДАЛ

Гэрээний дагуу зарцуулсан зардал, эд хөрөнгийн өртгийг үнэн зөв тооцоолох аргыг тодорхойлоход бүртгэл тооцооны журмын зорилго нь оршино. Хэрэв энэхүү арга нь ГТГ буюу Гэрээлэгчийн хувьд шударга бус, зохисгүй байна гэж үзвэл талууд тохиролцон зохих өөрчлөлтүүдийг оруулна.

Энэхүү бүртгэл тооцооны журмын заалтууд гэрээний заалттай үл тохирох буюу зөрчилдөх аливаа тохиолдолд олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийгмэл зарчмыг баримтлана.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГУУД

- а) Гэрээлэгч нь ГТГ-т хайгуулын ажлын туршид хуанлийн улирал бүрийн эцсээс хойш гуч (30) хоногийн дотор дараах тайлангуудыг шилжүүлнэ. Үүнд:
1. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;
 2. орлого зарлагын тайлан;
- б) Олборлолтын үед Гэрээлэгч нь ГТГ-т хуанлийн улирал бүрийг дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор дараах тайлангуудыг гаргаж өгнө. Үүнд:
1. олборлолтын тайлан;
 2. олборлолтын үнэлгээний тайлан;
 3. зардал тус бүрээр гаргасан өртөг нөхөлтийн тайлан;
 4. орлого зарлагын тайлан;
 5. хуваах тус ба ашигт тосны тайлан;
 6. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;

Дээрх тайлангуудыг хуримтлагдсан дүнгээр бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн олонүзлэлийн стандарт болон энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу хийж, тайлант жил дууссаны дараа жар (60) хоногийн дотор ГТГ-г гаргаж өгнө.

4. САИХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- а) Гэрээний 13 дугаар зүйлийн дагуу шалгалт хийхдээ, Засгийн газрын төлөөлөгч нь өртөгт тосоор нөхөгдөх зардал, Гэрээлэгчийн санхүүгийн данс, дансны бичилт, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа торлийн гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, бусад баримт бичиг, бичилтүүд зэрэг газрын тосны үйл ажиллагааны талаарх бүхий л төлбөр тооцоог жил бүр шалгах эрхтэй. Түүнчлэн, Засгийн газрын төлөөлөгч нь тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад газар орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторт очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- б) Гэрээлэгчийн бүх баримт бичиг нь тэдгээрийн үүсэн байгуулагдсан өдрөөс хойш таван (5) жил эсхүл хуульд заасан журмын дагуу шаардагдах хугацаанд хадгалагдаж, шалгуулахад бэлэн байна.

5. ВАЛЮТ СОЛИХ

Гэрээлэгчийн газрын тостой холбогдох үйл ажиллагааны бүртгэл нь АНУ-ын доллараар хийгдэнэ. АНУ-ын доллараар гарсан бүх зардал нь зарцуулсан тоо хэмжээгээрээ бүртгэгдэнэ. Монгол улсын мөнгөн нэгжээр гаргасан зардлыг гэрээний 17 дугаар зүйлд заасны дагуу АНУ-ын долларт шилжүүлж, АНУ-ын доллараас бусад мөнгөн нэгжээр гарсан зардал нь тухайн валютыг Гэрээлэгчийн АНУ-ын долларын данснаас худалдан авсан тохиолдолд худалдан авсан үгээр АНУ-ын долларт шилжүүлэгдэх ба үүнээс бусад тохиолдолд Монгол Банкны албан ханшаар тооцно.

Монгол төгрөг болон АНУ-ын доллараас бусад валютыг АНУ-ын долларт шилжүүлсэн ханшаар бүртгэл хөтөлнө.

6. БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь бүртгэлийг Англи хэл дээр нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө.

7. БҮРТГЭЛИЙН ЖУРМЫГ ХЯНАХ

Энэхүү Бүртгэлийн журмыг Гэрээлэгч, ГТГ хоёр бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр ирээдүйн үйл ажиллагааг зохицуулахаар Засгийн газрын төлөөлөгч нь хянан шалгаж болно.

8. БҮРТГЭЛИЙН ЦАРИЙВЧИЛСАН АРГАЧЛАЛ

Гэрээлэгчийн төлөөлөр болсон өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч нь Гэрээ болон энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу боловсруулсан дансны гүйцэтгэлийг

бүдүүвч, зардлын нарийвчилсан ангилал, баримтлагдах зардлын товийн нарийвчлан тодорхойлсон хэлбэр, үйл ажиллагааны бичлэг болон бүртгэлийн аргачлалын талаарх саналыг ГТГ-г ирүүлж хэлэлцэнэ. Энэхүү аргачлалыг санхүүгийн нийтлэг бүртгэл, олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд хэвлэсэн зарчим, Монгол Улсын хууль, журмын дагуу боловсруулна. Ийнхүү хэлэлцээний дагуу Засгийн Газрын төлөөлөгчийн зөвшөөрснөөр Гэрээлэгч нь цаашид ашиглагдах дансны гүйлгээний бүдүүвч, зааварчаагыг боловсруулж ГТГ-г гаргаж огно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ ЗАРДАЛ, ОРЛОГО

1. НӨХӨН ТӨЛӨГДӨХ ЗАРДАЛ

Гэрээлэгч нь Гэрээний дагуу дараах зардлуудыг харинаж шууд төлөх бөгөөд эдгээр зардлуудыг Гэрээний 4 дүгээр зүйлийн дагуу ангилж, нөхөн авна.

а) Газрын эрх

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах барилга байгууламж барих талбайн эрх авахтай холбогдон гарсан зардал

б) Хөдөлмөр эрхлэлт

1. Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй ажиллагсдын цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, томилолт, хөдөлмөрийн чадвар түр алдах, тахир дутуугийн нөхөн олговорууд.
2. Гэрээлэгчийн Монголд ажиллахаар томилогдсон галаадын иргэдийн амьжиргааны, орон байрны болон бусад хөнгөлөлтүүд.
3. Засгийн газрын байгууллагаас хуулийн дагуу Гэрээлэгчийн ажиллагсдын цалин хөлсөнд хамааруулж ногдуулж буй хураамжтай холбогдсон зардлууд.

в) Ажиллагсдад үзүүлэх хөнгөлөлт, олгох тэтгэвэр, тэтгэмж

Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй гадаад болон монгол ажиллагсдын цалин хөлсөнд хамаарагдах ажиллагсдын амь нас болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдон гарах зардал.

Энэтг халагдсаны тэтгэмж монгол болон гадаад улсын ажиллагсдын хувьд адил байх бөгөөд тэтгэмжийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу зохицуулна.

г) Материал, тоног төхөөрөмж ба сэлбэг хэрэгсэл

Гэрээлэгчийн худалдаж авсан, түрээслэсэн буюу нийлүүлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл.

1. Худалдаж авсан материал

Гэрээлэгчийн худалдаж авсан материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардлыг тооцоход Гэрээлэгчид үзүүлсэн бүх хөнгөлөлтийг нь хасаад түүний жинхэнэ төлсөн үнийг энэхүү журмын 2 дугаар зүйлийн 3.1-г заасан үнэлгээний зарчмын дагуу тогтооно.

2. Гэрээлэгч буюу салбар байгууллагаас нийлүүлсэн материал

Гэрээлэгч нь аливаа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн өөрийн буюу салбар байгууллагынхаа ноцтоос авч нийлүүлэхээс бусад тохиолдолд Монголын иргэн, аж ахуйн нэгжээс худалдаж авна. Гэхдээ дээр дурдсан

нөөцөөс нийлүүлсэн материалын үнэ нь даатгал, нийлүүлэгчийн адил нөхцөлд гуравдахь этгээдээ тосгоотой эд зүйлийг худалдаж авч болох үнээс өндөр байх ёсгүй. Уг материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнэлгээг энэхүү журмын 2 дугаар зүйлийн 3.2-г заасны дагуу тогтооно.

3. Баталгаа

Гэрээлэгч нийлүүлж буй материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлдээ үйлдвэрлэгчийн буюу худалдагчийн чанарын баталгаанаас оор ямар нэгэн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд хэрэв нийлүүлсэн материал гэмтэл согогтой байвал үйлдвэрлэгч буюу худалдагчаас Гэрээлэгчид зорүүт нөхөн төлөх хүргэл үүнийг орлогол авахгүй.

4. Түрээс

Түрээсэлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнийг бодитой төлсөн үнээр тооцно.

д) Тээвэрлэлт

Газрын тосгой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг тээвэрлэхэд гарсан зардал

е) Үйлчилгээ

1. Гэрээлэгч нь гуравдагч этгээдээ зөвлөх, гэрээг үйлчилгээ болон хангамжаар үйлчлүүлэхтэй холбогдсон зардлын зөвшөөрлийг ГТГ-аас урьдчилан бичгээр авна. Уг зардал нь ижил төстэй ажил, үйлчилгээ үзүүлэх гадаадын болон Монголын байгууллагад төлөх зардалтай ойролцоо байна.

2. Гэрээлэгч болон түүний салбар байгууллагаас Монголд болон хилийн чанадад лабораторийн шинжилгээ хийх, загварчлах, геологи, геофизикийн боловсруулалт, тайлал хийх, инженерийн болон мэдээлэл боловсруулах зэрэг үйлчилгээний зардал нь тухайн үед олон улсын газрын тосны аж үйлдвэрт дагаж буй үнэлгээтэй дүйцэхүйц байна.

Гэрээлэгч буюу түүний салбар байгууллагаас үзүүлсэн үйлчилгээ нь ашиг нэмэлгүйгээр зарцуулсан зардлаар тооцогдоно. Уг зардал нь тухайн үйлчилгээг ижил нөхцөлөөр гүйцэтгэх бусад салбар байгууллага, гуравдагч этгээдэд гарах хэвийн зардлаас илүүгүй байна.

Шаардлагатай бол, тухайн үйлчилгээ, түүнийг зохион байгуулсаны зардал зэргийг баталсан баримтыг Гэрээлэгч, түүний салбар байгууллага, ГТГ-аар гаргуулан авна.

Гэрээлэгч, түүний салбар байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний зардал нь олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд газрын тосны компаниуд тэдгээрийн салбар байгууллагуудад төстэй үйлчилгээ үзүүлсний төлбөрт төлдөг зардлаас өндөр өртөгтэй бол тухайн зардлыг ГТГ нь энэхүү журмын 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хамааруулж өртөг нөхөлтөөс хасах эрх эдэлнэ.

ж) Хохирол болон алдагдал

Доорхи з) бүлгийн дагуу даатгалд хамрагдахаас бусад тохиолдолд газар хөдлөлт, гал түймэр, үер, шуурга, хулгай, осол буюу бусад Гэрээлэгчээс хамаарахгүй шалтгааны улмаас учирсан хохирол, алдагдлыг нөхөн сэргээхэд гарах бүхий л зардал, Гэрээлэгч нь хохирол болон алдагдалд орсон тухайгаа нийлэггүй ГТГ-г бичгээр мэдэгдэнэ.

з) Даатгалын зардал

Гэрээний 24 дүгээр зүйлд заасанчлан даатгалын компанитай байгуулсан гэрээний дагуу төлсөн даатгалын зардлын өртөг нөхөлтийн тооцоонд оруулна.

и) Хэргийн анги, агуулах болон бусад байгууламж

Хэргийн ангиуд, агуулахууд, тэвэрлэлтийн болон холбооны систем, усан хамгааж, зам болон бусад байгууламжуудийг хадгалж хамгаалах, тоноглох, ажилдуулахтай холбогдон Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор гарч буй зардал.

к) Эрх зүйн зардал

Гэрээт галбай, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг хамгаалах, шүүх хурлын буюу хууль зүйн туслалцаа авсан, үүний дотор омгөөлөгчийн хөлө, шагнал, зөвлөхийн цалин хөлөний тодорхой хувь, мөн Гэрээний дагуух газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар талууд болон аль нэгний нь эсрэг шийдвэр гарсангай холбоотой зардал, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа буюу энэ гэрээний эсрэг чиглэсэн аливаа үйлдэл, гомдол, заргаас хамгаалах зорилгоор гэрээнд оролцогч талууд буюу аль нэг тал нь урьдчилан сэргийлэхээр авсан арга хэмжээний зардууд. Дээр дурдсан арга хэмжээг гэрээнд оролцогч талууд буюу аль нэгнийх нь хуулинд хэрэгжүүлсэн тохолдолд тэдгээрт энэхүү үйлчилгээ үзүүлсний зөмх хэмжээний мөнгө төлнө.

л) Захиргааны зардал

1. Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС-1-ийн 82)-д заасны дагуу борлуулалт өртгийн аргад хамааралтай харууллагын төвөөр нь ангилдаг аргаар удирдлагын зардлыг тусад нь бүртгэнэ. Энэ зардалд Гэрээлэгчийн Монголд буюу гадаад дахь ерөнхий удирдлага (үүний дотор хувьцаа эзэмшигчид багтана / хянах, зөвлөх, үйлчлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнуудтай холбоотой гарсан зардлуудыг бүртгэнэ. Үүнд: Цалин хөлө, амралтын нөхөн олговор, нэмэгдэл урамшуулал, хуулийн дагуу буюу Засгийн газрын харьяа байгууллагаас ногдуулсан татвар хураамж, шимтгэл, удирдлагын байрлаж буй албан контор болон техник хэрэгсэл, тавилга, эд хогшил худалдан авах, түрээс, ашиглалтын зардал, шатахуун, томиллолт сургалт зэрэг зардлуудыг оруулна. Гэрээний дагуу дээр дурдсан газрын тостой холбогдсон удирдлагын үйл ажиллагааны зардал нь газрын тостой холбогдсон гэрээлэгчийн жилийн зардлын 5 хувиас хэтрэхгүй байна. Захиргааны зардлын бусад зардалд давхардуулан тооцохгүй.

2. Дээр дурдсан захиргааны зардлыг бусад (энэ зүйлийн 1.а-к хүртэлх) зардалд давхардуулан тооцохгүй.

2. ОРЛОГО

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцаас орсон орлогыг зохих дансанд бүртгэж авна. Уг орлого нь дараах ажил гүйлгээнээс бүрдэнэ:

а) Гомдол заргаас авсан орлого

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх зарга, даатгалын орлого буюу хөрөнгө.

б) Гуравдагч талын орлого

Омч хөрөнгө ашигдуулсны, Гэрээлэгчээс үзүүлсэн үйлчилгээний буюу аливаа мэдээллийн төлбөр хэлбэрээр гуравдагч талаас олсон орлого.

в) Хүргээ бичилт

Өмнө нь дансанд бүртгэгдсэн гэмтэл согогтой материал, тоног төхөөрөмжид гүүний нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс Гэрээлэгчид буцаан олгосон нөхөн олговор.

г) Буцааж төлсөн төлбөр

Өмнө нь дансанд бүртгэгдсэн байсан зардлаас Гэрээлэгчид буцаан төлсөн түрээс, нөхөн төлбөр буюу бусад орлого.

д) Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг худалдах, экспортлох

Энэхүү гэрээнд тусгайлан заагаагүй бол Гэрээлэгч дансанд бүртгэлтэй байсан аливаа эд материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг салбар байгууллага, эсвэл бусад байгууллага, хувь хүнд худалдах, экспортлох буюу шилжүүлэх тохиолдолд уг шилжүүлгийн дүн бүртгэлд тусгагдсан байна.

3. ЭД МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 1(г)-д заасны дагуу дансанд бүртгэлтэй эсвэл 2(д)-д зааснаар бүртгэлд тусгагдсан материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэлгээ дорх зарчмаар хийгдэнэ. Үүнд:

1. Доорх (3.2) зүйлд өөрөөр заагаагүй бол Гэрээлэгчийн худалдан авсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэ нь эдгээртэй адил чанарын барааны олон улсын зах зээл дэх үнэ, худалдан авах хэлэлцээр байгуулсан тухайн үед олон улсын зах зээлд давамгайлж байсан нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигтэй тохирч байх ёстой. Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн худалдан авах үнэ нь зохих тохиолдолд худалдааны болон бэлэн мөнгөний хямдралууд, нийлүүлэлтийн төлбөр, тээврийн болон хүргэх зардал, даатгал, татвар, гаалийн татвар, консулын төлбөрүүд болон бусад импортын бараанд ногдуулах төлбөрүүдийг урьд өмнө өөр тооцоонд оруулсан эсэхийг харгалзан үзэж хамруулна.
2. Салбар байгууллагуудаас худалдан авсан болон тэдэнд худалдсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг доорх (а), (б)-д заасны дагуу үнэлнэ.
 - а) Шинэ эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь (А ангилал) Гэрээлэгчийн гэрээ байгуулах үеийн адил чанарын барааны олон улсын зах зээлийн үнэ, нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигт нийцэж байх.
 - б) Хэрэглэж байсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд (Б, В ангилал).
 - i) Эвдрэлгүй, гэмтэлгүй, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглаж байгаа засвар үйлчилгээ шаардагдахгүй ашиглах боломжтой түүхий эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь Б ангилалд хамрах бөгөөд дээрх (а)-д тодорхойлсон шинэ материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн 75 хувиар (75%) үнэлэгдэнэ.
 - ii) Б ангилалд хамруулах боломжгүй материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд, гэхдээ:
 - ♦ засвар үйлчилгээний дараа үндсэн зориулалтаар нь Б ангилалын дагуу хэрэглэж байсан боловч сайн эд материал, тоног төхөөрөмж

болон сэлбэг хэрэгслүүдийн ашиг дахин ашиглах боломжтой;
эсвэл

* Үндсэн зориулалтаараа ашиглагдах боломжтой боловч ерөнхийдөө засвар үйлчилгээ хийх боломжгүй эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь В ангилалд орох бөгөөд дээрх (а)-д тодорхойлсон шинэ эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн тавны хувиар (50%) үнэлэгдэнэ. В ангиллын эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнэ засвар үйлчилгээний өртөг нийлээд Б ангиллын эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнээс хэтрэхгүй байх нөхцөлд, засвар үйлчилгээний үнэ өртийг засварлагдсан эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдэд оруулна.Б. В ангилалд орохгүй эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийг хэрэглээтэй нь уялдуулж үнэлнэ.

ix) Эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн Газрын тосны үйл ажиллагаанд түр ашигласнаар 2)б)ii)-д заасны дагуу хямдруулах боломжгүй нөхцөлд эдгээр эд материал, тоног тохөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь хийгдсэн үйлчилгээний үнийн дүнтэй нийцэх дансны цэвэр тооцооны дүнд үндэслэн үнэлэгдэх болно.

4. ЗАРДЛЫН ТӨВҮҮД

Гэрээний дагуу нөхөн төлөгдөх зардалд үр дүнтэй хяналт хийх боломжийг хангах зорилгоор бүх зардлуудыг зардлын төвүүд болон тэдний дэд ангилалуудад хуваан ангилж, ГТГ-г танилцуулна.

Нарийвчилсан ангиллыг Хавсралт "Г"-ын 1.8 дугаар зүйлийн дагуу тохиролцоно. Гэхдээ доорх ангилалууд заавал хийгдэнэ. Үүнд:

а) Талбай тус бүрээр зардлууд дараах маягаар хуваарилагдана:

1. Хайгуулын талбай.
2. Олборлолтын талбай нэг бүрчлэн.
3. Дамжуулах хоолой гэх мэт талбайн гадуур үйл ажиллагааны зардал.
4. Тодорхой талбайд хамааруулах боломжгүй зардлууд.
5. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт

б) Газрын тосны үйл ажиллагаа бүрт зардлууд дараах маягаар хуваарилагдана:

i) Хайгуулын үйл ажиллагаа. Үүнд:

1. Агаарын, геологийн, геохимийн, палеонтологийн, топографийн болон бусад судалгаа.
2. Чичирхийлэлийн судалгаа нэг бүрчлэн.
3. Хайгуулын болон үнэлгээний цооног нэг бүрчлэн.
4. Дэд бүтэц (зам, шисэх онгоцны буудал).
5. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний өртөг хуваарилалт өрвө газрын тосны үйл ажиллагаатай холбоотой зардлууд).
6. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.

7. Бусад зардлууд.

ii) Олборлолтын үйл ажиллагаа. Үүнд:

1. Агаарын, геологийн, геохимийн, геофизикийн болон бусад судалгаа.
2. Олборлолтын цооног нэг бүрчлэн.
3. Хуримтлуулах шугамууд.
4. Талбайн байгууламжууд.
5. Хадгалах байгууламжууд.
6. Дамжуулах хоолой, тээврийн цистернууд.
7. Дэд бүтэц.
8. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний ортог хуваарилалт орно (Газрын тосны үйл ажиллагаатай холбогдох зардлууд).
9. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.

iii) Ашиглалтын үйл ажиллагааг олборлолтын үйл ажиллагаатай адил ангилна.

v) Олборлогдож, хадгалагдсан газрын түүхий тос болон байгалийн хийтэй холбогдох зардлыг дараах зарчмыг баримталж хуваарилна. Үүнд:

1. Зардлын дийлэнх хувь нь түүхий газрын тос эсвэл байгалийн хийн аль нэгэнд хамааралтай бол аль нэгэнд нь бүрэн хуваарилна.
2. Зардлыг түүхий тос болон байгалийн хий хоёуланд нь хамааруулах боломжтой тохиолдолд уг зардал нь талуудын харилцан тохиролцсон аргачлалын үндсэн дээр олон улсын газрын тосны аж үйлдвэрийн туршлагын дагуу хуваарилагдана.

5. **НӨХӨН ТӨЛӨГДӨХГҮЙ ЗАРДЛУУД**

Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Үүнд:

- а) Бүртгэл байхгүй болон биет зүйлийн хувьд зөрчилтэй зардлууд.
- б) Холбогдох Ажлын хөтөлбөр, Төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй, эсвэл Гэрээнд зөвшөөрөөгүй ангилалд хамрах зардал.
- в) Осол, гамшгийн улмаас гарсан зардлаас бусад Гэрээлэгчийн худалдан авсан бараа, гүйцэтгүүлсэн болон захиалсан үйлчилгээний үнэ тухайн үеийн адил чанарын бараа үйлчилгээний олон улсын зах зээлийн үнэ, олон улсын зах зээлд давамгайлж буй нийлүүлэлтийн адилхан нөхцөлийн үнийн жишгээс илүү гарсан зардал.
- г) Туслан гүйцэтгэгч болон нийлүүлэгчтэй байгуулсан холбогдох Гэрээтэй үл нийцэх бараа, үйлчилгээний төлбөрүүд.
- д) Дээрх "в" хэсэгт заасны дагуу эд материалын байдал үнэтэйгээ таарахгүй нөхцөлд энэ зөрчилтэй холбогдон гарсан нэмэгдэл зардал.
- е) Газрын тосны үйл ажиллагаанд онцын шаардлагагүй зардал. Үүнд нийлүүлэх цэгээс хойш гарах үйл ажиллагааны, тухайлбал газрын түүхий тосыг Монгол Улсаас гаргахаар ашигласан вагон мэтний тээврийн хэрэгсэлд авсаны дараах зардал.
- ж) Монгол Улсын бусад улсад төлсөн гатвар, хуримтжууд.

- з) Гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу төлөгдох урамшууллауд болон бусад төлбөрүүд.
- и) Шүүгч, Арбитрч буюу шинжээчийн асуудлыг өөрөөр шийдвэрлээгүй бол Гэрээний 22 дугаар зүйлийн дагуу шүүх, арбитражийн болон шинжээчдийн зардал.
- к) Монгол Улсын Шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан хүү, торгууль, авз.
- л) ГТГ-аас бичгээр зөвшөөрөгдөөгүй ажил үйлчилгээ, аливаа хандив тусламж
- н) Газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулсан шингэ тоног төхөөрөмж, материал болон аргачлал, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор судалгаа хийхтэй холбогдон гарсан зардал.
- о) Талбайн дэнчин
- ө) БХГ-ний 7 дугаар зүйлийн "в", "г" заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал
- ү) Зээлийн хүүгийн зардал
- ф) Төлөөлөгчийн газрыг дэмжих зардал
- р) Орон нутгийг дэмжих зардал
- с) Гэрээт талбайд ажил гүйцэтгэсэн боловч холбогдох мэдээлэл, тайлан, баримт материалыг ГТГ-т хүлээлгэн өгөөгүй ажил, үйлчилгээний зардал
- г) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны төрмийг зорчсоноос гарсан зардал

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

ТООЛЛОГО БОЛОН ТООЛЛОГЫН ТАЙЛАН

1. ТОГТМОЛ ТООЛЛОГО ХИЙХ, МЭДЭГДЭХ БОЛОН ТӨЛӨӨЛӨХ

ГТГ болон Гэрээлэгч харилцан тохиролцож тогтоосон зохих хугацаанд Гэрээлэгч үйл ажиллагааны бүх эд материал, биет хөрөнгө болон барилга угсралтын төслүүдийн тооллогыг явуулж байна. Тооллогод ГТГ оролцох боломжийг хангах үүднээс Гэрээлэгч тооллого эхлэхээс гучаас (30) доошгүй хоногийн өмнө тооллого хийх тухай ГТГ-т бичгээр мэдэгдэнэ. Гэрээлэгч жил бүр доод тал нь нэг удаа, мөн Гэрээг цуцлах тохиолдолд тооллого явуулна.

2. ТООЛЛОГЫН БҮРТГЭЛИЙГ ТУЛГАН ШАЛГАЖ, ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

Гэрээлэгч, ГТГ хоёр хамтран эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг тулган шалгаад, илүүдэл буюу дуталтын жагсаалтыг гаргаж, Гэрээлэгч нь зөрүүт залруулна.

3. ТООЛЛОГЫН ТАЙЛАН

- а) Гэрээлэгч нь олон улсын газрын тосны аж үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу газрын тосны үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй эд хөрөнгийн нарийвчилсан бүртгэл хийнэ.
- б) Гэрээлэгч нь доорх зүйлүүдийг агуулсан тооллогын тайланг ГТГ-т удирдлагын тусламж ирүүлнэ. Үүнд:
 - 1. Хянах боломжтой бүх эд хөрөнгө, материалын тодорхойлолт болон үнэ.

2. Эд хоронго тус бүрийн дансанд бүртгэгдсэн үнийн дүн.
3. Эд хоронгийг дансанд бүртгэсэн он, сар, өдөр.
4. Эдгээр эд хоронгийн өртөг Гэрээний 15 дугаар зүйлийн дагуу нөхөгдсөн эсэх.

4. ТЭМДЭГЛЭГЭЭ

Эдгэхүү хавсралт "Г" -ийн 1.8 дугаар зүйлд зааснаар тохиролцсон аргуудын дагуу бүх эд хоронго нь хяналтын үйл ажиллагааг хялбарчлах зохих код буюу тэмдэглэгээтэй байх ёстой.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫГ ХЭМЖИХ БА ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАН

1. Олборлолтын тайлан доорх зарчмуудын дагуу бэлтгэнэ. Үүнд:
 - а) Хуваах тос буюу хий, өртөгт тос буюу өртөг нөхөх хийг Гэрээний VIII, IX зүйлд заасан талбайгаас олборлосон болон хадгалсан нийт түүхий тос буюу нийт хийн хэмжээг үндэслэн тодорхойлно.
 - б) Олборлосон хийгээд нөөцөлсөн түүхий тос болон хийн нийт хэмжээг Олборлолтын талбай дахь ачих цэгт өдөр бүр тодорхойлно. Уг талбайн ачих цэгт олон төрлийн эрэглэл бүхий түүхий тосыг юүлэх бөгөөд ийм түүхий тосны зэрэглэлийг ГТГ, Гэрээлэгчийн хооронд хэлэлцэн тохироогүй бол тус бүрчлэн ангилан тогтооно. Ачих цэг нь Олборлолтын талбайд байх агаад дамжуулах хоолой, төмөр зам, машинаар Олборлолтын талбайгаас тээвэрлэхээс өмнө энэ цэгт түүхий тосыг хэмжиж тодорхойлно.
 - в) Олборлож хадгалсан түүхий тос болон байгалийн хийг өдөр болгон баррелиар бүтээгдэхүүн хуваах цэг дээр, харин ГТГ, Гэрээлэгчийн харилцан тохиролцсон цэгт хэмжих ба тээвэрлэлтийн цэг(үүд)-ээр чанарын хувьд ялгаатай түүхий тос ирж байвал гэрээнд өөрөөр заагаагүй бол хэмжээг нь тусад нь тодорхойлно.
 - г) Түүхий тосны хэмжээг хэвийн температур, даралтад байхад нь тодорхойлох ба агуулах усны хэмжээ, тунамал хурдасны байдлаас шалтгаалан засвар оруулна. Түүхий тосны нягт, хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлолтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байх ёстой.
 - д) Байгалийн хийн хэмжээг хэвийн температур болон даралтад байхад нь тодорхойлно. Дулаан ялгаруулах чадвар (калоринность), хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлолтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байна.
 - е) Газрын тосны үйл ажиллагаанд зарцуулсан түүхий тосны хэмжээг өдөр болгон хэмжиж, бүртгэж байна. Эдгээр нь:
 - I. дахин шахах;
 - II. дахин боловсруулах;
 - III. хайгуул, олборлолтын болон дамжуулах хоолойд шахахад шаардагдах тус мэт талбайн үйл ажиллагааны эрчим хүчний хэрэглээг зарсан.
 - ж) Шаардлагагүй ууршсан түүхий тос, бусад хийг өдөр болгон бүртгэнэ.

3) Түүхий тосны бэлтгэл нөөцийн хэмжээг хуанлийн сар бүрийн эхэн, эцэст хамгийн Стаар нь тооцож тогтоосон байна.

2. Тухайн цооног ба талбайгаас анхны (туршилтын ба эдийн засгийн үр ашигтай) олборлолт эхэлмэгц олборлолтын талбай бүрээр доор заасан мэдээллүүдийг багтаасан олборлолтын тайланг Гэрээлэгч сар бүр гаргаж өгнө. Үүнд:

- а) Олборлож, хадгалсан түүхий тосны хэмжээ
- б) Олборлож, хадгалсан байгалийн хийн хэмжээ
- в) Өрөмдлөг явуулах, олборлох болон хадгалах сав уруу шахахад ашигласан түүхий тосны хэмжээ
- г) Ууршуулсан байгалийн хийн хэмжээ
- д) Сарын эхний түүхий тосны нөөцийн хэмжээ
- е) Сарын эцсийн түүхий тосны нөөцийн хэмжээ
- ё) Борлуулсан түүхий тосны хэмжээ

ТАВДУГААР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭ

1. Гэрээлэгч нь хуанлийн улирал бүр энэхүү Гэрээний дагуу олборлож, нийлүүлэх цэгт борлуулсан түүхий тос, байгалийн хийн үнэлгээг тооцоолсон тайланг бэлтгэх ёстой. Олборлолтын тайлангийн үнэлгээ нь дараах зүйлүүдийг агуулна. Үүнд:

- а) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улирлын турш гуравдагч этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- б) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улирлын турш гуравдагч этгээдээс өөр этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- в) Гэрээний 8-4 зүйл хамаарагдах тохиолдолд түүхий тосны үнэлгээ тогтоох зорилгоор газрын тос экспортологч гол гол орнуудын түүхий тосны үнэлгээний талаарх боломжтой мэдээлэл
- г) ГТГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан борлуулсан байгалийн хийн хэмжээ, үнэ

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

ӨРТӨГ НӨХӨЛТИЙН ТАЙЛАН

1. Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр дорх зүйлүүдийг агуулсан өртөг нөхөлтийн тайлан бэлтгэх ёстой. Үүнд:

- а) Хуанлийн улирлын туршид гарсан нөхөгдөх зардал;
- б) Хуанлийн улиралд нөхөгдөх нийт зардал;

- г) Хуанлийн улирлын туршид Гэрээлэгчийн авсан өртөгт тос ба өртөг нөхөлтийн байгалийн хийн хэмжээ, үнэ;
- д) Хуанлийн улиралд нөхсөн зардлын хэмжээ;
- е) Дараагийн хуанлийн улиралд шилжүүлэн нөхөгдөх зардал;

2. ХЯНАЛТЫН ТАЙЛАНГУУД

Гэрээлэгч нь өртөг нөхөлтийн данс ба тэнцүүлэх сөрөг данс нгээж нөхөгдөх зардлын үлдэж буй хэмжээ, нөхөгдсөн хэмжээг хянах бөгөөд энэ дансны мэдээллийг улирал бүр ГТГ-т гаргаж өгнө.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

ОРЛОГО ЗАРЛАГЫН ТАЙЛАН

Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр орлого зарлагын тайланг гаргаж өгнө. Энэ тайлан нь дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

- а) Энэхүү Бүртгэл тооцооны журамд тохирсон зардлын ангилал ба зардлын төвд үндэслэн, төсөвт тусгах хуанлийн жилийн зардал, орлого;
- б) Энэхүү Гэрээний дагуу нөхөгдөх зардал гэж тогтоосон, тухайн хуанлийн улиралд хуримтлагдсан зардал ба орлого;
- в) Хараахан шийдвэрлээгүй байгаа хуанлийн жилийн хуримтлагдсан зардал ба орлого;
- г) Төсөвт оруулах Гэрээний дагуу зөвшөөрсөн өөрчлөлтүүд;
- д) Жилийн эцсийн хуримтлагдсан зардлын урьдчилсан тооцоо;
- е) Дээрх (г) зүйлийн дагуу засварласан төсөв ба урьдчилсан тооцооны хоорондын ялгаа, тайлбар.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

ХУВААХ ТОС БА АШИГТ ТАЙЛАН МЭДЭЭ

Гэрээлэгч доорх тайлан, мэдээг улирал бүр ГТГ-т ирүүлнэ. Үүнд:

- а) Тухайн улирлын турш олборлосон Түүхий тос;
- б) Тухайн улирлын эцэст олборлосон болон хуримтлагдсан Түүхий тосны хэмжээ;
- в) Тухайн улирлын ГТГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тос;
- г) Тухайн улирлын эцэст ГТГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тосны хуримтлагдсан нийт хэмжээ;
- д) Тухайн улиралд Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хэмжээ;
- е) Тухайн улирлын эцэст Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хуримтлагдсан хэмжээ;